

ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛСАН ИНД-21-ИЙН ХАРЬЦУУЛАЛТ

| <p align="center">Бүтээгдэхүүн, эд ангийн гэрчилгээжүүлэлт (Шинэчлэгдэж байгаа) /64 хуудас/ 2017 оны NZ amend.9</p> | <p align="center">АГААРЫН ХӨЛӨГТ ХАМААРАХ БҮТЭЭГДЭХҮҮН, ЭД АНГИ, ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТ (Хүчинтэй мөрдөгдөж байгаа) /42 хуудас (үндсэн дүрэм-42 хуудастай байсан)/ 1997 оны NZ amend.5</p> | <p align="center">Тайлбар</p> |
|--|---|---|
| <p>АБүлэг-Ерөнхий зүйл</p> | <p>А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ / GENERAL</p> | |
| <p>21.1. Зорилго Энэ Дүрэм нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно: (1)Монгол Улсад үйлдвэрлэх бүтээгдэхүүний маягийн гэрчилгээжүүлэлт; (2)Монгол Улсад импортлох бүтээгдэхүүний маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээжүүлэлт; (3)агаарын хөлгийн НТЧ-ын гэрчилгээжүүлэлт; (4)загварын өөрчлөлт материал, эд анги, процесс, хэрэгсэл, техникийн өгөгдөл болон эрсдэлтэй эд ангид зөвшөөрөл, эсхүл эрх олгох; (5)бүтээгдэхүүн, эрсдэлтэй эд анги, эсхүл хэрэгсэлд экспортын баримт бичиг олгох; (6)бүтээгдэхүүн, эсхүл эрсдэлтэй эд ангийг таньж тогтоох.</p> | <p>21.1. Зорилго/ Purpose (a) Энэ дүрмээр дараах үйл ажиллагааг зохицуулна: 1/ Монгол Улсад үйлдвэрлэх бүтээгдэхүүнд Маягийн гэрчилгээ олгох; 2/ Монгол Улсад импортлох Бүтээгдэхүүний маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээ олгох; 3/ Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлгийн Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох; 4/ онцгой эд анги, нэмэлт тоног төхөөрөмж, материал, техникийн үзүүлэлт, технологийн аргачлал, загварын өөрчлөлт зэргийг баталгаажуулах эсхүл хүлээн зөвшөөрөх; 5/ нэмэлт тоног төхөөрөмж, бүтээгдэхүүн, онцгой эд ангийг экспортлох баримт бичиг олгох; 6/ онцгой эд анги болон бүтээгдэхүүнийг тодорхойлох.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан -“онцгой эд анги” гэснийг “эрсдэлтэй эд анги” гэж өөрчилсөн</p> |
| <p>21.3. Нэр томъёо ба товчлол Энэ Дүрэмтэй холбоотой нэр томъёо болон товчлол нь ИНД-ийн нэр томъёоны тайлбарт багтсан.</p> | | <p>-Нэр томъёоны тайлбар ИНД-1-д орсон</p> |
| <p>21.5. Нөөц</p> | <p>21.5. Нөөц</p> | |
| <p>21.7. Гадаадын байгууллага хүсэлт гаргах Хэрэв Дарга, тухайн гэрчилгээ, зөвшөөрөл, эсхүл эрх олгох зайлшгүй хэрэгцээ байна гэж үзвэл, Монгол Улсын гадна оршин суугаа этгээдийн гэрчилгээ, зөвшөөрөл, эсхүл эрх авах хүсэлтийн дагуу зөвшөөрөл олгож болно.</p> | <p>21.7. Гадаадын иргэн, хуулийн этгээд өргөдөл гаргах/ Overseas applications (a) Гадаадын иргэн, хуулийн этгээд энэ дүрэмд заасан гэрчилгээ, зөвшөөрөл авахтай холбогдсон өргөдлийг Иргэний нисэхийн ерөнхий газар (цаашид ИНЕГ гэх)-ын даргад гаргаж болно.</p> | <p>- Орчуулга, найруулга зассан - “эрх” нь орхигдсон байсныг нэмж оруулсан.</p> |
| <p>21.8. Шаардлагатай загварын өөрчлөлт (a)Дарга ИНД-39-ийн дагуу бүтээгдэхүүний НТЧ-ын удирдамж гаргасан тохиолдолд, бүтээгдэхүүний маягийн гэрчилгээ эзэмшигч нь: (1)хэрэв Дарга тухайн загварын өөрчлөлт нь бүтээгдэхүүний аюултай нөхцөлийг засахад шаардлагатай гэж тогтоосон бол, түүний шаардсан даруйд тохирох загварын өөрчлөлтийн зөвшөөрөл авахаар Даргад хүргүүлнэ; (2)загварын өөрчлөлтийн зөвшөөрөл авсан даруйд тухайн</p> | <p>21.8. Загварын шаардлагатай өөрчлөлт/ Required design changes (a) ИНЕГ-ын дарга ИНД-39-ийн дагуу бүтээгдэхүүнд зориулж НТЧ-ын удирдамж гаргасан тохиолдолд Маягийн гэрчилгээ эзэмшигч нь: 1/ хэрэв ИНЕГ-ын дарга бүтээгдэхүүнд бий болсон аюултай нөхцөлийг арилгахад загварын өөрчлөлт зайлшгүй шаардлагатай гэж тогтоосон бол хийгдэх загварын өөрчлөлтийг батлуулахаар ИНЕГ-ын даргад ирүүлнэ; 2/ загварын өөрчлөлтийг баталсны дараа өөрчлөлттэй</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |

| | | |
|--|--|--|
| <p>өөрчлөлтийг хамарсан тайлбар өгөгдлийг гаргаж тухайн бүтээгдэхүүнийг ашигладаг үйл ажиллагаа эрхлэгч бүр хэрэглэхэд бэлэн байлгана.</p> <p>(b) Хэрэв бүтээгдэхүүнд тухайн цаг хугацаанд аюултай нөхцөл байхгүй боловч, маягийн гэрчилгээнд өөрчлөлт оруулснаар бүтээгдэхүүний аюулгүй байдал сайжрахыг ашиглалтын туршлагаар тогтоосон бол тухайн бүтээгдэхүүний маягт, маягийн гэрчилгээ эзэмшигч нь:</p> <p>(1) <u>Даргын</u> шаардсан даруйд, тохирох загварын өөрчлөлтийн зөвшөөрөл авахаар хүргүүлнэ;</p> <p>(2) загварын өөрчлөлтийн зөвшөөрөл авсан даруйд тухайн өөрчлөлтийг хамарсан тайлбар өгөгдлийг гаргаж тухайн бүтээгдэхүүнийг ашигладаг үйл ажиллагаа эрхлэгч бүр хэрэглэхэд бэлэн байлгана.</p> | <p>холбоотой мэдээллийн тайлбарыг бүтээгдэхүүн ашиглагч бүрт түгээнэ.</p> <p>(б) Бүтээгдэхүүнд аюултай байдал үүсээгүй ч, Маягийн гэрчилгээнд өөрчлөлт оруулснаар бүтээгдэхүүний аюулгүй ажиллагаанд тус нэмэртэй гэдэг нь ашиглалтын туршлагаар тогтоогдсон тохиолдолд Маягийн гэрчилгээ эзэмшигч нь:</p> <p>1/ загварт оруулах өөрчлөлтийг <u>ИНЕГ</u>-ын даргаар батлуулахаар ирүүлнэ;</p> <p>2/ загварын өөрчлөлтийг баталсны дараа өөрчлөлттэй холбоотой мэдээллийн тайлбарыг бүтээгдэхүүн ашиглагч бүрт түгээнэ.</p> | |
| <p>В Бүлэг-Маягийн гэрчилгээ ба маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээ</p> | <p>Б БҮЛЭГ. МАЯГИЙН ГЭРЧИЛГЭЭ, МАЯГИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ГЭРЧИЛГЭЭ/ TYPE CERTIFICATES AND TYPE ACCEPTANCE CERTIFICATES</p> | |
| <p>21.11. Зорилго</p> <p>Энэ Бүлэг нь дараах <u>зохицуулалтын шаардлагыг тогтооно</u>:</p> <p>(1) Монгол Улсад үйлдвэрлэх бүтээгдэхүүний маягийн гэрчилгээжүүлэлт;</p> <p>(2) Монгол Улсад импортлох бүтээгдэхүүний маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээжүүлэлт;</p> <p>(3) маягийн гэрчилгээ эзэмшигчийн үүрэг хариуцлага.</p> | <p>21.11. Үйлчлэх хүрээ/Scope</p> <p>(а) Энэ бүлгээр дараах <u>үйл ажиллагааг зохицуулна</u>:</p> <p>1/ Монгол Улсад үйлдвэрлэх бүтээгдэхүүнд маягийн гэрчилгээ олгох;</p> <p>2/ Монгол Улсад импортлох бүтээгдэхүүний маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээ олгох;</p> <p>3/ Маягийн гэрчилгээ эзэмшигчийн үүрэг хариуцлагыг тогтоох.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан - “<u>зохицуулалтын шаардлага</u>” “<u>үйл ажиллагаа</u>”</p> |
| <p>21.13. Гэрчилгээний <u>категори</u></p> <p>(а) Энэ Бүлгийн дагуу <u>Дарга</u> дараах гэрчилгээг олгож болно:</p> <p>(1) Монгол Улсад үйлдвэрлэх бүтээгдэхүүний маягт олгох стандарт <u>категорийн</u> маягийн гэрчилгээ;</p> <p>(2) Монгол Улсад үйлдвэрлэх агаарын хөлгийн маягт олгох хязгаарлалттай <u>категорийн</u> маягийн гэрчилгээ;</p> <p>(3) Монгол Улсад импортлох бүтээгдэхүүний маягт олгох стандарт <u>категорийн</u> маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээ;</p> <p>(4) Монгол Улсад импортлох агаарын хөлгийн маягт олгох хязгаарлалттай <u>категорийн</u> маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээ.</p> <p>(b) Хэрэв <u>тухайн</u> гэрчилгээний холбогдох шаардлагыг хангасан бол, Дарга энэ зүйлийн (а)-д заасан гэрчилгээг олгож болно.</p> | <p>21.13. Гэрчилгээний <u>ангилал/ Certificate categories</u></p> <p>(а) <u>ИНЕГ</u>-ын дарга энэ бүлгийн дагуу бүтээгдэхүүнд дараах ангиллын гэрчилгээг олгож болно:</p> <p>1/ Монгол Улсад үйлдвэрлэх бүтээгдэхүүнд стандарт, эсхүл хязгаарлагдмал <u>ангиллын</u> маягийн гэрчилгээ;</p> <p>2/ Монгол Улсад импортлох бүтээгдэхүүний стандарт, эсхүл хязгаарлагдмал <u>ангиллын</u> маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээ.</p> <p>(б) <u>ИНЕГ</u>-ын дарга энэ зүйлийн (а)-д заасан гэрчилгээнд тавигдах шаардлага хангагдсан гэж үзвэл уг гэрчилгээг олгоно.</p> | <p>-“ангилал”-ыг “категори” болгож өөрчилсөн</p> |

(с) Дарга агаарын хөлгийн хязгаарлалттай категорийн маягийн гэрчилгээ, эсхүл хязгаарлалттай категорийн маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээг олгохдоо, тухайн агаарын хөлгийн гэрчилгээжсэн үйл ажиллагааны зориулалтыг гэрчилгээнд тодорхой заах үүрэгтэй.

(в) ИНЕГ-ын дарга агаарын хөлөгт хязгаарлагдмал ангиллын маягийн гэрчилгээ, эсхүл Маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээг олгохдоо түүний ашиглалтын зориулалтыг гэрчилгээнд нь тодорхой зааж өгсөн байна.

21.15. Нөөц

21.15. Нөөц

21.17. Гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах

21.17. Өргөдөл гаргах/ Application for certificate

(а) Бүтээгдэхүүний маягт, маягийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь CAA 24021/01 маягтыг бөглөж, дараах баримтын хамт Даргад хүргүүлэх үүрэгтэй:

(а) Бүтээгдэхүүндээ Маягийн гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь ИНЕГ-021/01 тоот маягтыг бөглөж, дараах баримт бичгийн хамт ИНЕГ-ын даргад ирүүлнэ:

-Орчуулга,
найруулга зассан

- (1) зохих төлбөрийн баримт;
- (2) дараах мэдээлэл:
 - (i) агаарын хөлгийн маягийн хувьд, тухайн агаарын хөлгийн гурван талт зураг болон бусад бэлэн байгаа урьдчилсан үндсэн өгөгдөл;
 - (ii) агаарын хөлгийн хөдөлгүүр, эсхүл сэнсний маягийн хувьд, түүний загварын хэв шинжийн тайлбар, үйл ажиллагааны үзүүлэлт болон санал болгосон үйл ажиллагааны хязгаарлалт;
 - (iii) энэ Бүлгээр шаардсан, эсхүл Даргын шаардаж болох тухайн бүтээгдэхүүнтэй холбоотой бусад нэмэлт мэдээлэл.
- (b) Бүтээгдэхүүний маягт, маягийн гэрчилгээ эзэмших хүсэлт нь дараах хугацаанд хүчинтэй хэвээр байна:
 - (1) 3 жил; эсхүл
 - (2) MCTOW нь 5700 кг-аас дээш жинтэй нисэх онгоцны маягийн хувьд, 5 жил; эсхүл
 - (3) MCTOW нь 2730 кг-аас дээш жинтэй роторт-хөлгийн маягийн хувьд, 5 жил; эсхүл
 - (4) Даргын зөвшөөрч болох илүү урт хугацаа.

- 1/ тухайн маягийн агаарын хөлгийг гурван талын проекцоор харуулсан техникийн шугам зураг болон урьдчилсан байдлаар үзүүлэх аливаа техникийн ерөнхий үзүүлэлтүүд;
- 2/ агаарын хөлгийн хөдөлгүүр, сэнсний маяг, тэдгээрийн маягийн онцлогийг тусгасан тодорхойлолт, ашиглалтын үзүүлэлтүүд болон хязгаарлалтууд;
- 3/ энэ бүлгээр шаардсан эсхүл ИНЕГ-ын дарга шаардлагатай гэж үзсэн бүтээгдэхүүнтэй холбоотой бусад мэдээллийг;
- 4/ холбогдох төлбөрийн баримтыг хавсаргасан байна.
- (б) Бүтээгдэхүүнд Маягийн гэрчилгээ олгохыг хүссэн өргөдөл нь дор заасан хугацаанд хүчин төгөлдөр байна:
 - 1/ хөөрөлтийн зөвшөөрөгдсөн дээд жин нь 5700 кг-аас доош онгоцны хувьд 3 жил;
 - 2/ хөөрөлтийн зөвшөөрөгдсөн дээд жин нь 5700 кг-аас дээш онгоцны хувьд 5 жил;
 - 3/ хөөрөлтийн зөвшөөрөгдсөн дээд жин нь 2730 кг-аас дээш нисдэг тэрэгний хувьд 5 жил;
 - 4/ ИНЕГ-ын дарга зөвшөөрсөн тохиолдолд илүү удаан хугацаагаар тогтоож болно.

- rotorcraft-ыг “нисдэг тэрэг” гэснийг “роторт хөлөг” болгож өөрчилсөн

(с) Бүтээгдэхүүний маягт, маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь CAA 24021/02 маягтыг бөглөж, зохих төлбөрийн баримтын хамт Даргад хүргүүлэх үүрэгтэй.

(в) Бүтээгдэхүүний маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь ИНЕГ-021/02 тоот маягтыг бөглөж, төлбөрийн баримтын хамт ИНЕГ-ын даргад ирүүлнэ.

21.19. Гэрчилгээ олгох

21.19. Гэрчилгээ олгох/ Issue of certificate

- (а) Хэрэв Дарга, дараах шаардлага хангагдсан гэж үзвэл, хүсэлт гаргагч нь бүтээгдэхүүний маягт, маягийн гэрчилгээ, эсхүл маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээ эзэмших эрхтэй:
- (1) хүсэлт гаргагч 21.31-21.43-т заасан гэрчилгээжүүлэлтийн холбогдох шаардлагыг хангасан байх;
 - (2) тухайн гэрчилгээг олгох нь нисэхийн аюулгүй байдлын

- (а) ИНЕГ-ын дарга дараах шаардлагыг хангасан өргөдөл гаргагчийн бүтээгдэхүүнд Маягийн гэрчилгээ, эсхүл Маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээ олгоно:
- 1/ энэ дүрмийн 21.31-ээс 21.43-т заасан шаардлагуудыг хангасан;
 - 2/ гэрчилгээг олгосноор нисэхийн аюулгүй байдалнд харшлахгүй

-Орчуулга,
найруулга зассан

| | | |
|--|--|------------------------------------|
| <p>ашиг сонирхолд харшлахгүй байх;</p> <p>(3) бүтээгдэхүүний маягт олгох маягийн гэрчилгээний хувьд:</p> <p>(i) 21.35-ын дагуу шаардсан <u>үзлэг шалгалт</u> болон <u>тестээр</u> тухайн бүтээгдэхүүнийг хамааралтай НТЧ-ын шаардлага хангасныг тогтоосон байх;</p> <p>(ii) хүсэлт гаргагч нь ИНД-146-гийн дагуу зохион бүтээх байгууллагын гэрчилгээ эзэмшдэг, эсхүл гэрчилгээ эзэмших хүсэлт гаргасан байх; эсхүл</p> <p>(iii) хүсэлт гаргагч нь ИНД-148-ын дагуу үйлдвэрлэх байгууллагын <u>гэрчилгээ эзэмшдэг, эсхүл гэрчилгээ эзэмших</u> хүсэлт гаргасан байх.</p> <p>(b) Хэрэв маягийн гэрчилгээ нь 21.17(b)-д заасан хугацаанд олгогдоогүй бол, хүсэлт гаргагч нь 21.17(a)-ийн дагуу:</p> <p>(1) маягийн гэрчилгээний шинэ хүсэлтийг хүргүүлнэ; эсхүл</p> <p>(2) анхны гаргасан хүсэлтийг сунгуулах хүсэлтийг хүргүүлнэ.</p> <p>(c) Хэрэв маягийн гэрчилгээ эзэмших хүсэлтийг сунгуулахаар энэ зүйлийн (b)(2)-ын дагуу гаргасан хүсэлтийг зөвшөөрсөн бол анхны хүсэлтийн хүчинтэй хугацааг, 21.17(b)-гийн дагуу тогтоосон анхны хүсэлтийн хугацаанаас ихгүй хугацаагаар тухайн маягийн гэрчилгээ олгох өдрийн өмнөх өдөр гэж тооцно.</p> | <p>байх нөхцөлийг хангасан;</p> <p>3/ бүтээгдэхүүнд Маягийн гэрчилгээ олгоход:</p> <p>3.1. энэ дүрмийн 21.35–ын дагуу хийсэн <u>үзлэг шалгалтаар</u> бүтээгдэхүүн нь НТЧ-ын холбогдох шаардлагуудыг хангасан нь тогтоогдсон; ба</p> <p>3.2. өргөдөл гаргагч нь зохион бүтээгч байгууллагын гэрчилгээ эзэмшигч эсхүл гэрчилгээжих өргөдлөө гаргасан байх; эсхүл</p> <p>3.3. ИНД-148-ын дагуу гэрчилгээжсэн үйлдвэрлэгч байгууллагын <u>гэрчилгээ эзэмшигч эсхүл гэрчилгээжих</u> өргөдлөө гаргасан байх.</p> <p>(б) Маягийн гэрчилгээ энэ дүрмийн 21.17 (б)-д заасан хугацаанд олгогдоогүй тохиолдолд, өргөдөл гаргагч 21.17 (а)-ийн дагуу өргөдлийн маягыг шинээр бүрдүүлнэ:</p> <p>1/ Маягийн гэрчилгээ авах өргөдлийг дахин гаргах; эсхүл</p> <p>2/ өмнө гаргасан өргөдлийн хугацааг сунгуулах хүсэлтийг гаргаж болно.</p> <p>(в) Энэ зүйлийн (б)-гийн 2/-т заасны дагуу Маягийн гэрчилгээний өргөдлийн хугацааг сунгуулах тохиолдолд, өргөдлийн хүчинтэй хугацаа нь энэ дүрмийн 21.17 (б)-д заасан анхны өргөдлийн хугацаанаас ихгүй байна.</p> | |
| <p>21.21. Нөөц</p> | <p>21.21. Нөөц/Reserved</p> | |
| <p>21.23. Тусгай нөхцөл</p> <p>Хэрэв <u>Дарга</u>, НТЧ-ын стандарт нь дараах шалтгаанаар <u>хангалттай, эсхүл зохих</u> аюулгүй байдлын түвшнийг агуулаагүй болохыг тогтоосон бол, Дарга Хавсралт С-д заасан НТЧ-ын загварын стандартад дүйцэх аюулгүй байдлын түвшнийг тогтоох зорилгоор бүтээгдэхүүнд тусгай нөхцөл зааж болно:</p> <p>(1) бүтээгдэхүүн нь хамааралтай НТЧ-ын загварын стандартад суурилсан зохион бүтээх аргачлалтай харьцуулахад шинэ, эсхүл энгийн бус загварын хэв шинжтэй; эсхүл</p> <p>(2) бүтээгдэхүүнийг хэрэглэх зориулалт нь нийтлэг биш.</p> | <p>21.23. Тусгай нөхцөлүүд/ Special conditions</p> <p>(а) Дараах шалтгааны улмаас НТЧ-ын стандартад аюулгүй ажиллагааны түвшингийн талаар тохирсон заалт байхгүй тохиолдолд <u>ИНЕГ-ын дарга</u> Хавсралт В-д заасан загварын НТЧ-ын стандартад адилтгах хэмжээний <u>аюулгүй ажиллагааны түвшинг</u> тогтоох үүднээс тухайн бүтээгдэхүүнд тусгай нөхцөлийг зааж өгч болно:</p> <p>1/ тухайн бүтээгдэхүүн нь НТЧ-ын стандартын дагуу бүтээгддэг загвартай харьцуулахад цоо шинэ, эсхүл ердийнхөөс өөр загвар бол; эсхүл</p> <p>2/ бүтээгдэхүүний ашиглалтын зорилго нь ердийн биш бол.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |
| <p>21.25. Гэрчилгээний хугацаа</p> <p>(а) Маягийн гэрчилгээ нь түүнийг <u>түдгэлзүүлсэн</u>, эсхүл хүчингүй болгосноос бусад тохиолдолд хүчинтэй хэвээр байна.</p> <p>(б) Энэ Дүрмийн 21.43(a)(1)(i)-ийн дагуу маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээ олгоход шаардсан маягийн гэрчилгээ, эсхүл түүнтэй дүйцэх бусад баримт бичиг хүчингүй болсноос</p> | <p>21.25. Гэрчилгээний хугацаа/ Duration of certificate</p> <p>(а) Маягийн гэрчилгээ болон Маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээ нь <u>түр түдгэлзүүлэх</u>, эсхүл хүчингүй болгох хүртэл хүчин төгөлдөр байна.</p> <p>(б) Маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээ нь энэ дүрмийн 21.43 (а) 1/ 1.1–д заасан тухайн бүтээгдэхүүний маягийн гэрчилгээ, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг хүчингүй болох хүртэл хүчинтэй</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |

| | | |
|--|---|------------------------------------|
| <p>бусад тохиолдолд, маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээ нь хүчинтэй хэвээр байна.</p> | <p>байна.</p> | |
| <p>21.27. Гэрчилгээг шилжүүлэх (a) Тухайн этгээд нь <u>Даргын</u> хүлээн зөвшөөрөхүйц маягийн гэрчилгээ эзэмшдэг ба дараах гэрчилгээ эзэмшдэг байхаас бусад тохиолдолд маягийн гэрчилгээ эзэмшигчийг тухайн гэрчилгээг бусад этгээдэд шилжүүлэхийг зөвшөөрөхгүй: <u>(1) ИНД-146-гийн дагуу олгосон зохион бүтээх байгууллагын гэрчилгээ; эсхүл</u> (2) ИНД-148-ын дагуу олгосон үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ. (b) Маягийн гэрчилгээ эзэмшигч нь маягийн гэрчилгээг шилжүүлэхийн өмнө: (1) шилжүүлэн авагчийн нэр үйлчилгээ эрхлэх хаягийг <u>Даргад</u> бичгээр мэдэгдэх; (2) маягийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулахаар <u>Даргад</u> хүргүүлэх үүрэгтэй.</p> | <p>21.27. Гэрчилгээг шилжүүлэх/ Transfer of certificate (a) Маягийн гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээг <u>ИНЕГ</u>-ын даргын зөвшөөрөлгүйгээр, дор дурьдсанаас бусад этгээдэд шилжүүлэхийг хориглоно: 1/ <u>загвар зохион бүтээгч байгууллагын гэрчилгээ эзэмшигч;</u> эсхүл, 2/ ИНД148-ын дагуу гэрчилгээжсэн үйлдвэрлэгч байгууллагын гэрчилгээ эзэмшигч. (b) Маягийн гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээг өөр этгээдэд шилжүүлэхийн өмнө: 1/ гэрчилгээг шилжүүлэн авч буй этгээдийн нэр, хаягийг <u>ИНЕГ</u>-ын даргад бичгээр мэдэгдэх; ба 2/ гэрчилгээнд өөрчлөлт оруулахаар <u>ИНЕГ</u>-ын даргад ирүүлнэ.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |
| <p>Маягийн гэрчилгээжүүлэлтийн шаардлага 21.31. НТЧ-ын шаардлага Бүтээгдэхүүний маягт, маягийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах нотлох баримтыг <u>Даргад</u> хүргүүлэх үүрэгтэй: (1) энэ зүйлийн (2)-т зааснаас бусад тохиолдолд, бүтээгдэхүүний маягийн загвар нь дараах шаардлагыг хангаж байгааг: (i) Хавсралт С-д заасан хамааралтай НТЧ-ын загварын стандарт, эсхүл хүсэлт гаргагчийн сонгосон стандартын сүүлчийн нэмэлт өөрчлөлт; (ii) 21.23-ын дагуу <u>Даргын</u> тогтоосон тусгай нөхцөл; (iii) <u>Дарга</u> хамааралтай гэж үзсэн бусад НТЧ-ын шаардлага; (iv) Хавсралт С-д заасан агаарын хөлгийн холбогдох дуу чимээний болон хөдөлгүүрийн хийн ялгаруулалтын стандарт, эсхүл хүсэлт гаргагчийн сонгосон стандартын сүүлчийн нэмэлт өөрчлөлт; (2) хангаагүй НТЧ-ын шаардлагыг аюулгүй байдлыг хангах дүйцэх түвшний хүчин зүйлээр нөхсөн болохыг; (3) бүтээгдэхүүний маяг нь зөв нэмж өөрчилсөн нислэгийн заавар, эсхүл бусад тогтоосон хязгаарлалтын хүрээнд зориулалтын дагуу ашиглахад түүнийг аюултай болгох хэв шинж, эсхүл үзүүлэлтгүй болохыг.</p> | <p>Маягийн гэрчилгээ олгоход тавигдах шаардлага/ Type Certification Requirements 21.31. Нислэгт тэнцэх чадварын шаардлага/ Airworthiness requirements (a) Маягийн гэрчилгээ авах өргөдөл гаргагч нь дараах нотлох баримтыг <u>ИНЕГ</u>-ын даргад ирүүлнэ: 1/ энэ зүйлийн 2/-т зааснаас бусад тохиолдолд, бүтээгдэхүүний маягийн загвар нь дараах шаардлагуудыг хангасан тухай: 1.1. өргөдөл гаргагчийн сонгосон, энэ дүрмийн Хавсралт В-д тодорхойлогдсон холбогдох загварын НТЧ-ын стандартууд, эсхүл тэдгээрийн хамгийн сүүлчийн өөрчлөлтүүд; 1.2. энэ дүрмийн 21.23-ын дагуу <u>ИНЕГ</u>-ын даргын тогтоосон аливаа тусгай нөхцөлүүд; 1.3. <u>ИНЕГ</u>-ын даргын шаардлагатай гэж үзсэн НТЧ-ын бусад нэмэлт шаардлагууд; 1.4. өргөдөл гаргагчийн сонгосон, энэ дүрмийн Хавсралт В-д тодорхойлогдсон агаарын хөлгийн дуу чимээний болон хөдөлгүүрээс гарах хийн ялгаруулалтын стандартууд, эсхүл тэдгээрийн хамгийн сүүлчийн өөрчлөлтүүд. 2/ аль нэг НТЧ-ын стандарт шаардлагыг хангаагүй тохиолдолд аюулгүй ажиллагааны түвшинг түүнтэй адилтгах хэмжээний хүчин зүйлээр нөхөгдсөн тухай; 3/ нислэгийн зааварт, эсхүл бусад хязгаарлалтуудад зөв хийгдсэн нэмэлт өөрчлөлтийн дагуу ашиглахад тухайн маягийн бүтээгдэхүүний онцлог болон үзүүлэлт нь нислэгт аюултайгаар</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |

| | | |
|---|--|--|
| <p>21.32. Дуу чимээ болон хөдөлгүүрийн хийн ялгаруулалтын гэрчилгээжүүлэлт</p> <p>Бүтээгдэхүүний маягт, маягийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь Даргад дараах баримт бичгийг хүргүүлэх үүрэгтэй:</p> <p>(1) агаарын хөлгийн маягийн хувьд дараах баримт бичгээс бүрдсэн агаарын хөлгийн дуу чимээний гэрчилгээжүүлэлтийн мэдээлэл:</p> <p>(i) үйлдвэрлэгчийн маяг, оноосон загвар болон хөдөлгүүрийн маяг, загвар, хэрэв хамааралтай бол, сэнсний маяг загвар;</p> <p>(ii) Хавсралт С-д заасан стандарт категорийн агаарын хөлгийн дуу чимээний стандартын дагуу тухайн маягийн агаарын хөлгийн холбогдох дуу чимээний стандартыг тодорхойлсон мэдэгдэл;</p> <p>(iii) энэ зүйлийн (1)(ii)-ын дагуу хүсэлт гаргагчийн тодорхойлсон дуу чимээний стандартын нийцлийг бататгах зорилгоор агаарын хөлгийн загварт хийсэн модификацийн жагсаалт;</p> <p>(iv) энэ зүйлийн (1)(ii)-ын дагуу хүсэлт гаргагчийн тодорхойлсон дуу чимээний стандартад заасан журам болон стандартын дагуу хэмжсэн агаарын хөлгийн дуу чимээний дундаж түвшнийг заасан мэдэгдэл;</p> <p>(v) энэ зүйлийн (1)(iv)-т шаардсан дуу чимээний түвшний хэмжилтийн үеийн агаарын хөлгийн максимум жинг заасан мэдэгдэл;</p> <p>(2) турбо-жэт, турбо-фэн хөдөлгүүрийн маягийн хувьд, Хавсралт С-д заасан стандарт категорийн хөдөлгүүрийн хийн ялгаруулалтын стандартыг хангасан хөдөлгүүрийн хийн ялгаруулалтын гэрчилгээжүүлэлтийн дараах баримт бичгийг багтаасан мэдээлэл:</p> <p>(i) үйлдвэрлэгчийн маяг болон оноосон загвар;</p> <p>(ii) Хавсралт С-д заасан стандарт категорийн агаарын хөлгийн хөдөлгүүрийн хийн ялгаруулалтын стандартын дагуу тухайн маягийн хөдөлгүүрийн холбогдох хийн ялгаруулалтын стандартыг тодорхойлсон мэдэгдэл;</p> <p>(iii) энэ зүйлийн (2)(ii)-ын дагуу хүсэлт гаргагчийн тодорхойлсон, хөдөлгүүрийн хийн ялгаруулалтын стандартын нийцлийг бататгах зорилгоор хөдөлгүүрт хийсэн модификацийн жагсаалт;</p> <p>(iv) энэ зүйлийн (2)(ii)-ын дагуу хүсэлт гаргагчийн тодорхойлсон, хөдөлгүүрийн хийн ялгаруулалтын</p> | <p>нөлөөлөхгүй талаар.</p> <p>21.32. Агаарын хөлгийн дуу чимээний болон хөдөлгүүрээс гарах хийн ялгаруулалтын гэрчилгээжүүлэлт/ Aircraft noise and engine emission certification</p> <p>(а) Бүтээгдэхүүнд маягийн гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь ИНЕГ-ын даргад дараах баримт бичгийг ирүүлнэ:</p> <p>1/ агаарын хөлгийн маягийн хувьд түүний дуу чимээний гэрчилгээжүүлэлтийн мэдээлэл нь дараах зүйлээс бүрдсэн байна:</p> <p>1.1. үйлдвэрлэгчийн тодорхойлсон агаарын хөлгийн маяг, төрөл, хөдөлгүүрийн маяг, төрөл; шаардлагатай бол сэнсний маяг, төрөл;</p> <p>1.2. энэ дүрмийн Хавсралт В-д тодорхойлогдсон стандарт ангиллын агаарын хөлгийн дуу чимээний стандартын дагуу тухайн маягийн агаарын хөлгийн дуу чимээний стандартыг тогтоосон тодорхойлолт;</p> <p>1.3. энэ хэсгийн 1/ 1.2-ын дагуу тогтоосон, дуу чимээний стандартад нийцсэнийг бататгах агаарын хөлгийн загварт хийгдсэн өөрчлөлтүүдийн жагсаалт;</p> <p>1.4. энэ хэсгийн 1/ 1.2-ын дагуу тогтоосон, дуу чимээний стандартад заасан журам болон стандартаар агаарын хөлгийн дуу чимээний дундаж түвшинг хэмжиж тогтоосон тодорхойлолт;</p> <p>1.5. энэ хэсгийн 1/ 1.4-т шаардсаны дагуу агаарын хөлгийн дуу чимээний түвшинг хэмжих үеийн агаарын хөлгийн хамгийн дээд жинг тогтоосон тодорхойлолт.</p> <p>2/ тийрэлтэт хөдөлгүүрийн хувьд, хөдөлгүүрээс гарах хийн ялгаруулалтын гэрчилгээжүүлэлтийн мэдээлэл нь Хавсралт В-д тодорхойлсон стандарт ангиллын хөдөлгүүрийн үзүүлэлтүүдийг хангасан байх бөгөөд дараах мэдээллийг багтаасан байна:</p> <p>2.1. үйлдвэрлэгчийн маяг, төрөл тэдгээрийн тодорхойлолт;</p> <p>2.2. Хавсралт В-д тодорхойлсон хөдөлгүүрээс гарах хийн ялгаруулалтын стандарт ангиллын дагуу тухайн маягийн хөдөлгүүрээс гарах хийн ялгаруулалтын стандартыг тогтоосон тодорхойлолт;</p> <p>2.3. энэ хэсгийн 2/ 2.2-ын дагуу тогтоосон, хөдөлгүүрээс гарах хийн ялгаруулалтын стандартад нийцсэнийг бататгах хөдөлгүүрт хийгдсэн өөрчлөлтүүдийн жагсаалт;</p> <p>2.4. энэ хэсгийн 2/ 2.2-ын дагуу тогтоосон, хөдөлгүүрээс гарах хийн ялгаруулалтын стандарт үзүүлэлтэд заасны дагуу</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>Modification-ыг “өөрчлөлт” гэснийг “модификаци” болгож өөрчилсөн</p> |
|---|--|--|

| | | |
|---|--|---|
| <p>стандартад заасан тооцоот гаралтын (rated output) мэдэгдэл;</p> <p>(v) энэ зүйлийн (2)(ii)-ын дагуу хүсэлт гаргагчийн тодорхойлсон, хөдөлгүүрийн хийн ялгаруулалтын стандартаар шаардсан даралтын жишиг харьцааны мэдэгдэл;</p> <p>(vi) энэ зүйлийн (2)(ii)-ын дагуу хүсэлт гаргагчийн тодорхойлсон, хөдөлгүүрийн хийн ялгаруулалтын стандартын утааны индексийн шаардлага хангаж байгааг тогтоосон мэдэгдэл;</p> <p>(vii) энэ зүйлийн (2)(ii)-ын дагуу хүсэлт гаргагчийн тодорхойлсон, хөдөлгүүрийн хийн ялгаруулалтын стандартын бохирдуулагч хийн шаардлага хангаж байгааг тогтоосон мэдэгдэл.</p> | <p>гаралтыг тооцоолсон тодорхойлолт;</p> <p>2.5. энэ хэсгийн 2/ 2.2-ын дагуу тогтоосон, хөдөлгүүрээс гарах хийн ялгаруулалтын стандарт шаардлагыг баримтлан даралтын харьцааг тооцоолсон тодорхойлолт;</p> <p>2.6. энэ хэсгийн 2/ 2.2-ын дагуу тогтоосон, хөдөлгүүрээс гарах хийн ялгаруулалтын стандарт шаардлагын дагуу утааны индекс үзүүлэлтүүдийг хангаж байгаа тухай тодорхойлолт;</p> <p>2.7. энэ хэсгийн 2/ 2.2-ын дагуу тогтоосон, хөдөлгүүрээс гарах хийн ялгаруулалтын стандарт шаардлагын дагуу байгаль орчныг бохирдуулагч хийн бодисын үзүүлэлтүүдийг хангаж байгаа тухай тодорхойлолт.</p> | |
| <p>21.33. Маягийн загвар Бүтээгдэхүүний маягт, маягийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:</p> <p>(1) дараах мэдээллээс <u>бүрдсэн маягийн загварыг Даргад</u> хүргүүлэх:</p> <p>(i) хамааралтай НТЧ-ын шаардлага хангаж байгааг харуулсан бүтээгдэхүүний маягийн конфигураци ба загварын хэв шинжийг тодорхойлоход шаардлагатай зураг, тодорхойлолт болон бусад мэдээлэл;</p> <p>(ii) энэ зүйлийн (1)(i)-д заасан зураг, тодорхойлолтын жагсаалт;</p> <p>(iii) бүтээгдэхүүний маягийн бүтцийн бөх бат чанарыг тодорхойлоход шаардлагатай процесс, материал болон хэмжээсийн мэдээлэл;</p> <p>(iv) Хавсралт С-д заасан хамааралтай НТЧ-ын загварын стандартаар шаардсан НТЧ-ын хадгалалтын зааварчилгааны НТЧ-ын хязгаарлалтын хэсэг;</p> <p>(v) ижил маягийн сүүлд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний НТЧ-ыг тодорхойлоход шаардлагатай бусад өгөгдөл;</p> <p>(2) маягийн загвар бүрийг болон тухайн маягийн загварын хүрээнд вариант бүрийг таньж тогтоох.</p> | <p>21.33 Маягийн загварыг тодорхойлох/ Determining Type design (a) Бүтээгдэхүүнд маягийн гэрчилгээ авах өргөдөл гаргагч нь:</p> <p>1/ <u>ИНЕГ</u>-ын даргад маягийн загварын тухай дараах зүйлээс бүрдсэн баримт бичгийг ирүүлнэ:</p> <p>1.1. бүтээгдэхүүн нь НТЧ-ын холбогдох шаардлагуудыг хангаж байгааг харуулсан, бүтээгдэхүүний маягийн загварын онцлог ба хийцийг тодорхойлоход шаардлагатай техникийн зураг схем, тодорхойлолтууд болон бусад мэдээлэл;</p> <p>1.2. энэ хэсгийн 1/ 1.1-д заасан техникийн зураг схем, тодорхойлолтын жагсаалт;</p> <p>1.3. бүтээгдэхүүний бүтцийн бөх бат чанарыг тодорхойлоход шаардлагатай технологийн аргачлал, материал болон хэмжээсүүдийн талаарх мэдээлэл;</p> <p>1.4. Хавсралт В-д тодорхойлсон, загварын НТЧ-ын стандартаар шаардсан НТЧ-ын хадгалалтын зааварчилгааны НТЧ-ын хязгаарлалтын гэсэн бүлгийг;</p> <p>1.5. ижил маягийн сүүлийн үеийн бүтээгдэхүүний НТЧ-г тодорхойлоход шаардлагатай бусад мэдээлэл.</p> <p>2/ маягийн загварын хүрээнд хийгдсэн бүх загварууд болон <u>хувилбар</u> бүрийн тодорхойлолт.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-“вариант” “хувилбар”</p> |
| <p>21.35. Үзлэг шалгалт болон тест (a) Бүтээгдэхүүний маягт, маягийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах шаардлагыг бататгах тухайн маягийн бүтээгдэхүүнд үзлэг шалгалт болон тест хийнэ:</p> <p>(1) бүтээгдэхүүн нь холбогдох НТЧ-ын шаардлага хангаж байх;</p> <p>(2) материал болон бүтээгдэхүүн нь маягийн загварын</p> | <p>21.35 Үзлэг, шалгалт хийх/ Inspections and tests (a) Бүтээгдэхүүнд маягийн гэрчилгээ авах өргөдөл гаргагч нь тухайн бүтээгдэхүүнд үзлэг, шалгалт хийж дараах зүйлийг бататгасан байна:</p> <p>1/ бүтээгдэхүүн нь НТЧ-ын холбогдох шаардлагуудыг хангаж байгаа эсэх;</p> <p>2/ бүтээгдэхүүн болон түүний материал нь маягийн загварын</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |

| | | |
|--|---|---|
| <p>тодорхойлолтод тохирч байх; (3) бүтээгдэхүүний бүх эд анги нь маягийн загварын зурагтай тохирч байх; (4) үйлдвэрлэлийн процесс, бүтээх болон угсрах ажиллагаа нь маягийн загварт заасантай нийцэж байх.</p> <p>(b) Энэ зүйлийн (a)-гийн дагуу шаардсан үзлэг шалгалт болон тест хийсний дараа хүсэлт гаргагч нь:</p> <p>(1) <u>Даргын</u> шаардаж болох үзлэг шалгалт, нислэгийн болон газрын тест хийхийг зөвшөөрнө; (2) бүтээгдэхүүн нь энэ зүйлийн (a)(2), (3) болон (4)-ийн шаардлага хангаж байгааг нотлох баримтыг гаргана; (3) бүтээгдэхүүн нь энэ зүйлийн (a)(2), (3), болон (4)-ийн шаардлага хангаж байгааг харуулснаас хойш, <u>Даргад</u> тест хийж танилцуулах хүртэлх хугацаанд өөрчлөгдөөгүй хэвээр болохыг бататгана.</p> | <p>техникийн тодорхойлолтод тохирч байгаа эсэх; 3/ бүтээгдэхүүний эд ангиуд нь маягийн загварын зураг, схемтэйгээ тохирч байгаа эсэх; 4/ үйлдвэрлэлийн явц, бүтээх, угсрах ажиллагаа нь маягийн загварт заасны дагуу явагдаж, нийцсэн эсэх.</p> <p>(б) Энэ зүйлийн (a)-д заасан үзлэг, шалгалтыг хийсний дараа <u>ИНЕГ</u>-ын дарга шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өргөдөл гаргагч нь:</p> <p>1/ зохих зөвшөөрлийг авч бүтээгдэхүүнээ газарт болон агаарт шалгана; 2/ бүтээгдэхүүн нь энэ зүйлийн (a) 2/, 3/ болон 4/-т заасан шаардлагуудыг хангаж байгааг нотолсон баримтыг гаргана; 3/ бүтээгдэхүүн нь энэ зүйлийн (a) 2/, 3/ болон 4/-т заасан шаардлагуудыг хангасныг харуулах <u>ИНЕГ</u>-аас хийх үзлэг, шалгалт хүртэлх хугацаанд уг бүтээгдэхүүн өөрчлөгдөөгүй гэдгийг бататгана.</p> | |
| <p>21.37. <u>Нийцлийн мэдэгдэл</u> (a) 21.35(b)-гийн дагуу тест хийхээр, <u>Даргад</u> бүтээгдэхүүнээ танилцуулж байгаа маягийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь 21.35(b)(2)(3)-ын шаардлага хангаж байгааг мэдэгдсэн нийцлийн мэдэгдлийг <u>Даргад</u> хүргүүлнэ.</p> <p>(b) Бүтээгдэхүүний маягт, маягийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч, тухайн бүтээгдэхүүн нь хамааралтай НТЧ-ын шаардлага хангаж байгааг мэдэгдсэн нийцлийн мэдэгдлийг <u>Даргад</u> хүргүүлнэ.</p> | <p>21.37 <u>Шаардлага хангасан тухай мэдэгдэл гаргах/ Statement of compliance</u> (a) Маягийн гэрчилгээ авах өргөдөл гаргагч нь энэ дүрмийн 21.35 (б)-ийн дагуу <u>ИНЕГ</u>-т бүтээгдэхүүнээ танилцуулж, шалгуулахын тулд 21.35 (б) 2/ болон 3/-т заасан шаардлагуудыг тухайн бүтээгдэхүүн нь хангасан тухай мэдэгдлийг <u>ИНЕГ</u>-ын даргад ирүүлнэ. (б) Өргөдөл гаргагч энэ зүйлийн (a)-д зааснаас гадна тухайн бүтээгдэхүүн нь НТЧ-ын холбогдох шаардлагуудыг хангаж байгаа тухай мэдэгдлийг <u>ИНЕГ</u>-ын даргад мөн ирүүлсэн байна.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Compliance- “шаардлага” гэснийг “нийцэл” гэж өөрчилсөн.</p> |
| <p>21.39. <u>Шалгах нислэг</u> (a) Энэ зүйлийн (b)-г харгалзан агаарын хөлгийн маягт, маягийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, <u>Даргын</u> шаардаж болох дараах шаардлагыг бататгах шалгах нислэг хийх үүрэгтэй: (1) тухайн агаарын хөлгийн маяг нь хамааралтай НТЧ-ын шаардлага хангасан байх; (2) тухайн агаарын хөлгийн маяг болон агаарын хөлгийн бүрдэл хэсэг нь найдвартай, зөв ажилладаг байх.</p> <p>(b) Хүсэлт гаргагч нь дараах шаардлагыг бататгах үүрэгтэй: (1) энэ зүйлийн (a)-д шаардсан шалгах нислэг хийхийн өмнө: (i) агаарын хөлөг нь Хавсралт С-д заасан, хамааралтай НТЧ-ын загварын стандартын бүтцийн шаардлага хангасан байх ; (ii) тухайн агаарын хөлөгт, газарт хийх шаардлагатай</p> | <p>21.39 <u>Шалгалтын нислэг/ Flight tests</u> (a) Хэрэв <u>ИНЕГ</u>-ын дарга шаардлагатай гэж үзвэл өргөдөл гаргагч нь энэ зүйлийн (б)-д заасан нөхцөлийг хангаж дараах зүйлийг шалгаж тодорхойлох зорилгоор шалгалтын нислэгийг үйлдэнэ: 1/ агаарын хөлгийн маяг нь НТЧ-ын холбогдох шаардлагуудыг хангаж байгаа эсэх; 2/ агаарын хөлөг, түүний бүрэлдэхүүн хэсгийн ажиллагаа зөв бөгөөд найдвартай байгаа эсэх.</p> <p>(б) Энэ зүйлийн (a)-д шаардсан шалгалтын нислэгийг гүйцэтгэхийн өмнө өргөдөл гаргагч нь дараах зүйлийг шалгаж бататгасан байна: 1/ агаарын хөлөг нь энэ дүрмийн Хавсралт В-д тодорхойлсон загварын НТЧ-ын стандартын их биений бүтцийн шаардлагыг хангаж байгаа эсэх; 2/ агаарын хөлөг нь газарт хийх шаардлагатай үзлэг,</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Flight tests- “шалгалтын нислэг” гэснийг “нислэгийн туршилт” гэж өөрчилсөн</p> |

| | | |
|--|--|---------------------------------------|
| <p>үзлэг шалгалт болон тест хийдэг байх; (iii) тухайн агаарын хөлөг нь маягийн загвартаа нийцэж байх; (2)энэ зүйлийн (а)-д шаардсан шалгах нислэгийг: (i) дараах шаардлагыг хангасан этгээд гүйцэтгэсэн байх: (A) тухайн этгээд нь ИНД-61-ийн дагуу олгосон хүчинтэй нисгэгчийн үнэмлэх, эсхүл хүлээн зөвшөөрсөн гэрчилгээ эзэмшдэг байх ба хийгдэж байгаа маягийн анхны загварын туршилт, эсхүл туршилтын нислэгт туршин-нисгэгчийн үүрэг гүйцэтгэхийг <u>Дарга</u> зөвшөөрсөн байх; эсхүл (B) <u>агаарын хөлөг нь хэт хөнгөн агаарын хөлөг ба тухайн этгээдийг хэт хөнгөн агаарын хөлгийн байгууллага зөвшөөрсөн байх, хэрэв ИНД-149-ийн байгууллагын гэрчилгээ нь тухайн эзэмшигчид хийгдэж байгаа маягийн анхны загварын тест, эсхүл туршилтын нислэгт туршин-нисгэгчид эрх олгохыг зөвшөөрдөг бол; эсхүл</u> (C) <u>агаарын хөлөг нь глайдер ба тухайн этгээдийг глайдерын байгууллага зөвшөөрсөн байх, хэрэв ИНД-149-ийн байгууллагын гэрчилгээ нь тухайн эзэмшигчид хийгдэж байгаа маягийн анхны загварын тест, эсхүл туршилтын нислэгт туршин-нисгэгчид эрх олгохыг зөвшөөрдөг бол;</u> (ii) <u>Даргын хүлээн зөвшөөрөхүйц холбогдох журмын дагуу гүйцэтгэсэн байх.</u></p> | <p>шалгалтанд орсон эсэх; 3/ агаарын хөлөг нь тухайн маягийн загвартайгаа нийцэж байгаа эсэх. (в) Энэ зүйлийн (а)-д шаардсан шалгах нислэгийг ИНЕГ-ын даргын баталсан шалгалтын нислэгийн журмын дагуу гүйцэтгэх ба гүйцэтгэх этгээд нь дараах шаардлагыг хангасан байна: 1/ ИНД-61-ийн дагуу олгосон, хүчин төгөлдөр нисгэгчийн үнэмлэх эзэмшсэн, шалгагчийн зэрэглэлтэй нисгэгч байх; 2/ ИНЕГ-ын даргаас тухайн агаарын хөлгийг шалгах зөвшөөрөл олгогдсон байх.</p> | <p>-Amend.7-оор шинээр нэмэгдсэн.</p> |
| <p>Маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээжүүлэлтийн шаардлага 21.41. НТЧ-ын шаардлага</p> <p>Бүтээгдэхүүний маягт, маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах нотлох баримтыг <u>Даргад</u> хүргүүлэх үүрэгтэй:</p> <p>(1) <u>Дарга өөр хугацааг бичгээр тусгайлан зааснаас бусад тохиолдолд тухайн бүтээгдэхүүн нь Хавсралт С-д заасан болон гадаадын маягийн гэрчилгээ, эсхүл дүйцэх баримт бичигт заасан хугацаанд хүчинтэй байсан дараах стандартыг хангасан болохыг;</u> (i) <u>НТЧ-ын загварын стандарт;</u> (ii) <u>агаарын хөлгийн дуу чимээний болон хөдөлгүүрийн хийн ялгаруулалтын стандарт;</u></p> <p>(2) бүтээгдэхүүний маяг нь гадаадын маягийн гэрчилгээжүүлэлтийн дагуу тогтоогдсон, эсхүл 21.23-ын дагуу <u>Дарга</u> бичгээр тодорхойлсон тусгай нөхцөлийг хангаж байгааг;</p> | <p>Маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээ олгоход тавигдах шаардлага/ Type Acceptance Certification Requirements 21.41 НТЧ-ын шаардлага/ Airworthiness requirements</p> <p>(а) Бүтээгдэхүүний маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээ авах өргөдөл гаргагч нь дараах нотлох баримтыг ИНЕГ-ын даргад ирүүлнэ: 1/ бүтээгдэхүүний маяг нь Хавсралт В-д тодорхойлсон дараах шаардлагуудыг хангасан тухай: 1.1. загварын НТЧ-ын стандартууд; 1.2. агаарын хөлгийн дуу чимээ, хөдөлгүүрээс гарах хийн ялгаруулалтын стандартууд; 1.3. ИНЕГ-ын дарга хүчинтэй хугацааг нь өөрөөр тогтоогоогүй бол, гадаад улсын эрх бүхий байгууллагаас олгосон хүчин төгөлдөр Маягийн гэрчилгээ, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг.</p> <p>2/ ИНЕГ-ын дарга энэ дүрмийн 21.23-ын дагуу тодорхойлсон эсхүл гадаадын Маягийн гэрчилгээнд заасан тусгай нөхцөлийг хангаж байгаа тухай;</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |

| | | |
|---|--|---|
| <p>(3) хангаагүй НТЧ-ын шаардлагыг аюулгүй байдлын дүйцэх түвшнийг хангасан хүчин зүйлээр нөхсөн болохыг;</p> <p>(4) бүтээгдэхүүний маягийг зориулалтын дагуу ашиглахад аюултай болгох хэв шинж, эсхүл үзүүлэлт байхгүй болохыг.</p> | <p>3/ аливаа нэг НТЧ-ын шаардлагыг хангаагүй тохиолдолд аюулгүй ажиллагааны түвшинг түүнтэй адилтгах хэмжээний хүчин зүйлээр нөхөж хангасан тухай;</p> <p>4/ агаарын хөлгийн нислэг техникийн үзүүлэлтүүд нь зориулалтын дагуу ашиглахад аюулгүй гэдгийг бататгасан.</p> | |
| <p>21.43. Өгөгдлийн шаардлага</p> <p>(a) Бүтээгдэхүүний маягт, маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь Даргад дараах баримт бичгийг хүргүүлэх үүрэгтэй:</p> <p>(1) дараах нотлох баримт:</p> <p>(i) тухайн маягийн загварыг ICAO-гийн Хэлэлцэн тохирогч Зохион бүтээгч улс маягийн гэрчилгээ, эсхүл дүйцэх баримт бичиг олгосноор зөвшөөрсөн болохыг;</p> <p>(ii) тухайн маягийн гэрчилгээ, эсхүл дүйцэх баримт бичгийг Зохион бүтээгч улс хүчинтэй гэж үзсэн болохыг;</p> <p>(2) энэ зүйлийн (a)(1)-д заасан маягийн гэрчилгээ, эсхүл дүйцэх баримт бичиг олгоход тавих НТЧ-ын шаардлага хангасан тухай дараах дэлгэрэнгүй мэдээлэл:</p> <p>(i) НТЧ-ын загварын стандарт;</p> <p>(ii) стандартын хүчинтэй хугацаа;</p> <p>(iii) гадаадын маягийн гэрчилгээжүүлэлтийн хүрээнд тогтоосон тусгай нөхцөл;</p> <p>(iv) хангаагүй шаардлагыг Даргын хүлээн зөвшөөрөхүйц, аюулгүй байдлын дүйцэх түвшнийг хангах хүчин зүйлээр нөхсөн тухай;</p> <p>(v) аливаа НТЧ-ын хязгаарлалт;</p> <p>(3) агаарын хөлгийн дуу чимээний болон хөдөлгүүрийн хийн ялгаруулалтын гэрчилгээжүүлэлтийн талаар 21.32(1) (2)-т шаардсан дэлгэрэнгүй мэдээлэл;</p> <p>(4) хамааралтай НТЧ-ын загварын стандартад нийцэж байгааг харуулсан, энэ зүйлийн (a)(1)-д заасан маягийн гэрчилгээ, эсхүл дүйцэх баримт бичгийг авахаар хүргүүлсэн өгөгдлийг тогтоосон жагсаалт;</p> <p>(5) агаарын хөлгийн хувьд, энэ зүйлийн (a)(1)-д заасан маягийн гэрчилгээ, эсхүл дүйцэх баримт бичгийн хүрээнд баталсан нислэгийн зааврын хувь, эсхүл хэрэв холбогдох загварын стандартад нислэгийн заавартай байхыг шаардаагүй бол, Хавсралт С-д заасан стандартад нийцсэн нислэгийн заавар;</p> <p>(6) хэрэв Дарга шаардсан бол:</p> | <p>21.43 <u>Техникийн үзүүлэлтийн мэдээлэл</u>д тавигдах шаардлага/ Technical data requirements</p> <p>(a) Бүтээгдэхүүний маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээ авах өргөдөл гаргагч нь ИНЕГ-ын даргад дараах мэдээллийг ирүүлнэ:</p> <p>1/ дараах зүйлийг нотлох баримт:</p> <p>1.1. маягийн загвар нь Чикагогийн конвенцийн хэлэлцэн тохирогч зохион бүтээгч улсаас баталгаажуулан олгосон Маягийн гэрчилгээ, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг;</p> <p>1.2. зохион бүтээгч улсаас олгосон тухайн Маягийн гэрчилгээ, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг нь хүчинтэй хугацаандаа байгааг харуулсан баримт;</p> <p>2/ энэ зүйлийн (a) 1/-д заасан Маягийн гэрчилгээ эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг олгоход НТЧ-ын шаардлагыг хангасан тухай дараах зүйлийг багтаасан дэлгэрэнгүй:</p> <p>2.1. НТЧ-ын загварын стандартууд;</p> <p>2.2. стандартын хүчинтэй хугацаа;</p> <p>2.3. гадаадын Маягийн гэрчилгээнд заасан бусад тусгай нөхцөлүүд;</p> <p>2.4. ИНЕГ-ын даргын хүлээн зөвшөөрөх аюулгүй ажиллагааны түвшинг зохих хүчин зүйлээр нөхөж байгаа стандарт шаардлагыг хангаагүй заалтууд;</p> <p>2.5. НТЧ-ын аливаа хязгаарлалтууд.</p> <p>3/ энэ дүрмийн 21.32 1/ болон 2/-т заасан агаарын хөлгийн дуу чимээ болон хөдөлгүүрээс гарах хийн ялгаруулалтын гэрчилгээжүүлэлтийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл;</p> <p>4/ энэ зүйлийн (a) 1/-д заасан Маягийн гэрчилгээг эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг олгоход танилцуулсан загварын НТЧ-ын стандартыг хангаж байгааг харуулсан үзүүлэлтийн жагсаалт;</p> <p>5/ агаарын хөлгийн хувьд, энэ зүйлийн (a) 1/-д заасан Маягийн гэрчилгээ эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийн дагуу батлагдсан Нислэгийн зааврын нэг хувийг, хэрэв тухайн загварын стандартад нислэгийн зааврыг шаардаагүй бол Хавсралт В-д заасан стандартыг хангасан Нислэгийн зааврын хувийг;</p> <p>6/ ИНЕГ-ын дарга шаардсан тохиолдолд дараах баримт бичгийг</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Technical data- “техникийн үзүүлэлтийн мэдээлэл” гэснийг “өгөгдөхүүн” гэж өөрчилсөн.</p> |

| | | |
|---|---|---|
| <p>(i) бүтээгдэхүүний маягийн техник үйлчилгээний зааврын хувь;</p> <p>(ii) бүтээгдэхүүний маягийг үйлдвэрлэгчээс гаргасан хүчинтэй ашиглалтын мэдээллийн (service information) хувь;</p> <p>(iii) бүтээгдэхүүний маягийн эд ангийн зурагт каталогийн хувь;</p> <p>(7) үйлдвэрлэгч, эсхүл энэ зүйлийн (a)(1)-д заасан маягийн гэрчилгээ, эсхүл дүйцэх баримт бичиг эзэмшигч нь энэ зүйлийн (a)(5)(a)(6)-д заасан баримт бичигт орсон нэмэлт өөрчлөлт болон шинэчлэлтийн хувийг Даргад хүргүүлж байхыг зөвшөөрсөн болохыг нотлох баримт.</p> <p>(b) Хэрэв энэ зүйлийн (a)-д иш татсан бүтээгдэхүүний маяг нь агаарын хөлгийн маяг бол энэ зүйлийн (a)(6)-д шаардсан мэдээлэлд тухайн агаарын хөлгийн хөдөлгүүрийн, хэрэв хамааралтай бол, сэнсний мэдээлэл багтсан байх ёстой.</p> <p>(c) Хэрэв 21.41 болон 21.43-ын шаардлага нь аливаа нэмэлт бүтээгдэхүүнд тохирч байгаа бол, <u>Дарга</u>, маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээнд хамаарах бүтээгдэхүүний загвар, эсхүл серийн дугаарын хамрах хүрээг бичгээр тодорхойлох, эсхүл тухайн гэрчилгээний хамрах хүрээг дахин тодорхойлж болно.</p> | <p>ирүүлнэ:</p> <p>6.1. бүтээгдэхүүний техник үйлчилгээний зааврын хуулбар;</p> <p>6.2. агаарын хөлгийн үйлдвэрлэгчээс гаргасан техник үйлчилгээний талаарх мэдээллийн хуулбар;</p> <p>6.3. тайлбар зураг бүхий эд ангийн каталогийн хуулбар;</p> <p>7/ агаарын хөлгийн үйлдвэрлэгч, эсхүл Маягийн гэрчилгээ эзэмшигч нь энэ хэсгийн (a) 5/ болон 6/-д заасан баримт бичигт орсон аливаа өөрчлөлт, шинэчлэлт бүрийг <u>ИНЕГ</u>-ын даргад ирүүлж байхыг зөвшөөрсөн нотолгоо.</p> <p>(б) Хэрэв энэ зүйлийн (a)–д заасан бүтээгдэхүүн нь агаарын хөлөг бол (a) 6/-д шаардсан мэдээллийг ирүүлэхдээ тухайн агаарын хөлгийн хөдөлгүүр, сэнсний мэдээллийг багтаасан байна.</p> <p>(в) Аливаа нэмэлт бүтээгдэхүүний хувьд, энэ дүрмийн 21.41 ба 21.43-т заасан шаардлагуудыг хангасан тохиолдолд <u>ИНЕГ</u>-ын дарга агаарын хөлгийн Маягийн гэрчилгээг дахин тодорхойлох, эсхүл Маягийн гэрчилгээнд заасан бүтээгдэхүүний төрөл, серийн дугаарын хамаарагдах хүрээг тогтоож өгч болно.</p> | |
| <p>С Бүлэг-Загварын өөрчлөлт</p> | <p>В БҮЛЭГ. ЗАГВАРЫН ӨӨРЧЛӨЛТ/ DESIGN CHANGES</p> | |
| <p>21.71. Зорилго Энэ Бүлэг нь загварын өөрчлөлтийн зөвшөөрөл олгох зохицуулалтын шаардлагыг тогтооно.</p> | <p>21.71. Үйлчлэх хүрээ/ Scope (a) Энэ бүлгээр бүтээгдэхүүний загварт орсон өөрчлөлтийг баталгаажуулах ажиллагааг зохицуулна.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |
| <p>21.73. Загварын өөрчлөлтийн зөвшөөрөл</p> <p>(a) Загварын өөрчлөлтийг дараах хэлбэрээр зөвшөөрч болно:</p> <p>(1) НТЧ-ын удирдамжид оруулах; эсхүл</p> <p>(2) <u>модификацийг зөвшөөрөх</u>; эсхүл</p> <p>(3) D Бүлгийн дагуу маягийн гэрчилгээ, эсхүл маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээний өөрчлөлтийг зөвшөөрөх; эсхүл</p> <p>(4) E Бүлгийн дагуу нэмэлт маягийн гэрчилгээ олгох.</p> <p>(b) Загварын өөрчлөлт нь дараах тохиолдолд, Даргын хүлээн зөвшөөрөхүйц байна, хэрэв:</p> <p>(1) Хавсралт D-д заасан техникийн өгөгдөлд заасан бол; эсхүл</p> <p>(2) НТЧ-ын гэрчилгээ олгосноор хүлээн зөвшөөрсөн бол.</p> <p><u>(c) Тухайн бүтээгдэхүүнд том хэмжээний модификаци хийхээр төлөвлөж байгаа, бүтээгдэхүүний маягийн гэрчилгээ</u></p> | <p>21.73. Загварын өөрчлөлтийг баталгаажуулах/ Approval of design changes</p> <p>(a) Загварын өөрчлөлтийг дараах арга замаар баталгаажуулна:</p> <p>1/ НТЧ-ын удирдамжид оруулах;</p> <p>2/ <u>өөрчлөлтийг баталгаажуулах</u>;</p> <p>3/ энэ дүрмийн Г Бүлгийн дагуу тухайн Маягийн гэрчилгээ эсхүл Маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээнд өөрчлөлт оруулах; эсхүл</p> <p>4/ энэ дүрмийн Д Бүлгийн дагуу Маягийн нэмэлт гэрчилгээ олгох.</p> <p>(б) <u>ИНЕГ</u>-ын дарга загварын өөрчлөлтийг дараах тохиолдолд хүлээн зөвшөөрнө:</p> <p>1/ техникийн үзүүлэлт нь энэ дүрмийн Хавсралт Г-д заасны дагуу байгаа бол;</p> <p>2/ НТЧ-ын гэрчилгээг олгох замаар зөвшөөрсөн бол.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>Amend.9-өөр нэмэгдсэн</p> |

| | | |
|---|--|------------------------------------|
| <p>эзэмшигч биш этгээд нь Е Бүлгийн дагуу нэмэлт маягийн гэрчилгээ эзэмших хэлбэрээр тухайн загварын өөрчлөлтийн зөвшөөрөл авах хүсэлтийг Даргад гаргаж болно.</p> | | |
| <p>21.75. Загварын өөрчлөлтийн хадгалалт Энэ Дүрэм хүчинтэй болохоос өмнө Даргын зөвшөөрсөн загварын өөрчлөлт бүрийг энэ Дүрмийн дагуу зөвшөөрсөнд тооцно.</p> | <p>21.75. Загварын өөрчлөлт хүчин төгөлдөр болох/ Continuation of design changes (a) ИНЕГ-ын дарга загварын өөрчлөлтийг энэ дүрмийн дагуу баталгаажуулсан үеэс эхлэн хүчин төгөлдөр болно.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |
| <p>21.77. НТЧ-ын хадгалалтын үүрэг хариуцлага Загварын өөрчлөлтийн нийцлийн мэдэгдэл гаргасан байгууллага нь тухайн өөрчлөлттэй холбоотой ИНД-146.61-д шаардсан НТЧ-ын хадгалалтын үүрэг хариуцлагыг хүлээнэ.</p> | <p>21.77. НТЧ-ын хадгалалтыг харууцах/ Continued airworthiness responsibilities (a) Энэ дүрмийн дагуу загварт өөрчлөлт оруулах тухай тодорхойлолт гаргасан зохион бүтээгч байгууллага нь НТЧ-ын хадгалалтыг хариуцна.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |
| <p>21.79. НТЧ-ын гэрчилгээ олгож загварын өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөх</p> <p>(a) Агаарын хөлөгт хийсэн загварын өөрчлөлтийг дараах тохиолдолд тухайн агаарын хөлөгт НТЧ-ын гэрчилгээ олгосноор хүлээн зөвшөөрч болно, хэрэв:</p> <p>(1) НТЧ-ын гэрчилгээ олгох үед, загварын өөрчлөлтийг агаарын хөлгийн техник үйлчилгээний бүртгэлд бүртгэсэн бол;</p> <p>(2) загварын өөрчлөлт нь хамааралтай НТЧ-ын шаардлагад нийцэж байгааг нотлох хангалттай баримт байгаа бол;</p> <p>(3) загварын өөрчлөлт нь Хавсралт С-д заасан агаарын хөлгийн холбогдох дуу чимээний болон хөдөлгүүрийн хийн ялгаруулалтын стандартад нийцэж байгааг нотлох хангалттай баримт байгаа бол.</p> <p>(b) Энэ дүрмийн дагуу хүлээн зөвшөөрсөн загварын өөрчлөлтийг зөвхөн НТЧ-ын гэрчилгээ олгосон агаарын хөлөгт хийж болно.</p> | <p>21.79 НТЧ-ын гэрчилгээ олгосноор загварын өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөх/Acceptance of design changes by the issue of an airworthiness certificate</p> <p>(a) Дараах шаардлагыг хангасан агаарын хөлөгт НТЧ-ын гэрчилгээ олгож агаарын хөлгийн загварын өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч болно:</p> <p>1/ НТЧ-ын гэрчилгээ олгох үед хийгдсэн загварын өөрчлөлтийг агаарын хөлгийн техникийн баримт бичигт тусгасан бол;</p> <p>2/ загварын өөрчлөлт нь НТЧ-ын холбогдох шаардлагад нийцсэнийг нотлох хангалттай баримт байгаа бол;</p> <p>3/ загварын өөрчлөлт нь Хавсралт В-д заасан агаарын хөлгийн дуу чимээний болон хөдөлгүүрээс гарах хийн ялгаруулалтын стандарт үзүүлэлттэй нийцсэнийг нотлох хангалттай баримт байгаа бол.</p> <p>(б) Энэ дүрмийн дагуу хүлээн зөвшөөрөгдсөн загварын өөрчлөлтийг зөвхөн НТЧ-ын гэрчилгээ олгогдсон тодорхой агаарын хөлөгт гүйцэтгэнэ.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |
| <p>21.81. Form САА 337-Модификацийн зөвшөөрөл Дарга энэ дүрмийн 21.505-ын дагуу тухайн модификацийн техникийн өгөгдлийг зөвшөөрснөөр модификацид зөвшөөрөл олгоно.</p> | <p>21.81 Өөрчлөлтийг баталгаажуулах ИНЕГ- 337 маягт/ Form САА 337 –approval of modifications (a) ИНЕГ-ын дарга нь энэ дүрмийн 21.505-д заасны дагуу тухайн өөрчлөлтийн техникийн үзүүлэлтийг батлах замаар өөрчлөлтийг баталгаажуулна.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |
| <p>D Бүлэг - Маягийн гэрчилгээ ба маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээний өөрчлөлт</p> | <p>Г БҮЛЭГ. МАЯГИЙН ГЭРЧИЛГЭЭ, МАЯГИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ГЭРЧИЛГЭЭНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ/ CHANGES TO TYPE CERTIFICATES AND TYPE ACCEPTANCE CERTIFICATES</p> | |
| <p>21.91. Зорилго Энэ Бүлэг нь маягийн гэрчилгээ болон маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээний өөрчлөлтийн зөвшөөрөл олгох зохицуулалтын шаардлагыг тогтооно.</p> | <p>21.91. Үйлчлэх хүрээ/ Scope (a) Маягийн гэрчилгээ болон Маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээний өөрчлөлтийг баталгаажуулах ажиллагааг энэ бүлгээр зохицуулна.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |

| | | |
|---|--|--|
| <p>21.93. Гэрчилгээний өөрчлөлт</p> <p>(a) Энэ Бүлгийн дагуу маягийн гэрчилгээнд оруулах өөрчлөлт нь дараах өөрчлөлтийг багтааж болно:</p> <ol style="list-style-type: none"> (1) маягийн гэрчилгээний категорийн; (2) маягийн загварын; (3) нислэгийн зааврын; (4) үйл ажиллагааны хязгаарлалтын; (5) маягийн гэрчилгээний өгөгдлийн хуудасны; <p>(б) маягийн гэрчилгээнд заасан онцгой нөхцөлийн;</p> <p>(b) Маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээний өөрчлөлтийг 21.95.(b)-гийн дагуу хийсэн байх ёстой.</p> | <p>21.93. Гэрчилгээнд өөрчлөлт оруулах/ Changes to certificates</p> <p>(a) Энэ бүлгийн дагуу Маягийн гэрчилгээнд оруулах өөрчлөлтөд дараах өөрчлөлтүүдийг багтааж болно:</p> <ol style="list-style-type: none"> 1/ Маягийн гэрчилгээний ангилал; 2/ маягийн загварын өөрчлөлт; 3/ нислэгийн зааврын өөрчлөлт; 4/ ашиглалтын хязгаарлалтын өөрчлөлт; 5/ Маягийн гэрчилгээний техникийн үзүүлэлтийг тодорхойлсон хавсралтын өөрчлөлт; 6/ Маягийн гэрчилгээнд заасан онцгой нөхцөлүүдийн өөрчлөлт. | <p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Amend.7 –оор нэмэгдсэн</p> |
| <p>21.95. Шинэ гэрчилгээ шаарддаг загварын өөрчлөлт</p> <p>(a) Загварын өөрчлөлтийн зөвшөөрөл авах хүсэлт гаргагч нь дараах тохиолдолд маягийн гэрчилгээ эзэмших хүсэлтийг шинээр гаргана:</p> <ol style="list-style-type: none"> (1) Дарга тухайн загвар, конфигураци, хөдөлгүүрийн хүч, хөдөлгүүрийн хүчний хязгаарлалт, хөдөлгүүрийн хурдны хязгаарлалт, эсхүл жинд санал болгосон өөрчлөлт нь НТЧ-ын шаардлагын хэрэгжилтийн өргөн хүрээний үзлэг шалгалт хийх шаардлагатай болохыг тогтоосон тохиолдолд; эсхүл (2) агаарын хөлгийн маягийн хувьд, санал болгосон өөрчлөлт нь: <ol style="list-style-type: none"> (i) хөдөлгүүрийн, эсхүл роторын тоонд; эсхүл (ii) татах хүчний өөр зарчмыг ашигладаг хөдөлгүүр, эсхүл роторт; эсхүл (iii) үйл ажиллагааны өөр зарчмыг ашигладаг роторт хамааралтай тохиолдолд; эсхүл (3) агаарын хөлгийн хөдөлгүүрийн маягийн хувьд, санал болгосон өөрчлөлт нь үйл ажиллагааны зарчимд хамааралтай тохиолдолд; эсхүл (4) сэнсний маягийн хувьд санал болгосон өөрчлөлт нь: <ol style="list-style-type: none"> (i) алганы тоонд; эсхүл (ii) алхмыг өөрчлөх ажиллагааны зарчимд; эсхүл (iii) алганы материалд хамааралтай тохиолдолд. <p>(b) Маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээний өөрчлөлтийн зөвшөөрөл авах хүсэлт гаргагч нь В Бүлгийн дагуу маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээ эзэмших хүсэлтийг шинээр гаргах ба хамааралтай НТЧ-ын шаардлагын дагуу маягийн гэрчилгээндээ оруулсан өөрчлөлтийг холбогдох гадаадын эрх</p> | <p>21.95. Шинээр гэрчилгээ шаардсан загварын өөрчлөлт/ Design changes requiring a new certificate</p> <p>(a) Загварын өөрчлөлтийг баталгаажуулах өргөдөл гаргагч этгээд нь дараах тохиолдолд Маягийн гэрчилгээ олгохыг хүссэн өргөдлийг шинээр гаргана:</p> <ol style="list-style-type: none"> 1/ ИНЕГ-ын дарга, бүтээгдэхүүний загвар, бүтцийн хийц, хөдөлгүүрийн хүч, эргэлтийн хэмжээ, тэдгээрийн хурдны хязгаарлалт болон жинд оруулах загварын өөрчлөлт нь НТЧ-ын шаардлага хангасан эсэхийг тогтоох нарийвчилсан судалгааг хийх шаардлагатай гэж үзсэн нөхцөлд; эсхүл, 2/ агаарын хөлгийн маягийн хувьд санал болгож буй өөрчлөлт нь: <ol style="list-style-type: none"> 2.1. ротор болон хөдөлгүүрийн тоог өөрчлөх бол; 2.2. хөдөлгүүр болон роторт хүчний өөр зарчмыг ашиглах бол; 2.3. роторт ашиглалтын өөр зарчмыг ашиглах бол; эсхүл, 3/ агаарын хөлгийн хөдөлгүүрийн маягийн хувьд өөрчлөлт оруулах санал нь ашиглалтын зарчимтай холбоотой бол; 4/ сэнсний маягийн хувьд санал болгож буй өөрчлөлт нь: <ol style="list-style-type: none"> 4.1. сэнсний алганы тоонд өөрчлөлт оруулах бол; 4.2. сэнсний алхмыг өөрчлөх зарчимд өөрчлөлт оруулах бол; 4.3. сэнсний алганы материалд өөрчлөлт оруулах бол. <p>(б) Маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээнд өөрчлөлт оруулах өргөдөл гаргагч нь энэ дүрмийн Б. Бүлэгт заасны дагуу Маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээний өргөдлийг шинээр гаргах ба НТЧ-ын холбогдох шаардлагын дагуу гадаадын улсын эрх бүхий байгууллагаас Маягийн гэрчилгээнд оруулсан өөрчлөлтийг</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Configuration- “бүтцийн хийц” гэснийг конфигураци болгож өөрчилсөн.</p> <p>-Орхигдуулсан “эсхүл” холбоосыг нөхөж оруулсан</p> |

| | | |
|--|---|------------------------------------|
| <p>бүхий байгууллага зөвшөөрсөн болохыг нотлох баримтыг Даргад хүргүүлнэ.</p> | <p>баталгаажуулсан нотлох баримтыг ИНЕГ-ын даргад ирүүлнэ.</p> | |
| <p>21.97. Маягийн гэрчилгээний өөрчлөлтийн хязгаарлалт Хүсэлт гаргагч нь дараах мэдээллийг Даргад хүргүүлснээс бусад тохиолдолд тухайн өөрчлөлтийг хийсний дараа маягийн гэрчилгээний зөвшөөрөгдсөн өөрчлөлт нь тодорхой конфигурацаар хязгаарлагдана: (1) зөвшөөрөл авахаар хүсэлт гаргасан маягтай ижил маягийн бусад конфигурацийг таньж тогтоох мэдээлэл; (2) өөрчлөлт нь бусад конфигурацитай тохирч байгааг нотлох баримт.</p> | <p>21.97 Маягийн гэрчилгээний өөрчлөлтөд тавигдах хязгаарлалт/ Limitations of changes to type certificates (а) Өргөдөл гаргагч нь ИНЕГ-ын даргад дараах мэдээллийг ирүүлээгүй бол тодорхой загварын хувьд хийгдсэн өөрчлөлтийг Маягийн гэрчилгээнд тусгахдаа хязгаарлалт хийнэ: 1/ зөвшөөрөл авах шаардлагатай ижил хийцээс өөр гэдгийг тодорхойлсон байх; 2/ тухайн өөрчлөлт нь өөр хийцийн хувьд ашиглахад тохиромжтой гэдгийг нотолсон байх.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |
| <p>21.99. Хүсэлт гаргах нөхцөл Маягийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах хүсэлтийг тухайн гэрчилгээг эзэмшигч гаргана.</p> | <p>21.99 Өргөдөл гаргах эрх/ Eligibility (а) Маягийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах өргөдөл гаргагч нь тухайн гэрчилгээний эзэмшигч байна.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |
| <p>21.101. Зөвшөөрөл авах, хүсэлт гаргах Маягийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах хүсэлт гаргагч нь дараах мэдээллийг шаардсан САА 24021/08 маягыг бөглөж, зохих төлбөрийн баримтын хамт Даргад хүргүүлнэ: (1) хүсэлт гаргагчийн нэр Монгол Улсад үйлчилгээ эрхлэх хаяг; (2) 21.505-д шаардсан мэдээлэл; (3) гэрчилгээнд хавсаргах тайлбар өгөгдөл; (4) маягтад үзүүлсний дагуу Даргын шаардаж болох тухайн бүтээгдэхүүн болон хүсэлт гаргагчтай холбоотой нэмэлт мэдээлэл.</p> | <p>21.101 Баталгаа авахаар өргөдөл гаргах/ Application for approval (а) Маягийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах өргөдөл гаргагч нь ИНЕГ-021/08 тоот өргөдлийн маягыг бөглөж, дараах мэдээллийн хамт ИНЕГ-ын даргад ирүүлнэ: 1/ Монгол улсад үйл ажиллагаа явуулах өргөдөл гаргагчийн нэр, хаяг; 2/ энэ дүрмийн 21.505-д шаардсан мэдээлэл; 3/ гэрчилгээнд тусгагдах үзүүлэлтүүд; 4/ ИНЕГ-ын дарга шаардлагатай гэж үзвэл өргөдөл гаргагчаас маягтад тусгагдсан бүтээгдэхүүнтэй холбоотой асуулгыг тодорхой болгох үүднээс нэмэлт тодруулгыг шаардаж болно; 5/ өргөдөл гаргагч нь энэ зүйлийн (а)-д шаардсан өргөдөлд төлбөрийн баримтыг хавсаргасан байна.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |
| <p>21.103. Маягийн гэрчилгээний өөрчлөлтийн зөвшөөрөл Дараах нөхцөлд Дарга маягийн гэрчилгээний өөрчлөлтийг дараах тохиолдолд зөвшөөрч болох ба хүсэлт гаргагч нь маягийн гэрчилгээний өөрчлөлтийн зөвшөөрөл авах эрхтэй, хэрэв: (1) хүсэлт гаргагч нь энэ Бүлгийн холбогдох шаардлагыг Даргын хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр хангасан бол; (2) маягийн гэрчилгээний өөрчлөлт нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлахгүй бол; (3) агаарын хөлгийг зориулалтын дагуу үргэлжлүүлэн ашиглахад, хангаагүй НТЧ-ын шаардлагыг Даргын хүлээн зөвшөөрөхүйц аюулгүй байдлын түвшнийг хангасан хүчин зүйлээр нөхсөн бол; (4) хэрэв зөв нэмж өөрчилсөн нислэгийн заавар, эсхүл бусад</p> | <p>21.103 Маягийн гэрчилгээнд оруулах өөрчлөлтийг баталгаажуулах/ Approval of change to type certificate (а) ИНЕГ-ын дарга дараах шаардлагыг хангасан тохиолдолд Маягийн гэрчилгээнд оруулах өөрчлөлтийг баталгаажуулна: 1/ өргөдөл гаргагч нь энэ бүлэгт заасан шаардлагуудыг ИНЕГ-ын даргын хүлээн зөвшөөрөхүйц хэмжээнд хангасан; 2/ Маягийн гэрчилгээнд өөрчлөлт оруулснаар нисэхийн аюулгүй байдалнд харшлахгүй байх нөхцөлийг хангасан; 3/ аль нэг НТЧ-ын шаардлагыг хангахгүй байгаа боловч, ИНЕГ-ын даргын хүлээн зөвшөөрөхүйц адилтгах хэмжээний аюулгүй ажиллагааны түвшинг зохих хүчин зүйлээр нөхөж хангасан; 4/ өөрчлөлт хийгдсэн бүтээгдэхүүнийг нислэгийн заавар, түүнд</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |

| | | |
|---|--|---|
| <p>тогтоосон хязгаарлалтын хүрээнд зориулалтын дагуу ашиглахад өөрчлөгдсөн бүтээгдэхүүнийг аюултай болгох хэв шинж, эсхүл үзүүлэлтгүй бол.</p> | <p>оруулсан өөрчлөлт, хязгаарлалтын дагуу ашиглахад загварын онцлог болон нислэгийн үзүүлэлтийн хувьд аюулгүй.</p> | |
| <p>Е Бүлэг-Нэмэлт маягийн гэрчилгээ</p> | <p>Д БҮЛЭГ. НЭМЭЛТ МАЯГИЙН ГЭРЧИЛГЭЭ/ SUPPLEMENTAL TYPE CERTIFICATES</p> | |
| <p>21.111. Зорилго Энэ Бүлэг нь: (1) нэмэлт маягийн гэрчилгээ олгох зохицуулалтын шаардлага; (2) нэмэлт маягийн гэрчилгээ эзэмшигчийн үүрэг хариуцлагыг тогтооно.</p> | <p>21.111. Үйлчлэх хүрээ/ Scope (a) Нэмэлт маягийн гэрчилгээ олгох болон түүнийг эзэмшигчийн хүлээх үүргийг энэ бүлэгт тогтооно.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |
| <p>21.113. Нэмэлт маягийн гэрчилгээ Энэ Бүлгийн дагуу олгосон нэмэлт маягийн гэрчилгээ нь дараах маяг, эсхүл нөхцөл байдалд өөрчлөлт оруулахыг зөвшөөрч болно: (1) маягийн гэрчилгээний категорид, эсхүл маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээний категорид; эсхүл (2) маягийн загварт; эсхүл (3) нислэгийн зааварт; эсхүл (4) үйл ажиллагааны хязгаарлалтад; эсхүл (5) маягийн гэрчилгээ, эсхүл маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээнд заасан тусгай нөхцөлд; эсхүл (6) бүтээгдэхүүний маягийн гэрчилгээ эзэмшдэггүй этгээд тухайн бүтээгдэхүүнд том хэмжээний модификаци хийхээр төлөвлөж байгаа үед; эсхүл (7) этгээд нь арилжааны зорилгоор нэмэлт маягийн гэрчилгээ эзэмшихийг хүсэж байгаа үед (жишээ нь, хүсэлт гаргагч хоёрдогч этгээдэд худалдах тал бол, эсхүл гадаадын эрх бүхий байгууллага хүлээн зөвшөөрөх зорилгоор тухайн гэрчилгээг шаардсан бол)</p> | <p>21.113. Нэмэлт маягийн гэрчилгээ/ Supplemental type certificate (a) Энэ бүлгийн дагуу нэмэлт маягийн гэрчилгээ олгосноор дараах зүйлд өөрчлөлт хийгдэж болно:</p> <ol style="list-style-type: none"> 1/ Маягийн гэрчилгээ, эсхүл Маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээний ангилалд; 2/ маягийн загварт; 3/ Нислэгийн зааварт; 4/ ашиглалтын хязгаарлалтад; 5/ Маягийн гэрчилгээ, эсхүл Маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээнд заасан тусгай нөхцөлүүдэд. | <p>-Орчуулга, найруулга зассан -2017 оны Amend.9-өөр шинээр нэмэгдсэн.</p> |
| <p>21.115. Хүсэлт гаргах нөхцөл Аливаа этгээд нь нэмэлт маягийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргаж болно.</p> | <p>21.115. Өргөдөл гаргах эрх/Eligibility (a) Нэмэлт маягийн гэрчилгээ авах өргөдлийг аливаа этгээд гаргаж болно.</p> | |
| <p>21.117. Гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах Нэмэлт маягийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь САА 24021/09 маягтыг бөглөж, дараах мэдээллийн хамт Даргад хүргүүлэх үүрэгтэй: (1) хүсэлт гаргагчийн нэр Монгол Улсад үйлчилгээ эрхлэх хаяг; (2) дараах дүрэмд шаардсан мэдээлэл: (i) 21.33;</p> | <p>21.117 Өргөдөл гаргах/ Application for certificate (a) Өргөдөл гаргагч нь нэмэлт маягийн гэрчилгээ авах өргөдлийг ИНЕГ-021/09 маягтын дагуу гаргаж, дараах мэдээллийн хамт ИНЕГ-ын даргад ирүүлнэ: 1/ Монгол Улсад үйл ажиллагаа явуулах өргөдөл гаргагчийн нэр, хаяг; 2/ энэ дүрмийн 21.33, 21.35 болон 21.509 (a)-д шаардсан мэдээлэл;</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |

| | | |
|---|---|---|
| <p>(ii) 21.35; (iii) 21.505(a); (iv) 21.32 хэрэв санал болгосон өөрчлөлт нь агаарын хөлгийн дуу чимээ, эсхүл хөдөлгүүрийн хийн ялгаруулалтын түвшинд нөлөөлөх бол; (3) маягтад үзүүлсний дагуу Даргын шаардаж болох, тухайн загварын өөрчлөлт болон хүсэлт гаргагчтай холбоотой нэмэлт мэдээлэл; (4) зохих төлбөрийн баримт;</p> | <p>3/ хэрэв санал болгож буй өөрчлөлт нь агаарын хөлгийн дуу чимээний болон хөдөлгүүрээс гарах хийн ялгаруулалтын түвшинд нөлөөлөх бол 21.32-д шаардсан мэдээлэл; 4/ ИНЕГ-ын дарга шаардлагатай гэж үзвэл өргөдөл гаргагчаас маягтанд тусгагдсан загварын өөрчлөлттэй холбоотой асуулгыг тодорхой болгох үүднээс нэмэлт тодруулгыг шаардаж болно; 5/ өргөдөл гаргагч нь энэ зүйлийн (а)-д шаардсан өргөдөлд төлбөрийн баримтыг хавсаргасан байна.</p> | |
| <p>21.119. Гэрчилгээ олгох (а) Хэрэв Дарга дараах шаардлага хангагдсан гэж үзвэл, хүсэлт гаргагч нь нэмэлт маягийн гэрчилгээ эзэмших эрхтэй ба Дарга бүтээгдэхүүн, эсхүл бүтээгдэхүүний маягт нэмэлт маягийн гэрчилгээ олгож болно: (1) хүсэлт гаргагч нь энэ Бүлгийн холбогдох шаардлагыг хангасан байх; (2) тухайн гэрчилгээг олгох нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлахгүй байх; (3) хангаагүй НТЧ-ын шаардлагыг аюулгүй байдлын дүйцэх түвшнийг хангасан хүчин зүйлээр нөхсөн байх; (4) хэрэв өөрчлөгдсөн бүтээгдэхүүн нь зөв нэмж өөрчилсөн нислэгийн заавар, эсхүл бусад тогтоосон хязгаарлалтын хүрээнд ажиллаж байгаа бол түүнийг зориулалтын дагуу ашиглахад аюултай болгох хэв шинж, эсхүл үзүүлэлтгүй байх. (б) Энэ Бүлгийн дагуу Даргын олгосон гэрчилгээнд тодорхой тохиолдол бүрд Даргын шаардлагатай гэж үзсэн нөхцөлийг зааж өгч болно.</p> | <p>21.119. Гэрчилгээ олгох/ Issue of certificate (а) ИНЕГ-ын дарга дараах шаардлагыг хангасан тохиолдолд нэмэлт маягийн гэрчилгээ олгоно: 1/ энэ бүлгийн холбогдох шаардлагуудыг хангасан; 2/ гэрчилгээ олгосноор нисэхийн аюулгүй байдалнд харшлахгүй байх нөхцөлийг хангасан; 3/ аль нэг НТЧ-ын шаардлагыг хангахгүй байгаа боловч түүнтэй адилтгах хэмжээний аюулгүй ажиллагааны түвшинг зохих хүчин зүйлээр нөхөж хангасан өөрчлөлт хийгдсэн бүтээгдэхүүнийг, 4/ Нислэгийн зааварт эсхүл бусад хязгаарлалтуудад зөв хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийн дагуу ашиглахад загварын онцлог болон нислэгийн үзүүлэлтийн хувьд аюулгүй. (б) ИНЕГ-ын дарга энэ бүлгийн дагуу гэрчилгээг олгохдоо шаардлагатай гэж үзвэл тусгай нөхцөлийг зааж өгч болно.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |
| <p>21.121. Гэрчилгээг шилжүүлэх (а) Нэмэлт маягийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээг 21.123-т заасан үүрэг хариуцлагыг хүлээх чадвартай болохыг Дарга хүлээн зөвшөөрсөн этгээд, эсхүл байгууллагаас бусад этгээдэд эсхүл байгууллагад шилжүүлэхийг зөвшөөрөхгүй. (б) Нэмэлт маягийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээг шилжүүлэхийн өмнө: (1) шилжүүлэн авагчийн нэр Монгол Улсад үйлчилгээ эрхлэх хаягийг Даргад бичгээр мэдэгдэнэ;</p> | <p>21.121. Гэрчилгээг шилжүүлэх/ Transfer of certificate (а) Нэмэлт маягийн гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээг ИНЕГ-ын даргын зөвшөөрсөн, энэ дүрмийн 21.123-т заасан үүргийг гүйцэтгэж чадах этгээдэд шилжүүлж болно. (б) Гэрчилгээг шилжүүлэхээс өмнө Маягийн гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангасан байна: 1/ гэрчилгээг шилжүүлэн авч буй этгээдийн нэр, хаягийг ИНЕГ-</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |

| | | |
|---|--|---|
| <p>(2) нэмэлт өөрчлөлт оруулахаар гэрчилгээг Даргад хүргүүлнэ.</p> | <p>ын даргад бичгээр мэдэгдэнэ; 2/ өөрчлөлт оруулахаар гэрчилгээг ИНЕГ-ын даргад ирүүлнэ.</p> | |
| <p>21.123. Гэрчилгээ эзэмшигчийн үүрэг хариуцлага (a) Нэмэлт маягийн гэрчилгээ эзэмшигч нь: (1) маягийн гэрчилгээтэй бүтээгдэхүүний өөрчлөлтийн хувьд, ИНД-146.61-д шаардсан НТЧ-ын хадгалалтын үүрэг хариуцлагыг хүлээнэ; (2) Даргын хүсэлтээр, тухайн бүтээгдэхүүний маягийн гэрчилгээ эзэмшигчтэй зохих харилцаа холбоотой болохоо нотлох баримтыг хүргүүлнэ; (3) дараах шаардлагыг хангасан болохыг бататгана: (i) бүх бүртгэл нь гаргацтай байнгын арилдаггүй байх; (ii) энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, бүтээгдэхүүний загвар, эсхүл загварын өөрчлөлтийн бүртгэлийг тухайн маягийн бүтээгдэхүүний сүүлчийн загварыг ашиглалтаас бүрмөсөн хассанаас хойш 2 жилийн хугацаанд хадгалдаг байх; (4) Даргын хүсэлтээр, тухайн гэрчилгээ, загварын мэдээлэл, зураг, тестийн тайлан болон үзлэг шалгалтын бүртгэлийг Даргад хүргүүлнэ. (b) Дарга бүртгэлийг энэ зүйлийн (a)(3)(ii)-т шаардсанаас бага хугацаагаар хадгалахыг зөвшөөрч болно.</p> | <p>21.123 Гэрчилгээ эзэмшигчийн үүрэг/ Responsibilities of certificate holder (a) Нэмэлт маягийн гэрчилгээ эзэмшигч дараах үүрэгтэй: 1/ Маягийн гэрчилгээ олгосон бүтээгдэхүүнд өөрчлөлт оруулахдаа НТЧ-ын хадгалалтыг хариуцах; 2/ ИНЕГ-ын дарга шаардсан тохиолдолд бүтээгдэхүүний маягийн гэрчилгээ эзэмшигчтэй харилцаа холбоотой ажиллаж байгааг нотолсон баримтыг ирүүлэх; 3/ дараах зүйлийг бататгах: 3.1. бүх бүртгэл нь тодорхой, гаргацтай, тогтсон загварт байгаа эсэх 3.2. энэ зүйлийн (б)-д зааснаас бусад тохиолдолд бүтээгдэхүүний загвар, загварын өөрчлөлттэй холбоотой бүртгэл тэмдэглэлийг тухайн бүтээгдэхүүнийг ашиглалтаас хассанаас хойш 2 жилийн хугацаанд хадгалдаг байх. 4/ ИНЕГ-ын дарга шаардсан тохиолдолд, гэрчилгээ болон загварын талаарх мэдээлэл, техникийн зураг, үзлэг шалгалтын тайланг ИНЕГ-ын даргад хүргүүлнэ. (б) ИНЕГ-ын дарга техникийн баримт бичгийн хадгалах хугацааг энэ зүйлийн (a) 3/ 3.2-т заасан хугацаанаас бага байхаар тогтоож болно.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |
| <p>21.125. Гэрчилгээний өөрчлөлт Гэрчилгээнд заасан загварын өөрчлөлтөд томоохон өөрчлөлт оруулахаар төлөвлөж байгаа нэмэлт маягийн гэрчилгээ эзэмшигч нь: (1) нэмэлт маягийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлтийг САА 24021/09 маягтаар гаргана; эсхүл (2) шинэ нэмэлт маягийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргана.</p> | <p>21.125. Гэрчилгээнд өөрчлөлт оруулах/ Changes to certificate (a) Нэмэлт маягийн гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээнд заасан бүтээгдэхүүний загварт томоохон өөрчлөлт оруулах тохиолдолд: 1/ нэмэлт маягийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах ИНЕГ-021/09 маягыг бөглөж ирүүлэх; эсхүл, 2/ шинээр нэмэлт маягийн гэрчилгээ авах хүсэлтийг гаргана.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |
| <p>F Бүлэг - Урьдчилсан маягийн гэрчилгээ 21.141. Зорилго Энэ Бүлэг нь, бүтээгдэхүүний маягт урьдчилсан маягийн гэрчилгээ олгох болон түүнд нэмэлт өөрчлөлт оруулах зохицуулалтын шаардлагыг тогтооно. 21.143. Гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах Урьдчилсан маягийн гэрчилгээ эзэмших, эсхүл урьдчилсан маягийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлт гаргагч нь хүсэлтийг зохих төлбөрийн баримтын хамт Даргад хүргүүлэх үүрэгтэй.</p> | | <p>2007 онд Amend. 7-оор нэмэлт өөрчлөлт орсон.</p> |

21.145. Гэрчилгээ олгох

(a)Хэрэв Дарга дараах шаардлага хангагдсан гэж үзвэл, хүсэлт гаргагч нь урьдчилсан маягийн гэрчилгээ, эсхүл урьдчилсан маягийн гэрчилгээний нэмэлт өөрчлөлтийг авах эрхтэй ба Дарга урьдчилсан маягийн гэрчилгээ, эсхүл урьдчилсан маягийн гэрчилгээний нэмэлт өөрчлөлтийг олгож болно:

(1)хүсэлт гаргагч нь тухайн бүтээгдэхүүний маягийн гэрчилгээ, эсхүл нэмэлт маягийн гэрчилгээний аль тохирохыг эзэмшдэг, эсхүл эзэмших хүсэлт гаргасан байх;

(2)хүсэлт гаргагч нь энэ Бүлгийн холбогдох шаардлагыг хангасан байх;

(3)урьдчилсан маягийн гэрчилгээ олгох, эсхүл урьдчилсан маягийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлахгүй байх.

(b)Энэ Бүлгийн дагуу Даргын олгосон урьдчилсан маягийн гэрчилгээнд тодорхой тохиолдол бүрд Даргын шаардлагатай гэж үзсэн нөхцөлийг зааж өгч болно.

21.147. Урьдчилсан маягийн гэрчилгээжүүлэлтийн шаардлага

(a)Урьдчилсан маягийн гэрчилгээ эзэмших, эсхүл урьдчилсан маягийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлт гаргагч нь дараах нотлох баримтыг Даргад хүргүүлэх үүрэгтэй:

(1)бүтээгдэхүүнийг энэ зүйлийн (b)(1)-д тогтоосон хязгаарлалтын дагуу ашиглахад түүнийг аюултай болгох хэв шинж, үзүүлэлт, эсхүл нөхцөл байхгүй болохыг;

(2)бүтээгдэхүүнийг хүсэлт гаргагчийн эзэмшиж байгаа, эсхүл эзэмшихээр хүсэлт гаргасан маягийн гэрчилгээ, эсхүл нэмэлт маягийн гэрчилгээ олгохтой холбоотой НТЧ-ын шаардлагын дагуу зохион бүтээж, үйлдвэрлэсэн болохыг;

(3)бүтээгдэхүүнийг энэ зүйлийн (b)(1)-д тогтоосон үйл ажиллагааны зохих хязгаарлалтын хүрээнд аюулгүй ашиглаж болохыг;

(4)агаарын хөлгийн маягийн хувьд:

(i) тухайн агаарын хөлөг нь хүсэлт гаргагчийн эзэмшиж байгаа эсхүл эзэмших хүсэлт гаргасан маягийн гэрчилгээ, эсхүл нэмэлт маягийн гэрчилгээний нислэгийн үзүүлэлтийн холбогдох шаардлагын ихэнхийг хангасан болохыг;

(ii)тухайн агаарын хөлөг нь хүсэлт гаргагчийн эзэмшиж байгаа эсхүл хүсэлт гаргасан маягийн гэрчилгээ, эсхүл

2007 онд Amend. 7-
оор нэмэлт
өөрчлөлт орсон.

| | | |
|---|---|------------------------------------|
| <p><u>нэмэлт маягийн гэрчилгээ олгох нислэгийн шаардлагад нийцэж байгааг харуулахад шаардлагатай бүх маневрыг гүйцэтгэсэн болохыг;</u> <u>(iii) тухайн агаарын хөлгийг ИНД-д заасан холбогдох хязгаарлалтын дагуу аюулгүй ашиглаж болохыг.</u></p> <p><u>(b) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:</u> <u>(1) жин, хурд, нислэгийн маневр, ачаалал, удирдлага болон төхөөрөмжийн үйл ажиллагааны хязгаарлалтыг багтаасан, хүсэлт гаргагчийн эзэмшиж байгаа эсхүл эзэмшихээр хүсэлт гаргасан маягийн гэрчилгээ, эсхүл нэмэлт маягийн гэрчилгээ олгоход шаардагдах хязгаарлалтыг тогтоох;</u> <u>(2) бүтээгдэхүүний НТЧ-ын хадгалалтын үзлэг шалгалтын болон техник үйлчилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх.</u></p> <p><u>(c) Агаарын хөлгийн маягт урьдчилсан маягийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, энэ зүйлийн (b)(1)-ийн дагуу тогтоогоогүй агаарын хөлгийн хязгаарлалт бүрд тавих зохих үйл ажиллагааны хязгаарлалтыг харуулах үүрэгтэй.</u></p> <p><u>(d) Агаарын хөлгийн маягт урьдчилсан маягийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь агаарын хөлгийн маягийн анхны загварыг дараах гэрчилгээний эрхийн хүрээнд 50-аас доошгүй цаг ниссэнийг нотлох үүрэгтэй:</u> <u>(1) тусгай категорин-түршилтын НТЧ-ын гэрчилгээ; эсхүл</u> <u>(2) Монгол, Европын холбоо, Оросын Холбооны Улс, Австрали, Канад, Нэгдсэн Вант Улс эсхүл Америкийн Нэгдсэн Улсын (АНУ) зэвсэгт хүчний хяналтад.</u></p> <p><u>(e) Хэрэв тухайн хүсэлт нь урьдчилсан маягийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлт бол, Дарга энэ зүйлийн (d)-д заасан нислэгийн цагийг багасгах шийдвэрийг бичгээр гаргаж болно.</u></p> <p>21.149. Хугацаа</p> <p><u>(a) Тухайн гэрчилгээг түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосноос бусад тохиолдолд урьдчилсан маягийн гэрчилгээ нь олгосон өдрөөс хойш 24 сараас ихгүй, байх ёстой ба хүчинтэй хугацаа дуусах хүртэл хүчинтэй хэвээр байна.</u></p> <p><u>(b) Урьдчилсан маягийн гэрчилгээний нэмэлт өөрчлөлт нь энэ зүйлийн (a)-д заасан урьдчилсан маягийн гэрчилгээний хүчинтэй байх хугацаанд хүчинтэй хэвээр байна.</u></p> | | |
| <p>G Бүлэг-Нөөц</p> | | |
| <p>H Бүлэг-НТЧ-ын гэрчилгээ</p> | <p>E БҮЛЭГ. НИСЛЭГТ ТЭНЦЭХ ЧАДВАРЫН ГЭРЧИЛГЭЭ/ AIRWORTHINESS CERTIFICATES</p> | |
| <p>21.171. Зорилго Энэ Бүлэг нь агаарын хөлгийн НТЧ-ын гэрчилгээжүүлэлтийн</p> | <p>21.171. Үйлчлэх хүрээ/ Scope (a) Энэ бүлгээр Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлөгт НТЧ-ын</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |

| | | |
|---|--|---|
| <p>зохицуулалтын шаардлагыг тогтооно.</p> <p>21.173. Гэрчилгээний категори Дарга, Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөгт Хууль болон энэ Бүлгийн холбогдох шаардлагын дагуу дараах НТЧ-ын гэрчилгээ олгоно:</p> <ol style="list-style-type: none"> (1) стандарт категорийн; (2) хязгаарлалттай категорийн; (3) тусгай категорийн туршилтын; (4) тусгай категорийн үзүүлбэрийн; (5) тусгай категорийн сонирхогчийн бүтээсэн; (6) тусгай категорийн анхдагч; (7) тусгай категорийн спортын хөнгөн агаарын хөлгийн (LSA); (8) тусгай категорийн хязгаарлагдмал; (9) урьдчилсан категори. | <p>гэрчилгээ олгохтой холбогдсон үйл ажиллагааг зохицуулна.</p> <p>21.173. НТЧ-ын гэрчилгээний ангилал/ Airworthiness certificate categories</p> <p>(а) ИНЕГ-ын дарга энэ бүлгийн дагуу дараах ангиллын НТЧ-ын гэрчилгээг олгоно:</p> <ol style="list-style-type: none"> 1/ Стандарт ангиллын НТЧ-ын гэрчилгээ; 2/ Хязгаарлагдмал ангиллын НТЧ-ын гэрчилгээ; 3/ Тусгай ангиллын туршилтын НТЧ-ын гэрчилгээ; 4/ Тусгай ангиллын - тусгай нислэгийн зөвшөөрлийн НТЧ-ын гэрчилгээ. <p>(б) ИНЕГ-ын дарга НТЧ-ын гэрчилгээнд агаарын хөлгийн ашиглалттай холбоотой нөхцөл, хязгаарлалт болон гэрчилгээний зорилгыг зааж өгнө.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Категориуд Amend 7-оор 6, 8-аар 9 болж нэмэгдсэн</p> |
| <p>21.175. Гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах Агаарын хөлгийн НТЧ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах холбогдох маягтыг бөглөж, зохих төлбөрийн баримтын хамт Даргад хүргүүлэх үүрэгтэй:</p> <ol style="list-style-type: none"> (1) маягт САА 24021/05-стандарт, эсхүл хязгаарлалттай категорид; (2) маягт САА 24021/06-тусгай категорид; (3) маягт САА 24021/14 урьдчилсан категорид. | <p>21.175. Өргөдөл гаргах/ Application for certificate</p> <p>(а) НТЧ-ын гэрчилгээ авах өргөдөл гаргагч нь дараах өргөдлийн маягтаас өөрт хамаарах маягтыг бөглөж, төлбөрийн баримтын хамт ИНЕГ-ын даргад ирүүлнэ:</p> <ol style="list-style-type: none"> 1/ өргөдлийн маягт ИНЕГ-021/05-Стандарт, эсхүл Хязгаарлагдмал ангиллын НТЧ-ын гэрчилгээ; 2/ өргөдлийн маягт ИНЕГ-021/06 - Тусгай ангиллын туршилтын НТЧ-ын гэрчилгээ; 3/ өргөдлийн маягт ИНЕГ-021/07 - Тусгай ангиллын-тусгай нислэгийн зөвшөөрлийн НТЧ-ын гэрчилгээ. | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |
| <p>21.177. Гэрчилгээ олгох тусгай нөхцөл</p> <p>(а) Хэрэв Дарга дараах шаардлага хангагдсан гэж үзвэл, агаарын хөлөгт стандарт категорийн болон хязгаарлалттай категорийн НТЧ-ын гэрчилгээг хамт олгож болно:</p> <ol style="list-style-type: none"> (1) агаарын хөлгийг тухайн категорийн конфигурацид шилжүүлэх үед энэ Бүлгийн категори бүрийн холбогдох гэрчилгээжүүлэлтийн шаардлагыг хангасан байх; (2) төхөөрөмжийг энгийн механик аргаар салгах эсхүл нэмснээр тухайн агаарын хөлгийг нэг конфигурацаас нөгөөд шилжүүлэх боломжтой байх. <p>(б) Хэрэв Дарга дараах шаардлага хангагдсан гэж үзвэл, тухайн агаарын хөлөгт зөвхөн хязгаарлалттай категорийн НТЧ-ын гэрчилгээ олгож болно:</p> <ol style="list-style-type: none"> (1) тухайн агаарын хөлгийн дотор талд ХАА-н агаарын хөлгийн үйл ажиллагаанд зориулж бодис цацахаар | <p>21.177. Гэрчилгээ олгох/ Issue of certificate</p> <p>(а) Энэ зүйлийн (б) болон (в)-ийн нөхцөлөөр өргөдөл гаргагч нь гэрчилгээжүүлэлтийн шаардлагыг хангасан тохиолдолд ИНЕГ-ын дарга дараах НТЧ-ын гэрчилгээг олгоно:</p> <ol style="list-style-type: none"> 1/ Стандарт ангиллын НТЧ-ын гэрчилгээ; 2/ Хязгаарлагдмал ангиллын НТЧ-ын гэрчилгээ. <p>(б) ИНЕГ-ын дарга дараах шаардлагыг хангасан өргөдөл гаргагчид стандарт болон хязгаарлагдмал ангиллын НТЧ-ын гэрчилгээг хамт олгож болно:</p> <ol style="list-style-type: none"> 1/ агаарын хөлөг нь хийцийн хувьд аль ч ангилалд хамаарч болох бөгөөд энэ бүлгийн ангилал тус бүрийн | <p>-Орчуулга, найруулга зассан.</p> |

| | | |
|---|--|--|
| <p>тоноглон байх; (2) дотоод төхөөрөмж нэмж суурилуулснаар тухайн агаарын хөлгийг агаарын тээврийн үйл ажиллагаанд ашиглахад тохиромжтой болгосон байх.</p> <p>(с) Хэрэв <u>Дарга</u> дараах шаардлага хангагдсан гэж үзвэл тухайн агаарын хөлөгт 21.173-т заасан тусгай <u>категориудаас</u> зөвхөн нэгээр нь НТЧ-ын гэрчилгээ олгож болно: (1) агаарын хөлөг нь үйл ажиллагаа гүйцэтгэх зориулалтын хувьд, энэ Бүлгийн холбогдох гэрчилгээжүүлэлтийн шаардлагыг хангасан байх; (2) агаарын хөлөг нь аюулгүй ажиллах нөхцөлд байх.</p> <p><u>(д) Дарга НТЧ-ын гэрчилгээнд тухайн гэрчилгээний зорилго болон тухайн агаарын хөлгийн үйл ажиллагаанд холбогдох нөхцөл хязгаарлалтыг зааж өгч болно.</u></p> | <p>гэрчилгээжүүлэлтийн шаардлагуудыг хангасан бол; 2/ агаарын хөлөгт энгийн механик аргаар тоног төхөөрөмж суурилуулах, эсхүл агаарын хөлгийн хийц нь нэг бүтцээс нөгөө бүтцэд шилжиж чаддаг бол.</p> <p>(в) Өргөдөл гаргагчийн агаарын хөлөг нь хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглахаар тоноглогдсон тохиолдолд зөвхөн хязгаарлагдмал ангиллын НТЧ-ын гэрчилгээг олгох ба зорчигч тээврийн зориулалтаар ашиглахыг хориглоно.</p> <p>(г) Дараах шаардлагыг хангасан өргөдөл гаргагчид Тусгай ангиллын туршилтын НТЧ-ын гэрчилгээ олгоно: 1/ агаарын хөлөг нь ашиглалтын зорилготой холбоотой энэ дүрмийн гэрчилгээжүүлэлтийн шаардлагуудыг хангасан бол; 2/ аюулгүй ажиллагааны түвшин нь агаарын хөлгийн ашиглалтын зорилгод нийцсэн бол.</p> <p><u>(д) Дараах шаардлагыг хангасан өргөдөл гаргагчид Тусгай ангиллын-тусгай нислэгийн зөвшөөрлийн НТЧ-ын гэрчилгээг олгоно:</u> <u>1/ энэ бүлгийн гэрчилгээжүүлэлтийн холбогдох шаардлагуудыг хангасан бол;</u> <u>2/ агаарын хөлөг нь техникийн дутагдалтай боловч НТЧ-ын болон техник үйлчилгээний зохих шаардлагуудыг хангаж, дор заасан аль нэг зорилгоор нислэг үйлдэхэд аюулгүй ажиллагааны түвшин нь нийцсэн бол:</u> <u>2.1. агаарын хөлөгт техник үйлчилгээ хийх эсхүл хадгалалтад оруулах зорилгоор техник үйлчилгээний төв рүү хийх нислэг;</u> <u>2.2. ИНД-148-ын дагуу гэрчилгээжсэн үйлдвэрлэгч байгууллагаас шинээр үйлдвэрлэсэн агаарын хөлгийг шалгах нислэг;</u> <u>2.3. аюул нүүрлэсэн бүсээс агаарын хөлгийг нүүлгэн шилжүүлэх нислэг;</u> <u>2.4. агаарын хөлөгт НТЧ-ын гэрчилгээ олгоход нийцсэнийг баталж үзүүлэх нислэг.</u></p> <p><u>(е) Энэ бүлгийн гэрчилгээжүүлэлтийн холбогдох шаардлагуудыг хангасан болон агаарын хөлгийн аюулгүй ажиллагааны түвшин нь ашиглалтын зорилгод нийцсэн өргөдөл гаргагчид ИНЕГ-ын дарга тусгай нислэгийн зөвшөөрлийн НТЧ-ын гэрчилгээ олгоно.</u></p> | <p>-2007 онд Amend. 7-оор нэмэлт өөрчлөлт орсон.</p> |
| <p>21.179. Гэрчилгээний хугацаа</p> | <p>21.179. Гэрчилгээний хугацаа/ Duration of certificate (a) Агаарын хөлгийн техник үйлчилгээ нь ИНД-91 болон ИНД-43-ын</p> | |

(a) Хэрэв тухайн агаарын хөлөгт ИНД-91, ИНД-43-ын холбогдох шаардлагын дагуу техник үйлчилгээг гүйцэтгэсэн бол гэрчилгээний хугацаа дууссан, эсхүл түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосноос бусад тохиолдолд, агаарын хөлгийн дараах НТЧ-ын гэрчилгээ хүчинтэй хэвээр байна:

- (1) стандарт [категори](#);
- (2) хязгаарлалттай [категори](#);
- (3) тусгай [категори](#).

(b) Агаарын хөлгийн стандарт [категорийн](#) НТЧ-ын гэрчилгээ болон агаарын хөлгийн хязгаарлалттай [категорийн](#) НТЧ-ын гэрчилгээ нь дараах тохиолдолд хүчингүй болно:

- (1) агаарын хөлгийг Монгол Улсын бүртгэлээс хассан; эсхүл
- (2) агаарын хөлөг, түүний хөдөлгүүрт болон хэрэв хамааралтай бол, сэнсэнд олгосон маягийн гэрчилгээ, эсхүл маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээний аль хамааралтай нь хүчингүй болсон; эсхүл
- (3) агаарын хөлгийн хувьд, ижил категорид шинэ НТЧ-ын гэрчилгээ олгосон.

(c) Агаарын хөлгийн тусгай [категорийн](#) НТЧ-ын гэрчилгээ дараах тохиолдолд хүчингүй болно:

- (1) агаарын хөлгийг Монгол Улсын бүртгэлээс хассан; эсхүл
- (2) агаарын хөлгийн хувьд, ижил категорид шинэ НТЧ-ын гэрчилгээ олгосон.

(d) НТЧ-ын гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (b), эсхүл (c)-гийн дагуу гэрчилгээний хугацаа дууссан тохиолдолд гэрчилгээг [Даргад хураалгах үүрэгтэй](#).

(e) Стандарт [категорийн](#) НТЧ-ын гэрчилгээ, эсхүл хязгаарлалттай [категорийн](#) НТЧ-ын гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (b)(2)-ын дагуу гэрчилгээний хугацаа дууссан тохиолдолд, тухайн агаарын хөлөгт 21.175-ын дагуу зохих тусгай [категорийн](#) НТЧ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргаж болно.

(f) [Агаарын хөлгийн урьдчилсан категорийн НТЧ-ын гэрчилгээ нь дараах тохиолдолд тухайн гэрчилгээнд заасан хугацаанд хүчинтэй хэвээр байна:](#)

- (1) хэрэв:
 - (i) агаарын хөлгийн техник үйлчилгээг ИНД-91, ИНД-43-ын холбогдох шаардлагын дагуу хийсэн бол;
 - (ii) агаарын хөлөг нь Монгол Улсын бүртгэлтэй хэвээр байгаа бол;
 - (iii) 21.145-ын дагуу тухайн агаарын хөлгийн маягт олгосон урьдчилсан маягийн гэрчилгээ нь хүчинтэй

холбогдох шаардлагуудын дагуу хийгдсэн тохиолдолд [ИНЕГ](#)-ын дарга өөрөөр тогтоогоогүй бол дараах ангиллын НТЧ-ын гэрчилгээг [нэг жилийн хугацаагаар](#) олгож, шинэчилнэ:

- 1/ Стандарт [ангиллын](#) НТЧ-ын гэрчилгээ;
- 2/ Хязгаарлагдмал [ангиллын](#) НТЧ-ын гэрчилгээ;
- 3/ Тусгай [ангиллын](#) туршилтын НТЧ-ын гэрчилгээ.

(b) Агаарын хөлгийн Стандарт, эсхүл Хязгаарлагдмал ангиллын НТЧ-ын гэрчилгээ нь дараах тохиолдолд хүчингүй болно:

- 1/ агаарын хөлгийг гадаад улсад бүртгүүлэх;
- 2/ агаарын хөлөг, түүний хөдөлгүүр, сэнсэнд олгосон Маягийн гэрчилгээ эсхүл Маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээ нь хүчингүй болсон;

3/ агаарын хөлөгт ижил ангиллын шинэ НТЧ-ын гэрчилгээ олгосон.

(в) Дараах тохиолдолд агаарын хөлгийн [Тусгай ангиллын туршилтын](#) НТЧ-ын гэрчилгээ хүчингүй болно:

- 1/ агаарын хөлөг нь гадаад улсад бүртгүүлэх;
- 2/ агаарын хөлөгт ижил [ангиллын](#) шинэ НТЧ-ын гэрчилгээ олгосон.

(г) [Тусгай ангиллын - тусгай нислэгийн НТЧ-ын гэрчилгээ нь хүчинтэй хугацааг нь түр түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгохоос бусад тохиолдолд гэрчилгээнд заасан хугацаанд хүчин төгөлдөр байна.](#)

-Орчуулга, найруулга зассан

-Категориуд 2007 онд Amend 7-оор 6, 8-аар 9 болж нэмэгдсэн

| | | |
|---|--|--|
| <p><u>хэвээр бол;</u> <u>(2) дараахаас бусад тохиолдолд:</u> (i) <u>урьдчилсан категорийн НТЧ-ын гэрчилгээг түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосон; эсхүл</u> (ii) <u>тухайн агаарын хөлөгт стандарт категорийн НТЧ-ын гэрчилгээ, эсхүл хязгаарлалттай категорийн НТЧ-ын гэрчилгээ олгосон.</u></p> | <p>(д) НТЧ-ын гэрчилгээ эзэмшигч нь энэ бүлгийн дагуу гэрчилгээний хүчинтэй хугацаа дууссан тохиолдолд гэрчилгээг ИНЕГ-ын даргад ирүүлнэ. (е) Агаарын хөлөгт ямар нэгэн эвдрэл гарсан тохиолдолд, ИНЕГ-аас тухайн агаарын хөлгийг нислэгт тэнцэх чадвартай эсэхийг энэ дүрмийн Хавсралт В-д тодорхойлсон загварын НТЧ-ын стандартуудын дагуу тогтоож шийдвэрлэнэ. (ж) Агаарын хөлгийн стандарт, эсхүл хязгаарлагдмал ангиллын НТЧ-ын гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (б) 2/-ын дагуу гэрчилгээ хүчингүй болсон тохиолдолд агаарын хөлөгтөө 21.193-т заасан тусгай ангиллын туршилтын НТЧ-ын гэрчилгээг авч болно.</p> | |
| <p>21.181. Гэрчилгээг шилжүүлэх Хэрэв бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь ИНД-47.57-гийн дагуу тухайн агаарын хөлгийг хууль ёсоор эзэмших эрхээ зогсоосон бол, Монгол Улсын агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь дараах хамааралтай НТЧ-ын гэрчилгээг агаарын хөлгийн хамт шилжүүлэх үүрэгтэй: (1) стандарт категори; (2) хязгаарлалттай категори; (3) тусгай категори; (4) урьдчилсан категори.</p> | <p>21.181. Гэрчилгээг шилжүүлэх/ Transfer of certificate (а) Агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь ИНД-47-д заасны дагуу агаарын хөлгийг хууль ёсоор эзэмших эрхээ зогсоосон тохиолдолд НТЧ-ын гэрчилгээг агаарын хөлгийн хамт шилжүүлнэ.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан -must “шилжүүлнэ”-ийг “үүрэгтэй” болгож залруулсан.</p> |
| <p>Гэрчилгээжүүлэлтийн шаардлага 21.191. Стандарт болон хязгаарлалттай категорийн гэрчилгээжүүлэлтийн шаардлага Агаарын хөлөгт стандарт категори, хязгаарлалттай категори, эсхүл урьдчилсан категорийн НТЧ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах нотлох баримтыг Даргад хүргүүлэх үүрэгтэй: (1) агаарын хөлөг, түүний хөдөлгүүр болон хэрэв хамааралтай бол, сэнс нь дараах холбогдох, хүчинтэй гэрчилгээнд тохирч байгааг: (i) В Бүлгийн дагуу олгосон маягийн гэрчилгээнд; эсхүл (ii) В Бүлгийн дагуу олгосон маягийг хүлээн</p> | <p>Гэрчилгээ олгоход тавигдах шаардлага/ Certification Requirements 21.191. Стандарт болон хязгаарлагдмал ангиллын шаардлага/ Standard and restricted category requirements (а) Агаарын хөлөгт стандарт, эсхүл хязгаарлагдмал ангиллын НТЧ-ын гэрчилгээ авах өргөдөл гаргагч нь дараах нотлох баримтыг ИНЕГ-ын даргад ирүүлнэ: 1/ агаарын хөлөг, түүний хөдөлгүүр, сэнсэнд энэ дүрмийн бүлэг Б-ийн дагуу олгосон Маягийн гэрчилгээ эсхүл Маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээ;</p> | <p>-орчуулга, найруулга зассан</p> |

зөвшөөрөх гэрчилгээнд; эсхүл

(iii) Ф Бүлгийн дагуу олгосон урьдчилсан маягийн гэрчилгээнд;

- (2) агаарын хөлгийн модификаци болон засвар нь тухайн агаарын хөлгийн маягийн хувьд, N Бүлгийн дагуу хүлээн зөвшөөрөхүйц техникийн өгөгдлийн дагуу зөвшөөрөгдсөн загварын өөрчлөлттэй тохирч байгааг;
- (3) агаарын хөлөгт хамааралтай НТЧ-ын удирдамж бүрийг ИНД-39-ийн дагуу хангасан болохыг;
- (4) агаарын хөлөгт дараах баримт бичиг олгосон болохыг:
 - (i) холбогдох нислэгийн заавар;
 - (ii) холбогдох бүртгэлийн дэвтэр, засвар болон өөрчлөлтийн маягт, бусад баримт бичиг;
- (5) агаарын хөлөг нь Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөг бөгөөд ИНД-47-гийн дагуу таних пайз болон дараах аль нэг тэмдэглэгээний хэлбэрийг байрлуулсныг:
 - (i) үндэсний харъяалал болон бүртгэлийн дугаар;
 - (ii) цагдаагийн тэмдэг;
 - (iii) зөвшөөрөгдсөн танигдахуйц будган зураглал тэмдэглэгээ;
- (6) агаарын хөлөг, түүний хөдөлгүүр, сэнс болон сэнсний бул, алгыг Q Бүлэгт заасан аргаар таньж тогтоосон болохыг;
- (7) агаарын хөлөг нь ИНД-26-д заасан холбогдох бүх нэмэлт НТЧ-ын шаардлагад тохирч байгааг;
- (8) НТЧ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргахын өмнөх 60 хоногийн дотор тухайн агаарын хөлөгт дараах үзлэг шалгалт хийсэн болохыг:
 - (i) 100 цагийн, эсхүл үйлдвэрлэгчийн техник үйлчилгээний хуваарийн дагуу дүйцэх үзлэг шалгалт; эсхүл
 - (ii) ИНД-119-ийн дагуу гэрчилгээжсэн агаарын тээвэрлэгчийн, эсхүл ICAO-гийн Хэлэлцэн тохирогч улсын гэрчилгээжүүлсэн агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэгчийн холбогдох техник үйлчилгээний хөтөлбөрийн дагуу хуваарьт үзлэг шалгалт; эсхүл
 - (iii) Даргын хүлээн зөвшөөрөхүйц дүйцэх үзлэг шалгалт;
- (9) 21.175-ын дагуу хүсэлт гаргахын өмнөх сүүлийн 5 жилийн дотор тухайн агаарын хөлгийг жинлэсэн болохыг;

- 2/ энэ дүрмийн K Бүлэгт заасан зөвшөөрөгдсөн техникийн үзүүлэлтийн дагуу батлагдсан, загварын өөрчлөлтөд нийцүүлэн агаарын хөлөгт хийгдсэн аливаа засвар болон өөрчлөлтүүд;
- 3/ ИНД-39-ийн дагуу гарсан, агаарын хөлөгт хамааралтай НТЧ-ын удирдамжийн гүйцэтгэл;
- 4/ агаарын хөлгийн бүхээгийн бүртгэл хөтлөлтийн дэвтэр, нислэгийн заавар, засвар, өөрчлөлтийн тухай тэмдэглэл хийгдсэн маягт болон бусад баримт бичиг;
- 5/ агаарын хөлөг нь Монгол Улсад бүртгэлтэй бол ИНД-47-ийн дагуу үндэсний болон бүртгэлийн таних тэмдгийн тодорхойлолт;
- 6/ агаарын хөлөг, түүний хөдөлгүүр, сэнс, сэнсний гол болон сэнсний алга зэргийг энэ дүрмийн N Бүлэгт заасан арга хэрэгслээр тогтоосон тодорхойлолт;
- 7/ агаарын хөлөг нь ИНД 26-д заасан НТЧ-ын нэмэлт шаардлагад нийцэж байгаа тухай тодорхойлолт;
- 8/ өргөдөл гаргахаас өмнөх 60 хоногийн хугацаанд агаарын хөлөгт дараах техник үйлчилгээ хийгдсэн тухай тодорхойлолт:
 - 8.1. бага оврын агаарын хөлгийн хувьд үйлдвэрлэгчийн техник үйлчилгээний хөтөлбөрийн дагуу 100 цагийн, эсхүл түүнтэй адилтгах хэмжээний техник үйлчилгээ болон үзлэг шалгалт; эсхүл,
 - 8.2. ИНД-119-ийн дагуу гэрчилгээжсэн агаарын тээвэрлэгчийн Техник үйлчилгээний хөтөлбөрийн дагуу хуваарьт үзлэг шалгалт; эсхүл,
 - 8.3. ИНЕГ-ын даргын хүлээн зөвшөөрсөн адилтгах хэмжээний үзлэг шалгалт,
- 9/ энэ дүрмийн 21.175-ын дагуу өргөдөл гаргахаас өмнөх, сүүлийн 5 жилийн хугацаанд агаарын хөлгийг жигнэж үзсэн тооцоо, дүгнэлт;

-2007 онд Amend.7-оор өөрчлөгдсөн

| | | |
|---|---|------------------------------------|
| <p>(10) агаарын хөлөг нь аюулгүй ажиллагааг хангах нөхцөлд байгааг;</p> <p>(11) агаарын хөлөг, түүний <u>модификаци</u> болон засвар нь Хавсралт С-д заасан агаарын хөлгийн дуу чимээний болон хөдөлгүүрийн хийн ялгаруулалтын холбогдох стандартыг хангаж байгааг.</p> | <p>10/ агаарын хөлөг нь ашиглалтын аюулгүй ажиллагааны нөхцөлийг хангасан тухай;</p> <p>11/ агаарын хөлөг, түүнд хийгдсэн аливаа <u>өөрчлөлт</u>, засвар нь энэ дүрмийн Хавсралт В-д тодорхойлсон агаарын хөлгийн дуу чимээний болон хөдөлгүүрээс гарах хийн ялгаруулалтын стандарт шаардлагуудыг хангасан тухай.</p> | |
| <p>21.193. Тусгай категорийн туршилтын гэрчилгээжүүлэлтийн шаардлага</p> <p>Агаарын хөлөгт тусгай <u>категорийн</u> туршилтын НТЧ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах баримт бичгийг <u>Даргад хүргүүлэх үүрэгтэй</u>:</p> <p>(1) дараах мэдээллийг агуулсан, тухайн агаарын хөлгийг ашиглах үйл ажиллагааны зорилгыг тодорхойлсон мэдэгдэл:</p> <ul style="list-style-type: none"> (i) санал болгосон үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээлэл; (ii) үйл ажиллагаанд шаардагдах нислэгийн тооцоот үргэлжлэх хугацаа, эсхүл тоо; (iii) үйл ажиллагаа дээгүүр нь хийгдэх нутаг дэвсгэрийн дэлгэрэнгүй мэдээлэл; <p>(2) гадна конфигурацийн мэдэгдэхүйц өөрчлөлтгүйгээр өмнө нь гэрчилгээжсэн маягаас өөрчилсөн агаарын хөлгөөс бусад агаарын хөлгийн хувьд, гурван талт зургийг багтаасан тухайн агаарын хөлгийг таних хангалттай өгөгдөл;</p> <p>(3) тухайн хүсэлттэй холбоотой <u>Даргын</u> шаардаж болох бусад мэдээлэл;</p> <p>(4) нислэгийн заавар, техник үйлчилгээний заавар болон агаарын хөлгийн үйл ажиллагаатай холбоотой Даргын шаардаж болох баримт бичиг;</p> <p>(5) Даргын шаардаж болох, агаарын хөлгийн аюулгүй ажиллагааг хангахад шаардлагатай загварын өөрчлөлтөд тухайн агаарын хөлөг тохирч байгааг нотлох баримт;</p> <p>(6) агаарын хөлөг нь Монгол Улсын бүртгэлтэй бөгөөд ИНД-47-гийн дагуу таних пайз болон дараах аль нэг тэмдэглэгээний хэлбэрийг байрлуулсныг нотлох баримт:</p> <ul style="list-style-type: none"> (i) үндэсний харъяалал болон бүртгэлийн дугаар; эсхүл (ii) <u>зөвшөөрөгдсөн танигдахуйц будган зураглал</u> | <p>21.193. Туршилтын гэрчилгээнд тавигдах шаардлага/ Experimental certification requirements</p> <p>(a) Агаарын хөлгийн тусгай <u>ангиллын</u> туршилтын НТЧ-ын гэрчилгээ авах өргөдөл гаргагч нь дараах баримтыг <u>ИНЕГ</u>-ын даргад ирүүлнэ:</p> <p>1/ агаарын хөлгийг ашиглах зорилгын тухай мэдэгдэл;</p> <p>2/ агаарын хөлгийг тодорхойлох хангалттай мэдээлэл;</p> <p>3/ <u>ИНЕГ</u>-ын даргын шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл;</p> <p>4/ Нислэгийн заавар, техник үйлчилгээний заавар болон агаарын хөлгийн ашиглалттай холбоотой бусад баримт бичиг;</p> <p>5/ дараах зүйлийг нотлох баримт:</p> <ul style="list-style-type: none"> 5.1. аюулгүй нөхцөлийг хангах үүднээс <u>ИНЕГ</u>-ын даргын шаардлагатай гэж үзсэн агаарын хөлгийн загварын өөрчлөлтийг гүйцэтгэсэн тухай; 5.2. агаарын хөлгийг энэ дүрмийн бүлэг Н-д заасны дагуу тодорхойлсон; 5.3. агаарын хөлөг нь Монгол Улсад бүртгэлтэй бол ИНД-47-гийн дагуу үндэсний болон бүртгэлийн таних тэмдгийн тодорхойлолт. | <p>-орчуулга, найруулга зассан</p> |

тэмдэглэгээ;

- (7) тухайн агаарын хөлгийг Q Бүлэгт заасан аргаар таньж тогтоосон болохыг нотлох баримт;
- (8) агаарын хөлгийн техник үйлчилгээний хөтөлбөрийг ИНД-91.607-гийн дагуу баталсан болохыг нотлох баримт;
- (9) 21.205-д заасан зурагт хуудасны шаардлага хангасан болохыг нотлох баримт.

-2007, 2009 оны Amend.7 болон 8-аар өөрчлөгдсөн

(б) Агаарын хөлгийн тусгай ангиллын туршилтын НТЧ-ын гэрчилгээ авах өргөдөл гаргагч нь бүтээгдэхүүнийг сайжруулах болон судалгаа шинжилгээний зориулалтаар ашиглах тохиолдолд энэ зүйлийн (а)-д зааснаас гадна дараах баримтыг ИНЕГ-ын даргад ирүүлнэ:

- 1/ агаарын хөлгийн ашиглалтын зорилгын дэлгэрэнгүй;
- 2/ шалгах нислэгийн хугацаа, нислэгийн тоо;
- 3/ шалгалтын нислэг үйлдэх нутаг дэвсгэр;
- 4/ агаарын хөлөг нь бүтцийн хувьд Маягийн гэрчилгээнд урьд зааснаас өөрчлөгдсөн бол агаарын хөлгийн гурван талын проекцийг харуулсан техникийн шугам зураг.

-Amend 8-аар хасагдсан

(в) Энэ зүйлийн (б)-д зааснаас бусад зориулалтаар ашиглах гэж буй агаарын хөлөгт туршилтын гэрчилгээ авах өргөдөл гаргагч нь энэ зүйлийн (а)-д зааснаас гадна дараах нотлох баримтыг ИНЕГ-ын даргад ирүүлнэ:

- 1/ шалгах нислэгийн хугацаанд дараах зүйлийг бүрэн гүйцэтгэснийг үзүүлсэн тодорхойлолт:
 - 1.1. нислэгийн хурдны хэвийн хэмжээнд болон маневр хийхэд агаарын хөлгийн удирдлага хэвийн гүйцэтгэсэн тухай.
 - 1.2. агаарын хөлөг нь загварын онцлог болон нислэгийн үзүүлэлтийн хувьд аюулгүй байгаа.
- 2/ аюулгүй ажиллагааны түвшинг хангах зорилгоор агаарын хөлөг нь маягийн загварын НТЧ-ын стандарттай нийцэж буйг дараах байдлаар үзүүлсэн тодорхойлолт:
 - 2.1. холбогдох загварын НТЧ-ын стандартыг хангасан тухай;
 - 2.2. маягийн загварт нийцүүлсэн талаарх агаарын хөлгийн НТЧ-ын түүхтэй холбоотой мэдээлэл.

21.195. Тусгай категорийн үзүүлбэрийн гэрчилгээжүүлэлтийн шаардлага

- (а) Агаарын хөлөгт тусгай категорийн-үзүүлбэрийн НТЧ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах баримт бичгийг Даргад хүргүүлэх үүрэгтэй:
- (1) агаарын хөлгийг ашиглах үйл ажиллагааны зорилгыг

- тодорхойлсон мэдэгдэл;
- (2) агаарын хөлгийн хийц болон загварыг таних хангалттай өгөгдөл;
- (3) тухайн хүсэлттэй холбоотой Даргын шаардаж болох бусад мэдээлэл;
- (4) нислэгийн заавар, техник үйлчилгээний заавар болон агаарын хөлгийн үйл ажиллагаатай холбоотой Даргын шаардаж болох бусад баримт бичиг;
- (5) Даргын шаардаж болох, агаарын хөлгийн аюулгүй ажиллагааг хангахад шаардлагатай загварын өөрчлөлтөд тухайн агаарын хөлөг тохирч байгааг нотлох баримт;
- (6) агаарын хөлөг нь Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөг бөгөөд ИНД-47-гийн дагуу таних пайз болон дараах аль нэг тэмдэглэгээний хэлбэрийг харуулж байгааг нотлох баримт:
- (i) үндэсний харъяалал болон бүртгэлийн дугаар;
эсхүл
- (ii) зөвшөөрөгдсөн танигдахуйц будган зураглал тэмдэглэгээ;
- (7) агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь ИНД-47.55.(с)-гийн дагуу агаарын хөлгийн хувьд үйл ажиллагаа эрхлэгчийн хүчинтэй мэдэгдэл эзэмшиж байгааг нотлох баримт;
- (8) тухайн агаарын хөлгийг Q Бүлэгт заасан аргаар таньж тогтоосон болохыг нотлох баримт;
- (9) шалгалтын нислэг амжилттай хийгдсэн ба тухайн агаарын хөлөг нь дараах шаардлагыг хангаж байгааг нотлох баримт:
- (i) бүх хурдны хүрээнд болон бүх хэвийн үйл ажиллагааны маневрын түршид тогтвортой удирдагдаж байгаа болохыг;
- (ii) үйл ажиллагааны аюултай үзүүлэлт, эсхүл загварын хэв шинжгүй болохыг;
- (10) агаарын хөлгийн техник үйлчилгээний хөтөлбөрийг ИНД-91.607-гийн дагуу баталсан болохыг нотлох баримт;
- (11) хамааралтай НТЧ-ын удирдамж бүрийг ИНД-39-ийн дагуу хангасан болохыг нотлох баримт;
- (12) шалгалтын нислэгийн дараах өгөгдөл:
- (i) агаарын хөлгийн үйл ажиллагааны хязгаарлалт;
- (ii) агаарын хөлгийн НТЧ-ын хязгаарлалт;
- (13) 21.205-д заасан зурагт хуудасны шаардлага

-2009 онд Amend 8-аар нэмэгдсэн

хангасан болохыг нотлох баримт.

(b)Энэ зүйлийн (a)(9)-д шаардсан шалгалтын нислэгийг дараах байдлаар хийсэн байх шаардлагатай:

(1)тухайн агаарын хөлөгт олгосон тусгай категорийн - туршилтын НТЧ-ын гэрчилгээнд заасан хязгаарлалт болон нөхцөлийн дагуу;

(2)Хавсралт Е-гийн дагуу тухайн зорилгоор зөвшөөрөгдсөн туршин нисгэгчээр.

21.197. Тусгай категорийн сонирхогчийн бүтээсэн агаарын хөлгийн гэрчилгээжүүлэлтийн шаардлага

(a)Агаарын хөлөгт тусгай категорийн сонирхогчийн бүтээсэн НТЧ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах баримт бичгийг Даргад хүргүүлэх үүрэгтэй:

(1)агаарын хөлгийг ашиглах үйл ажиллагааны зорилгыг тодорхойлсон мэдэгдэл;

(2)агаарын хөлгийн хийц болон загварыг таних хангалттай өгөгдөл;

(3) хүсэлттэй холбоотой Даргын шаардаж болох бусад мэдээлэл;

(4)нислэгийн заавар, техник үйлчилгээний заавар болон агаарын хөлгийн үйл ажиллагаатай холбоотой Даргын шаардаж болох бусад баримт бичиг;

(5)дараах нотлох баримт:

(i) сонирхогч-зохион бүтээгч нь тухайн агаарын хөлгийн ихэнх хэсгийг өөрийн мэдлэг боловсрол, туршлагад тулгуурлан бүтээсэн болохыг; эсхүл

(ii) спортын хөнгөн агаарын хөлгийг туршилтын-спортын хөнгөн агаарын хөлөг гэж үйлдвэрлэгч тогтоосон болохыг;

(6)Даргын шаардаж болох, агаарын хөлгийн аюулгүй ажиллагааг хангахад шаардлагатай загварын өөрчлөлтөд тухайн агаарын хөлөг тохирч байгааг нотлох баримт;

(7) агаарын хөлөг нь Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөг бөгөөд ИНД-47-гийн дагуу таних пайз болон дараах аль нэг тэмдэглэгээний хэлбэрийг харуулж байгааг нотлох баримт:

(i) үндэсний харъяалал болон бүртгэлийн дугаар; эсхүл

(ii) зөвшөөрөгдсөн танигдахуйц будган зураглал тэмдэглэгээ;

(8)тухайн агаарын хөлгийг Q Бүлэгт заасан аргаар таньж тогтоосон болохыг нотлох баримт;

(9)шалгалтын нислэг амжилттай хийгдсэн ба тухайн агаарын хөлөг нь дараах шаардлагыг хангаж байгааг

-2009 онд Amend 8-аар нэмэгдсэн

нотлох баримт:

(i) бүх хурдны хүрээнд болон бүх хэвийн үйл ажиллагааны маневрын түршид тогтвортой удирдагддаг байх;

(ii) үйл ажиллагааны аюултай үзүүлэлт, эсхүл загварын хэв шинжгүй байх;

(10) агаарын хөлгийн техник үйлчилгээний хөтөлбөрийг ИНД-91.607-гийн дагуу баталсан болохыг нотлох баримт;

(11) хамааралтай НТЧ-ын удирдамж бүрийг ИНД-39-ийн дагуу хангасан болохыг нотлох баримт;

(12) шалгалтын нислэгийн дараах өгөгдөл:

(i) агаарын хөлгийн үйл ажиллагааны хязгаарлалт;

(ii) агаарын хөлгийн НТЧ-ын хязгаарлалт;

(13) 21.205-д заасан зурагт хуудасны шаардлага хангасан болохыг нотлох баримт.

(b)Энэ зүйлийн (a)(12)-т шаардсан шалгалтын нислэгийг дараах байдлаар хийсэн байх шаардлагатай:

(1)агаарын хөлгийн тусгай категорийн туршилтын НТЧ-ын гэрчилгээнд заасан хязгаарлалт болон нөхцөлийн дагуу;

(2)Хавсралт Е-гийн дагуу тухайн зорилгоор зөвшөөрөгдсөн туршин нисгэгчээр.

21.199. Тусгай категорийн анхдагч гэрчилгээжүүлэлтийн шаардлага

Агаарын хөлөгт тусгай категорийн - анхдагч НТЧ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах баримт бичгийг Даргад хүргүүлэх үүрэгтэй:

(1)агаарын хөлгийг ашиглах үйл ажиллагааны зорилгыг тодорхойлсон мэдэгдэл;

(2)агаарын хөлгийн хийц болон загварыг таних хангалттай өгөгдөл;

(3)тухайн хүсэлттэй холбоотой Даргын шаардаж болох бусад мэдээлэл;

(4)нислэгийн заавар, техник үйлчилгээний заавар болон агаарын хөлгийн үйл ажиллагаатай холбоотой Даргын шаардаж болох бусад баримт бичиг;

(5)тухайн агаарын хөлөгт хийсэн модификаци болон засвар нь С Бүлгийн дагуу зөвшөөрөгдсөн загварын өөрчлөлтөд тохирч байгааг нотлох баримт;

(6)хамааралтай НТЧ-ын удирдамж бүрийг ИНД-39-ийн дагуу хангасан болохыг нотлох баримт;

(7)агаарын хөлөг нь Монгол Улсын бүртгэлтэй агаарын

хөлөг бөгөөд ИНД-47-гийн дагуу таних пайз болон дараах аль нэг тэмдэглэгээний хэлбэрийг харуулж байгааг нотлох баримт:

(i) үндэсний харъяалал болон бүртгэлийн дугаар; эсхүл

(ii) зөвшөөрөгдсөн танигдахуйц будган зураглал, тэмдэглэгээ;

(8) агаарын хөлөг, түүний хөдөлгүүр, сэнс болон сэнсний бул, алгыг Q Бүлэгт заасан аргаар таньж тогтоосон болохыг нотлох баримт;

(9) агаарын хөлгийн техник үйлчилгээний хөтөлбөрийг ИНД-91.607-гийн дагуу баталсан болохыг нотлох баримт;

(10) агаарын хөлөг болон түүнд суурилуулсан бүрдэл хэсэгтэй холбоотой НТЧ-ын хадгалалтын өгөгдөл нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц эх үүсвэрээс авсан болохыг нотлох баримт;

(11) НТЧ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргахаас өмнөх 60 хоногийн дотор тухайн агаарын хөлөгт 100 цагийн, эсхүл үйлдвэрлэгчийн техник үйлчилгээний хуваарийн дагуу дүйцэх үзлэг шалгалт, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц дүйцэх үзлэг шалгалт хийсэн болохыг нотлох баримт;

(12) импортын агаарын хөлгийн хувьд:

(i) тухайн агаарын хөлгийг FAR 21.24-ийн дагуу анхдагч категорийн агаарын хөлгөөр гэрчилгээжүүлснийг, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц дүйцэх гэрчилгээжүүлэлтийг экспортлогч улсын холбогдох НТЧ-ын эрх бүхий байгууллага хийсэн болохыг нотлох баримт;

(ii) тухайн агаарын хөлөг нь FAR 21.24-д заасан анхдагч категорийн агаарын хөлгийн шаардлага болон НТЧ-ын загварын стандарт, эсхүл энэ зүйлийн (i)-ийн дагуу Даргын хүлээн зөвшөөрсөн дүйцэх гэрчилгээжүүлэлтийн шаардлага болон НТЧ-ын загварын стандартад тохирч байгааг нотлох баримт;

(13) Монгол Улсад үйлдвэрлэсэн агаарын хөлгийн хувьд:

(i) тухайн агаарын хөлгийг ИНД-148-ын дагуу олгосон агаарын хөлөг үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээний эрхийн хүрээнд үйлдвэрлэсэн болохыг нотлох баримт;

(ii) тухайн агаарын хөлөг нь FAR 21.24-д заасан

анхдагч категорийн агаарын хөлгийн шаардлага болон НТЧ-ын загварын стандарт, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц дүйцэх НТЧ-ын загварын стандартад тохирч байгааг нотлох баримт;

(14) 21.205-д заасан зурагт хуудасны шаардлага хангасан болохыг нотлох баримт.

21.201. Тусгай категорийн-спортын хөнгөн агаарын хөлгийн гэрчилгээжүүлэлтийн шаардлага

(а) Агаарын хөлөгт тусгай категорийн - спортын хөнгөн агаарын хөлгийн НТЧ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах баримт бичгийг Даргад хүргүүлэх үүрэгтэй:

(1) агаарын хөлгийг ашиглах үйл ажиллагааны зорилгыг тодорхойлсон мэдэгдэл;

(2) агаарын хөлгийн хийц болон загварыг таних хангалттай өгөгдөл;

(3) тухайн хүсэлттэй холбоотой Даргын шаардаж болох бусад мэдээлэл;

(4) нислэгийн заавар үйлдвэрлэгчийн техник үйлчилгээний заавар, үзлэг шалгалтын журам болон агаарын хөлгийн үйл ажиллагаатай холбоотой Даргын шаардаж болох бусад баримт бичиг;

(5) Даргын шаардаж болох, агаарын хөлгийн аюулгүй ажиллагааг хангахад шаардлагатай загварын өөрчлөлтөд тухайн агаарын хөлөг тохирч байгааг нотлох баримт;

(6) агаарын хөлөг нь Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөг бөгөөд ИНД-47-гийн дагуу таних пайз болон дараах аль нэг тэмдэглэгээний хэлбэрийг харуулж байгааг нотлох баримт:

(i) үндэсний харъяалал болон бүртгэлийн дугаар; эсхүл

(ii) зөвшөөрөгдсөн танигдахуйц будган зураглал тэмдэглэгээ;

(7) тухайн агаарын хөлгийг Q Бүлэгт заасан аргаар таньж тогтоосон болохыг нотлох баримт;

(8) шалгалтын нислэг амжилттай хийгдсэн ба тухайн агаарын хөлөг нь дараах шаардлагыг хангаж байгааг нотлох баримт:

(i) бүх хурдны хүрээнд болон бүх хэвийн үйл ажиллагааны маневрын түршид тогтвортой удирдагддаг байх;

(ii) үйл ажиллагааны аюултай үзүүлэлт, эсхүл загварын хэв шинжгүй байх;

(9) агаарын хөлгийн техник үйлчилгээний хөтөлбөрийг ИНД-91.607-ын дагуу баталсан болохыг нотлох баримт;

(10) хамааралтай НТЧ-ын удирдамж бүрийг ИНД-39-ийн дагуу хангасан болохыг нотлох баримт;

(11) импортын агаарын хөлгийн хувьд:

(i) тухайн агаарын хөлөгт тусгай категорийн спортын хөнгөн агаарын хөлгийн НТЧ-ын гэрчилгээг FAR 21.190-д заасан шаардлагын дагуу, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц дүйцэх стандартад заасны дагуу олгосон, эсхүл олгоход тохирохыг нотлох баримт;

(ii) энэ зүйлийн (b)-гийн шаардлагыг хангасан агаарын хөлгийн үйлдвэрлэгчийн бичгээр үйлдсэн мэдэгдэл, эсхүл үйлдвэрлэгчийн гарын үсэг зурсан мэдэгдлийн баталгаажуулсан хуулбар;

(12) Монгол Улсад үйлдвэрлэсэн агаарын хөлгийн хувьд:

(i) тухайн агаарын хөлгийг ИНД-148-ын дагуу олгосон агаарын хөлөг үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээний эрхийн хүрээнд үйлдвэрлэсэн болохыг нотлох баримт;

(ii) энэ зүйлийн (b)-гийн шаардлагыг хангасан тухай агаарын хөлгийн үйлдвэрлэгчийн бичгээр үйлдсэн мэдэгдэл, эсхүл үйлдвэрлэгчийн гарын үсэг зурсан мэдэгдлийн баталгаажуулсан хуулбар;

(13) 21.205-д заасан зурагт хуудасны шаардлага хангасан болохыг нотлох баримт.

(b) Энэ зүйлийн (a)(11) (12)-т шаардсан агаарын хөлгийн үйлдвэрлэгчийн нийцлийн мэдэгдэл нь дараах мэдээллийг агуулсан байх ёстой:

(1) агаарын хөлгийн хийц болон загвар, серийн дугаар болон үйлдвэрлэсэн огноог тогтоосон дэлгэрэнгүй мэдээлэл;

(2) агаарын хөлгийг спортын хөнгөн агаарын хөлгөөр тодорхойлж болохыг харуулах техникийн дэлгэрэнгүй мэдээлэл;

(3) агаарын хөлгийг зохион бүтээх болон үйлдвэрлэхтэй холбоотой зөвшилцсөн стандартыг таньж тогтоох;

(4) дараах нөхцөлийг баталгаажуулсан мэдэгдэл:

(i) үйлдвэрлэгч нь энэ зүйлийн (b)(3)-ын дагуу тогтоосон, зөвшилцсөн стандартын шаардлага хангасан чанар баталгаажуулалтын тогтолцоотой;

(ii) тухайн агаарын хөлгийн үйлдвэрлэгчийн загварын

өгөгдөл нь энэ зүйлийн (b)(3)-ын дагуу тогтоосон, зөвшилцсөн стандартад тохирч байгаа;

(iii)энэ зүйлийн (b)(4)(i)-д шаардсан чанар баталгаажуулалтын тогтолцоонд суурилсан ба агаарын хөлөг нь үйлдвэрлэгчийн загварын өгөгдөл болон энэ зүйлийн (b)(3)-ын дагуу тогтоосон, зөвшилцсөн стандартад тохирч байгаа;

(iv) энэ зүйлийн (b)(3)-т тогтоосон, зөвшилцсөн стандартын дагуу үйлдвэрлэгчийн тогтоосон, үйлдвэрлэлд хүлээн зөвшөөрөх тестийн журмын дагуу;

(A) үйлдвэрлэгч нь тухайн агаарын хөлгийг газарт болон нислэгт туршсан болохыг;

(B) газрын болон шалгах нислэгийн үед тухайн агаарын хөлгийн үзүүлэлт нь загварын шаардлагад нийцэж байгаад үйлдвэрлэгч нь итгэлтэй байгааг;

(C) тухайн агаарын хөлөг нь аюулгүй ажиллагааг хангах нөхцөлд байгааг;

(v)үйлдвэрлэгч нь тухайн агаарын хөлгийн НТЧ-ын хадгалалтыг хянах журамтай ба аюултай нөхцөлийг залруулах зорилгоор энэ зүйлийн (b)(3)-ын дагуу тогтоосон, зөвшилцсөн стандартыг хангасан аюулгүй байдлын удирдамж, эсхүл шаардлага гаргадаг болохыг.

(c)Спортын хөнгөн агаарын хөлгийг иж бүрдлээр угсарсан ба үйлдвэрлэгч нь туршилтын - спортын хөнгөн агаарын хөлөг гэж тогтоосон спортын хөнгөн агаарын хөлөгт тусгай категорийн спортын хөнгөн агаарын хөлгийн НТЧ-ын гэрчилгээ олгохгүй.

21.203. Тусгай категорийн хязгаарлагдмал гэрчилгээжүүлэлтийн шаардлага

(a)Агаарын хөлөгт тусгай категорийн - хязгаарлагдмал НТЧ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах баримт бичгийг Даргад хүргүүлэх үүрэгтэй:

(1)агаарын хөлгийг ашиглах үйл ажиллагааны зорилгыг тодорхойлсон мэдэгдэл;

(2) агаарын хөлгийн хийц болон загварыг таних хангалттай өгөгдөл;

(3) агаарын хөлгийн маягийг олон тоогоор, хяналттай зохион бүтээх орчинд, үйлдвэрт бүтээсэн болохыг нотлох баримт;

(4)агаарын хөлгийн маягийг өмнө нь иргэний, эсхүл цэргийн үйл ажиллагаанд хүлээн зөвшөөрсөн болохыг

нотлох баримт;

(5) агаарын хөлгийн дараах нотлох баримт:

(i) маягийн эх загвар болон үйл ажиллагааны конфигурацаас зарчмын хувьд, өөрчлөгдөөгүй болохыг; эсхүл

(ii) маягийн эх загвар болон үйл ажиллагааны конфигурацийн томоохон өөрчлөлтгүй, өргөн хүрээтэй сэргээсэн болохыг; эсхүл

(iii) зохих загварын зөвшөөрөлд хамааралтай, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц томоохон өөрчлөлт хийснийг үл харгалзан маягийн эх загварын стандарт болон үйл ажиллагааны конфигурацитай зарчмын хувьд, нийцэж байгааг;

(6) хамааралтай НТЧ-ын удирдамж бүрийг ИНД-39-ийн дагуу хангасан болохыг нотлох баримт;

(7) агаарын хөлгийн техник үйлчилгээний хөтөлбөрийг ИНД-91.607-гийн дагуу баталсан болохыг нотлох баримт;

(8) дараах мэдээллийг агуулсан нислэгийн зааврын хязгаарлалтын өгөгдөл:

(i) хурдны үзүүлэлт;

(ii) жин болон ачааллын мэдээлэл;

(iii) хөдөлгүүрийн үйл ажиллагааны үзүүлэлт;

(iv) түлш болон тосны тодорхойлолт;

(v) түлшний зарцуулалтын өгөгдөл;

(vi) нийт хэрэглэх боломжит түлшний хэмжээ;

(vii) мэдэгдэж байгаа мөстөлтийн нөхцөлд нислэг үйлдэх боломж;

(viii) эрсдэлтэй болон хориглосон маневр;

(ix) онцгой нөхцөлийн журам;

(x) бүхээгт байх хүний максимум тоо;

(xi) хэрэв нэгээс дээш нисэх багийн гишүүн шаардсан бол, минимум нисэх багийн гишүүний тоо;

(xii) зөвлөсөн хөөрөлтийн болон бүүлтын зай;

(xiii) хэрэв хамааралтай бол, ганц хөдөлгүүрээр өндөр авах үзүүлэлт;

(9) тухайн агаарын хөлөг нь Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөг бөгөөд ИНД-47-гийн дагуу таних пайз болон дараах аль нэг тэмдэглэгээний хэлбэрийг харуулж байгааг нотлох баримт:

(i) үндэсний харъяалал болон бүртгэлийн дугаар; эсхүл

(ii) зөвшөөрөгдсөн танигдахуйц будган зураглал, тэмдэглэгээ;

(10) агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь ИНД-47.55.(с)-гийн дагуу тухайн агаарын хөлгийн хувьд үйл ажиллагаа эрхлэгчийн хүчинтэй мэдэгдэл эзэмшиж байгааг нотлох баримт;

(11) НТЧ-ын гэрчилгээ эзэмших хүсэлтийг Даргад хүргүүлэхээс өмнөх 60 хоногийн дотор тухайн агаарын хөлөгт жилийн, эсхүл үйлдвэрлэгчийн, хуваарийн дагуу хийх 100 цагийн үзлэг шалгалттай дүйцэх, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхуйц дүйцэх үзлэг шалгалт хийсэн болохыг нотлох баримт;

(12) тухайн агаарын хөлөгөөр дараах шалгалтын нислэг хийсэн болохыг нотлох баримт:

(i) хэрэв агаарын хөлгийн аюулгүй байдлын, бүрэн бүтэн байдлын болон найдвартай ажиллагааны бүртгэлийн баримтжуулсан нотлох баримт байхгүй бол, тухайн агаарын хөлөг нь бүх хурдны хүрээнд болон бүх хэвийн үйл ажиллагааны маневрын туршид тогтвортой удирдагдаж байгаа болохыг тогтоох нислэгийн үнэлгээ; эсхүл

(ii) мэдэгдэж байгаа үйл ажиллагааны хязгаарлалтыг тогтоох, эсхүл тухайн хязгаарлалтын өөрчлөлт нь модификацийн үр дүн болохыг бататгах нислэгийн үнэлгээ; эсхүл

(iii) энэ зүйлийн (i) (ii)-ыг нэгтгэсэн үнэлгээ;

(13) тухайн агаарын хөлгийг аюулгүй ажиллах нөхцөлд байгааг нотлох баримт;

(14) 21.205-д заасан зурагт хуудасны шаардлага хангасан болохыг нотлох баримт.

(b) Энэ зүйлийн (a)(8)-д шаардсан нислэгийн зааврын хязгаарлалтын өгөгдөл нь дараах эх үүсвэртэй байх ёстой:

(1) үйлдвэрлэгчийн өгөгдөл, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхуйц цэргийн үйл ажиллагааны заавар; эсхүл

(2) гадаадын иргэний нисэхийн НТЧ-ын эрх бүхий байгууллагын хүлээн зөвшөөрсөн өгөгдөл; эсхүл

(3) тухайн агаарын хөлөгт олгосон тусгай категорийн - туршилтын НТЧ-ын гэрчилгээний дагуу хийсэн шалгалтын нислэгээс гаргаж авсан өгөгдөл; эсхүл

(4) энэ зүйлийн (1), (2) болон (3)-ын нэгдэл.

(c) Энэ зүйлийн (a)(12) болон (b)(3)-т шаардсан шалгалтын нислэгийг дараах байдлаар хийсэн байх шаардлагатай:

(1) тухайн агаарын хөлгийн тусгай категорийн- туршилтын

| | | |
|---|--|--|
| <p><u>НТЧ-ын гэрчилгээнд заасан хязгаарлалт болон нөхцөлийн дагуу;</u> <u>(2)Хавсралт Е-гийн дагуу тухайн зорилгоор зөвшөөрөгдсөн түршин нисгэгчээр.</u></p> | | |
| <p><u>21.205. Тусгай категорийн агаарын хөлгийн зурагт хуудас</u> <u>Тусгай категорийн НТЧ-ын гэрчилгээтэй агаарын хөлгийн хувьд тухайн агаарын хөлөгт дараах бичиглэл, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц бусад төстэй бичиглэлийг агуулсан ойлгомжтой зурагт хуудсыг зорчигчдод ил тод харагдахуйцаар байрлуулах ёстой:</u> <u>“Анхааруулга</u> <u>Энэ агаарын хөлөг нь Тусгай категорийн (Дэд категори) агаарын хөлөг бөгөөд агаарын тээврийн үйл ажиллагаанд зорчигч тээвэрлэх стандарт категорийн агаарын хөлөгт тавих Монгол Улсын иргэний нисэхийн НТЧ-ын стандартыг хангаагүй болно.</u> <u>Энэ агаарын хөлгөөр нисэх Зорчигч нь эрсдэлээ өөрөө хариуцна.”</u></p> | | |
| <p><u>I Бүлэг - Тусгай нислэгийн зөвшөөрөл</u></p> | | |
| <p><u>21.251. Хамрах хүрээ</u> <u>Энэ Бүлэг нь агаарын хөлөгт тусгай нислэгийн зөвшөөрөл олгох зохицуулалтын шаардлагыг тогтооно.</u> <u>21.253. Тусгай нислэгийн зөвшөөрлийн категори</u> <u>Дарга, агаарын хөлөгт дараах тусгай нислэгийн зөвшөөрлийг Хууль болон энэ Бүлгийн холбогдох шаардлагын дагуу олгоно:</u> <u>(1)тусгай нислэгийн зөвшөөрөл-түр эрх;</u> <u>(2)тусгай нислэгийн зөвшөөрлийн-байнгын эрх.</u> <u>21.255. Тусгай нислэгийн зөвшөөрөл авах хүсэлт гаргах</u> <u>Тусгай нислэгийн зөвшөөрөл авах хүсэлт гаргагч нь дараах маягтаас аль тохирохыг бөглөж, зохих төлбөрийн баримтын хамт Даргад хүргүүлэх үүрэгтэй:</u> <u>(1) маягт САА 24021/07 - тусгай нислэгийн зөвшөөрөл;</u> <u>(2) маягт САА 24021/15 - тусгай нислэгийн зөвшөөрлийн байнгын эрх</u> <u>21.257. Тусгай нислэгийн зөвшөөрөл олгох нөхцөл</u> <u>(a)Хэрэв дараах шаардлагыг хангасан гэж үзвэл, Дарга агаарын хөлөгт тусгай нислэгийн зөвшөөрөл олгож болно:</u> <u>(1)энэ Бүлгийн дагуу холбогдох гэрчилгээжүүлэлтийн шаардлагыг хангасан байх;</u> <u>(2)агаарын хөлгийн аливаа татгалзал нь энэ Дүрэм, эсхүл бусад иргэний нисэхийн дүрэмд заасан хамааралтай</u></p> | | <p>-2009 онд Amend 8-аар нэмэгдсэн</p> |

НТЧ-ын болон техник үйлчилгээний шаардлага хангаагүйг үл харгалзан аюулгүй байдлын түвшин нь, дараах зорилгоор ашиглахад хангалттай байх:

- (i) агаарын хөлгийн техник үйлчилгээ хийх төв рүү, эсхүл хадгалалтын цэг рүү нисэх;
- (ii) ИНД-148-ын дагуу олгосон үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ эзэмшигчийн шинэ агаарын хөлгийн шалгах нислэг хийх;
- (iii) аюул заналхийлж байгаа бүсээс агаарын хөлгийг шилжүүлэх.

(b) Хэрэв Дарга энэ Бүлгийн холбогдох гэрчилгээжүүлэлтийн шаардлага хангагдсан бөгөөд аюулгүй байдлын түвшин нь агаарын хөлгийг ашиглах зорилгод нийцнэ гэж үзвэл, Дарга агаарын хөлгийн маягт тусгай нислэгийн зөвшөөрлийн байнгын эрх олгож болно.

(c) Дарга тусгай нислэгийн зөвшөөрөлд, тухайн зөвшөөрлийн зорилго болон агаарын хөлгийн ашиглалтын холбогдох хязгаарлалт болон нөхцөлийг тусгайлан зааж болно.

21.259. Тусгай нислэгийн зөвшөөрлийн хугацаа

(a) Агаарын хөлгийн тусгай нислэгийн зөвшөөрөл нь хэрэв тухайн агаарын хөлөг Монгол Улсын бүртгэлтэй хэвээр байгаа бол Дарга зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосноос бусад тохиолдолд, заасан хугацаанд хүчинтэй хэвээр байна.

(b) Агаарын хөлгийн маягийн тусгай нислэгийн зөвшөөрлийн байнгын эрх нь Дарга зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосноос бусад тохиолдолд заасан хугацаанд хүчинтэй хэвээр байна.

Тусгай нислэгийн зөвшөөрлийн шаардлага

21.261. Тусгай нислэгийн зөвшөөрөл авах хүсэлт гаргах

Тусгай нислэгийн зөвшөөрөл авах хүсэлт гаргагч нь дараах мэдээллийг Даргад хүргүүлэх үүрэгтэй:

- (1) дараах мэдээллийн дэлгэрэнгүй:
 - (i) нислэгийн зорилго;
 - (ii) санал болгосон маршрут;
 - (iii) тухайн агаарын хөлөг болон түүний төхөөрөмжийг ажиллуулахад шаардагдах нисэх багийн гишүүд;
 - (iv) хамааралтай НТЧ, эсхүл техник үйлчилгээний шаардлагын үл тохирол;
 - (v) тухайн агаарын хөлгийн аюулгүй ажиллагааг

21.261. Тусгай нислэгийн зөвшөөрөлд тавигдах шаардлага/ Special flight permit requirements

- (a) Тусгай нислэгийн зөвшөөрөл авахаар өргөдөл гаргагч нь ИНЕГ-ын даргад дараах мэдээллийг ирүүлнэ:
 - 1/ Дараах мэдээллийн дэлгэрэнгүй:
 - 1.1. нислэгийн зорилго;
 - 1.2. төлөвлөж буй маршрут;
 - 1.3. нисэх баг;
 - 1.4. НТЧ-ын болон техник үйлчилгээний зохих шаардлагуудыг хангахгүй байгаа агаарын хөлгийн бүрэлдэхүүн хэсэг, эд анги, систем тоноглол бусад зүйлийн тухай;
 - 1.5. агаарын хөлгийн аюулгүй ажиллагааны шаардлагын

-Орчуулга найруулга зассан

| | | |
|---|--|-------------------------------------|
| <p>хангахад шаардлагатай байж болох хориг;</p> <p>(2) <u>Даргын</u> шаардаж болох бусад мэдээлэл;</p> <p>(3) тухайн агаарын хөлөг нь Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөг бөгөөд ИНД-47-гийн дагуу таних пайз болон агаарын хөлгийн тэмдэглэгээний зөвшөөрөгдсөн хэлбэрийг харуулж байгааг нотлох баримт;</p> <p>(4) тухайн агаарын хөлгийг Q Бүлэгт заасан аргаар таньж тогтоосон болохыг нотлох баримт.</p> | <p>үүднээс тогтоосон аливаа хязгаарлалтууд.</p> <p>2/ ашиглалтын хязгаарлалттай холбоотой <u>ИНЕГ</u>-ын даргын шаардсан бусад мэдээллүүд;</p> <p>3/ агаарын хөлөг нь Монгол Улсад бүртгэлтэй бол ИНД-47-ийн дагуу олгосон үндэсний болон бүртгэлийн таних тэмдгийн мэдээлэл;</p> <p>4/ агаарын хөлгийг энэ дүрмийн Н Бүлэгт заасны дагуу тодорхойлсон нотолгоо.</p> <p>б) Тусгай нислэг нь арилжааны бүс нислэг байна.</p> | |
| <p><u>21.263. Тусгай нислэгийн зөвшөөрлийн - байнгын эрх авах хүсэлт гаргах</u></p> <p><u>Агаарын хөлгийн маягт тусгай нислэгийн зөвшөөрлийн байнгын эрх авах хүсэлт гаргагч нь дараах мэдээллийг Даргад хүргүүлэх үүрэгтэй:</u></p> <p><u>(1) агаарын хөлгийн тусгай нислэгийн зөвшөөрлийн дагуух үйл ажиллагаа нь ИНД-148-ын дагуу олгосон үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээний эрхийн хүрээнд шалгах нислэг хийх зорилготой болохыг бататгах мэдэгдэл;</u></p> <p><u>(2) тухайн агаарын хөлгийн маягийн дэлгэрэнгүй мэдээлэл;</u></p> <p><u>(3) шалгах нислэг бүрийг аюулгүй гүйцэтгэсэн болохыг бататгах үйлдвэрлэх байгууллагын журмын дэлгэрэнгүй мэдээлэл;</u></p> <p><u>(4) Даргын шаардаж болох бусад мэдээлэл.</u></p> | | <p>-Орхигдсоныг нөхөж оруулсан.</p> |
| <p>J Бүлэг-Нөөц</p> | | |
| <p>K Бүлэг-Материал, эд анги, процесс болон хэрэгсэл</p> | <p>Ж БҮЛЭГ. МАТЕРИАЛ, ЭД АНГИ, НЭМЭЛТ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БОЛОН ТЕХНОЛОГИЙН АРГА АЖИЛЛАГАА/ MATERIALS, PARTS, PROCESSES, AND APPLIANCES</p> | |
| <p>21.301. Зорилго</p> <p>Энэ Бүлэг нь материал, эд анги, процесс болон хэрэгслийг зөвшөөрөх, эсхүл хүлээн зөвшөөрөх зохицуулалтын шаардлагыг тогтооно.</p> | <p>21.301. Үйлчлэх хүрээ/ Scope</p> <p>(a) Материал, эд анги, нэмэлт тоног төхөөрөмж болон технологийн арга ажиллагааг баталгаажуулах, эсхүл хүлээн зөвшөөрөх үйл ажиллагааг энэ бүлгээр зохицуулна.</p> | |
| <p>21.303. Солилтын болон <u>модификацийн</u> материал, эд анги болон хэрэгсэл</p> <p>Маягаар гэрчилгээжсэн бүтээгдэхүүний солилтын эсхүл модификацийн материал, эд анги, эсхүл хэрэгсэл нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:</p> <p>(1) бүтээгдэхүүн нь маягийн загварт нийцэж байгааг маягийн гэрчилгээ эзэмшигч зөвшөөрсөн байх; эсхүл</p> | <p>21.304 Материал, эд анги, нэмэлт тоног төхөөрөмжийг солих, <u>өөрчлөх</u>/ Replacement and modification materials, parts, and appliances</p> <p>(a) Маягийн гэрчилгээ олгогдсон бүтээгдэхүүнд суурилагдсан эд анги, материал, нэмэлт тоног төхөөрөмжийг солих, эсхүл <u>өөрчлөхөд</u> дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>1/ бүтээгдэхүүн нь маягийн загвартай нийцэж, Маягийн гэрчилгээ эзэмшигчээр зөвшөөрөгдсөн байх; эсхүл,</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |

| | | |
|---|---|--|
| <p>(2) бүтээгдэхүүнд техник үйлчилгээ хийж байгаа этгээд үйлдвэрлэсэн ба солилтын, эсхүл модификацийн материал, эд анги, эсхүл хэрэгсэл нь:</p> <p>(i) хийсэн загварын өөрчлөлтийг багтаасан, зөвшөөрсөн маягийн загварт нийцэж байгааг тухайн этгээд гэрчилгээжүүлсэн байх;</p> <p>(ii) Q Бүлгийн дагуу таньж тогтоогдсон байх; эсхүл</p> <p>(3) эд анги, эсхүл хэрэгслийн нийцэл болон гарал үүслийг тогтоож, техник үйлчилгээ гүйцэтгэсэн, ИНД-145-ын дагуу техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээ эзэмшигчийн олгосон САА Form One- шилжүүлэхийг зөвшөөрсөн гэрчилгээтэй байх; эсхүл,</p> <p>(4) дараах зөвшөөрлийн дагуу тухайн эд анги, эсхүл хэрэгслийг үйлдвэрлэсэн ИНД-148-ын дагуу үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ эзэмшигчийн олгосон САА Form One - шилжүүлэхийг зөвшөөрсөн гэрчилгээтэй байх:</p> <p>(i) Монгол Улсын TSO эрх; эсхүл</p> <p>(ii) Монгол Улсын PMA; эсхүл,</p> <p>(iii) E Бүлгийн дагуу олгосон нэмэлт маягийн гэрчилгээ;</p> <p>(5) тухайн материал, эд анги, эсхүл хэрэгслийн нийцлийг тогтоосон ИНД-145-ын дагуу хангамжийн байгууллагын гэрчилгээ эзэмшигчийн олгосон шилжүүлэх мэдэгдэлтэй байх; эсхүл</p> <p>(6) стандарт эд анги байх; эсхүл</p> <p>(7) тухайн зорилгоор Дарга хүлээн зөвшөөрсөн, импортын эд анги байх.</p> | <p>2/ тухайн бүтээгдэхүүнд техник үйлчилгээний ажлыг гүйцэтгэдэг этгээд үйлдвэрлэсэн байх бөгөөд солих, эсхүл өөрчлөх эд анги, материал, нэмэлт тоног төхөөрөмж нь:</p> <p>2.1. бүтээгдэхүүнд хийгдсэн аливаа загварын өөрчлөлтийг багтааж, батлагдсан маягийн загварт нийцэж буйг эрх бүхий этгээдээр баталгаажуулсан байх;</p> <p>2.2. энэ дүрмийн бүлэг Н-ийн дагуу таних тэмдэглэгээ хийгдсэн байх; эсхүл.</p> <p>3/ ИНД-145-ын дагуу гэрчилгээжсэн техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээ эзэмшигчээс <i>“ИНЕГ Маягт Нэг” – Баталгаат зөвшөөрлийн гэрчилгээ</i> -г олгогдсон байх; эсхүл,</p> <p>4/ тухайн эд анги, нэмэлт тоног төхөөрөмжийг дор заасны дагуу үйлдвэрлэх ИНД-148-ын дагуу гэрчилгээжсэн үйлдвэрлэгч байгууллагын гэрчилгээ эзэмшигчээс <i>“ИНЕГ Маягт Нэг” - Баталгаат зөвшөөрлийн гэрчилгээ</i>” олгогдсон байх:</p> <p>4.1. техникийн стандарт (TSO)-ийн зөвшөөрөл; эсхүл,</p> <p>4.2. эд ангийг үйлдвэрлэх зөвшөөрөл; эсхүл,</p> <p>4.3. энэ дүрмийн Д Бүлгийн дагуу олгосон нэмэлт маягийн гэрчилгээний; эсхүл,</p> <p>5/ материал, эд анги, нэмэлт тоног төхөөрөмжийн нийцлийг тогтоох эрх бүхий ИНД-144-ийн дагуу гэрчилгээжсэн хангамжийн байгууллагаар баталгаажсан зөвшөөрөлтэй байх; эсхүл</p> <p>6/ стандартын эд анги байх; эсхүл</p> <p>7/ ИНЕГ-ын даргын хүлээн зөвшөөрсөн импортлогдсон эд анги байна.</p> | <p>-“Монгол Улсын TSO зөвшөөрөл”, “Монгол Улсын PMA зөвшөөрөл”</p> |
| <p>21.305. Процессыг зөвшөөрөх, эсхүл хүлээн зөвшөөрөх</p> <p>Хэрэв маягийн гэрчилгээ олгоход тавих НТЧ-ын, эсхүл ИНД-ийн шаардлага хангахад тухайн процесс шаардлагатай бол түүнийг:</p> <p>(1) ИНД-145-ын дагуу олгосон техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт багтаасан байна; эсхүл,</p> <p>(2) ИНД-148-ын дагуу олгосон үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт багтаасан байна; эсхүл</p> <p>(3) Даргын хүлээн зөвшөөрөхүйц өөр хэлбэрээр гаргасан байна.</p> | <p>21.305 Технологийн арга ажиллагааг хүлээн зөвшөөрөх ба баталгаажуулах/Approval or acceptance of processes</p> <p>(a) Технологийн арга ажиллагаа нь иргэний нисэхийн холбогдох дүрэм болон маягийн гэрчилгээ олгоход тавигдах НТЧ-ын шаардлагуудыг хангасан тохиолдолд тэдгээрийг:</p> <p>1/ ИНД-145-ын дагуу гэрчилгээжсэн техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээ эзэмшигч нь байгууллагын ерөнхий зааварт оруулна; эсхүл,</p> <p>2/ ИНД-148-ын дагуу гэрчилгээжсэн үйлдвэрлэгч байгууллагын гэрчилгээ эзэмшигч нь байгууллагын ерөнхий зааварт оруулна; эсхүл</p> <p>3/ ИНЕГ-ын даргын хүлээн зөвшөөрсөн бусад баримт бичигт оруулна.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |

| L Бүлэг - Экспортын НТЧ-ын гэрчилгээ | БҮЛЭГ. НИСЛЭГТ ТЭНЦЭХ ЧАДВАРЫН ЭКСПОРТЫН ГЭРЧИЛГЭЭ/ EXPORT AIRWORTHINESS CERTIFICATES | |
|--|--|---|
| <p>21.321. Зорилго</p> <p>Энэ Бүлэг нь дараах гэрчилгээ олгох зохицуулалтын шаардлагыг тогтооно:</p> <p>(1) бүтээгдэхүүнийг экспортод гаргахад зориулсан экспортын НТЧ-ын гэрчилгээ;</p> <p>(2) эд анги, хэрэгслийг экспортод гаргахад зориулсан САА Form One - шилжүүлэхийг зөвшөөрсөн гэрчилгээ.</p> | <p>21.321 Үйлчлэх хүрээ/ Scope</p> <p>(a) Энэ бүлгээр дараах үйл ажиллагааны журмыг тогтооно:</p> <p>1/ бүтээгдэхүүнийг экспортлоход НТЧ-ын экспортын гэрчилгээ олгох;</p> <p>2/ эд анги болон нэмэлт тоног, төхөөрөмжийг экспортлоход “ИНЕГ Маягт Нэг” – Баталгаат зөвшөөрлийн гэрчилгээ” -г олгох.</p> | <p>-Орчуулга найруулга зассан</p> |
| <p>21.323. Нөөц 21.325. Нөөц</p> | <p>21.323. Нөөц/ Reserved 21.325. Нөөц/ Reserved</p> | |
| <p>21.327. Экспортын НТЧ-ын гэрчилгээний үл хамаарал</p> <p>Хэрэв экспортын НТЧ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь 21.333(b)-гийн дагуу импортлогч улсын бичгээр үйлдсэн мэдэгдлийг хүргүүлсэн бол, Дарга экспортын НТЧ-ын гэрчилгээг дараах үл хамаарлын жагсаалттай хамт олгож болно:</p> <p>(1) энэ Бүлгийн биелэгдээгүй шаардлага;</p> <p>(2) экспортод гаргасан бүтээгдэхүүн болон холбогдох маягийг зөвшөөрсөн, эсхүл маягийг хүлээн зөвшөөрсөн бүтээгдэхүүн хоорондын конфигурацийн зөрүү</p> | <p>21.327. НТЧ-ын экспортын гэрчилгээний ялгаа /Export airworthiness certificate exceptions</p> <p>(a) Өргөдөл гаргагч нь энэ дүрмийн 21.333 (б)-д заасны дагуу, бүтээгдэхүүнийг импортлогч улсаас бичгээр баталгаа гаргуулсан тохиолдолд ИНЕГ-ын дарга дараах заалтыг үл харгалзан НТЧ-ын экспортын гэрчилгээг олгож болно:</p> <p>1/ энэ бүлгийн шаардлагыг хангаагүй; эсхүл</p> <p>2/ экспортлох бүтээгдэхүүн болон маягийн баталгаажуулсан эсхүл маягийг хүлээн зөвшөөрсөн бүтээгдэхүүний хооронд бүтцийн ялгаатай байдал.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Exception –“ялгаа” гэснийг “үл хамаарал” гэж өөрчилсөн</p> |
| <p>21.329. Хүсэлт гаргах нөхцөл</p> <p>Экспортлогч, эсхүл түүний эрх бүхий төлөөлөгч нь бүтээгдэхүүнд экспортын НТЧ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргаж болно.</p> | <p>21.329. Өргөдөл гаргах эрх / Eligibility</p> <p>(a) Бүтээгдэхүүндээ НТЧ-ын экспортын гэрчилгээ авах өргөдлийг экспортлогч байгууллага, эсхүл түүний эрх бүхий төлөөлөгч гаргана.</p> | |
| <p>21.331. Экспортын НТЧ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах</p> <p>(a) Экспортын НТЧ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь САА 24021/10 маягыг бөглөж, дараах баримт бичгийг зохих төлбөрийн баримтын хамт, Даргад хүргүүлэх үүрэгтэй:</p> <p>(1) дараах нотлох баримт:</p> <p>(i) тухайн бүтээгдэхүүн нь импортлогч улсын хүлээн зөвшөөрөхүйц маягийн загварт нийцэж байгааг;</p> <p>(ii) импортлогч улсын гэрчилгээжүүлэлтийн тусгай нөхцөлийг хангасан болохыг;</p> <p>(iii) импортлогч улс нь гэрчилгээнд заасан үл хамаарлыг хүлээн зөвшөөрсөн болохыг;</p> <p>(iv) тухайн бүтээгдэхүүнийг Q Бүлгийн дагуу таньж тогтоосон болохыг;</p> | <p>21.331. Өргөдөл гаргах / Application for export airworthiness certificate</p> <p>(a) НТЧ-ын экспортын гэрчилгээ авах өргөдөл гаргагч нь ИНЕГ-021/10 маягыг бөглөж, дараах зүйлийг төлбөрийн баримтын хамт ИНЕГ-ын даргад ирүүлнэ:</p> <p>1/ нотлох баримт бичиг:</p> <p>1.1. бүтээгдэхүүний маягийн загварыг импортлож буй улсын иргэний нисэхийн эрх бүхий байгууллагаас хүлээн зөвшөөрсөн тухай;</p> <p>1.2. импортлож буй улсын гэрчилгээжүүлэлтийн тусгай нөхцөл шаардлагуудыг хангасан тухай;</p> <p>1.3. импортлож буй улс нь экспортын гэрчилгээний хавсралтад заасан зөрүүтэй заалтыг хүлээн зөвшөөрсөн тухай;</p> <p>1.4. бүтээгдэхүүнд энэ дүрмийн Н.Бүлгийн дагуу таних тэмдэглэгээ хийгдсэн тухай;</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |

(v) холбогдох НТЧ-ын удирдамжийг хангасан болохыг;

(2) шинэ бүтээгдэхүүнээс бусад бүтээгдэхүүний хувьд, Даргын шаардаж болох бүртгэлийн дэвтэр, модификаци, засварын маягт болон түүхэн бүртгэл;

(3) бүтээгдэхүүний хадгалалт болон баглаа боодлын тухайн аргын хүчинтэй хугацааг багтаасан бүтээгдэхүүнийг тээвэрлэх, эсхүл хадгалах явцад зэврэлт болон гэмтлээс хамгаалахын тулд хэрэглэсэн аргын тайлбар;

(4) импортлогч улсын худалдан авагчийн өмчлөлд шилжсэн, эсхүл шилжүүлэхээр хүлээгдэж байгаа огноо;

(5) хүсэлт гаргах үед бүрдээгүй байсан баримт бичгийг бүрдүүлэхээр хүлээгдэж байгаа огноо;

(6) энэ Бүлгийн аливаа зөрүүний дагалдах баримт бичиг;

(7) хэрэв тухайн маягтад үзүүлсний дагуу Дарга шаардсан бол тухайн бүтээгдэхүүн болон хүсэлт гаргагчтай холбоотой нэмэлт мэдээлэл.

(b) Агаарын хөлөгт экспортын НТЧ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь энэ зүйлийн (a)-д зааснаас гадна, дараах баримт бичгийг Даргад хүргүүлэх үүрэгтэй:

(1) дараах нотлох баримт:

(i) шинэ агаарын хөлгийн хувьд, ИНД-148-ын дагуу олгосон үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээний эрхийн хүрээнд үйлдвэрлэсэн болохыг;

(ii) шинээс бусад агаарын хөлгийн хувьд, Н Бүлгийн дагуу НТЧ-ын гэрчилгээ эзэмшиж байгаа, эсхүл гэрчилгээжүүлэлтийн шалгуурт тэнцэж байгааг;

(iii) тухайн агаарын хөлөг нь тохирох нислэгийн заавартай ба шинэ агаарын хөлгийн хувьд, техник үйлчилгээний заавартай болохыг;

(iv) хэрэв хамааралтай бол ачааллын хуваарийг агуулсан жин төвлөрөлтийн тайланг бүрэн хийсэн болохыг;

(v) тухайн агаарын хөлөгт экспортын НТЧ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргахаас өмнөх 60 хоногийн дотор 100 цагийн, эсхүл үйлдвэрлэгчийн техник үйлчилгээний хуваарийн дагуу дүйцэх, үзлэг шалгалт, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц дүйцэх үзлэг шалгалт хийсэн болохыг;

(vi) экспортод гаргах зорилгоор суурилуулсан эд анги

1.5. хамаарах НТЧ-ын удирдамжийг гүйцэтгэсэн тухай;

2/ ашиглалтанд байсан бүтээгдэхүүний хувьд, ашиглалтын нийт хугацаанд хөтөлсөн техник үйлчилгээ, томоохон засвар, өөрчлөлтийг тэмдэглэсэн бүртгэлийн баримт;

3/ тухайн бүтээгдэхүүнийг тээвэрлэх, хадгалах явцад зэврэлт болон эвдэрч гэмтэхээс хамгаалж боож баглах арга хэрэгсэл, хадгалалтын хугацааны талаарх тодорхойлолт;

4/ импортолж буй улсын худалдан авагчид илгээх огноо;

5/ өргөдөл гаргах үед бүрдээгүй байсан баримт бичгийг гүйцээж өгөх огноо;

6/ энэ бүлгийн өөрчлөлтийг тайлбарласан тухай;

7/ ИНЕГ-ын дарга нь шаардлагатай гэж үзвэл маягтанд тусгагдсан асуулгыг тодорхой болгох үүднээс бүтээгдэхүүний талаарх нэмэлт тодруулгыг өргөдөл гаргагчаас шаардаж болно.

(б) Агаарын хөлөгт НТЧ-ын экспортын гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь энэ зүйлийн (a)-д зааснаас гадна дараах зүйлийг ИНЕГ-ын даргад гаргаж өгнө:

1/ нотлох бичиг баримт:

1.1. шинэ агаарын хөлгийн хувьд, ИНД-148-ын дагуу гэрчилгээжсэн үйлдвэрлэгч байгууллагын зөвшөөрлийн хүрээнд үйлдвэрлэсэн гэдгийг баталсан;

1.2. ашиглалтад байсан агаарын хөлгийн хувьд энэ дүрмийн Бүлэг E-д заасан ангиллын дагуу олгосон НТЧ-ын гэрчилгээ;

1.3. агаарын хөлгийн нислэгийн заавар, шинэ агаарын хөлгийн хувьд техник үйлчилгээний заавар;

1.4. агаарын хөлгийн жин төвлөрөлтийн мэдээлэл, ачааллын тооцооны маягт;

1.5. өргөдөл гаргахаас өмнөх 60 хоногийн дотор агаарын хөлөг нь 100 цагийн болон үйлдвэрлэгчийн техник үйлчилгээний хуваарийн дагуу хийгдэх үзлэг, эсхүл түүнтэй адилтгах хэмжээний ИНЕГ-ын дарга хүлээн зөвшөөрсөн үзлэгт орсон тухай баримт;

1.6. экспортод гаргаж буй агаарын хөлгийг хүргэх шаардлагын үүднээс тоног төхөөрөмж суурилуулах бол

-Орчуулга,
найруулга зассан

| | | |
|--|---|------------------------------------|
| <p>нь хамааралтай НТЧ-ын шаардлага хангаж байгааг, эсхүл Н Бүлгийн дагуу тусгай категори - тусгай нислэгийн зөвшөөрлийн НТЧ-ын гэрчилгээ олгосноор зөвшөөрсөн болохыг;</p> <p>(2) энэ зүйлийн (b)(1)(vi)-д заасан суурилуулсан эд ангийг хүргэлтийн нислэг дууссаны дараа буцаан авч тухайн агаарын хөлгийг зөвшөөрсөн маягийн конфигурацид нийцүүлэн сэргээсэн тухай нотолгоо.</p> <p>(c) Хэрэв <u>Дарга</u> шаардлагатай гэж үзвэл, хүсэлт гаргагч нь экспортын НТЧ-ын гэрчилгээ эзэмших бүтээгдэхүүн болон холбогдох баримт өгөгдлийг үзлэг шалгалтад бэлэн байлгах үүрэгтэй.</p> | <p>тухайн тоног төхөөрөмж нь НТЧ-ын холбогдох шаардлагуудыг хангаж, энэ дүрмийн Бүлэг E –ын дагуу олгох тусгай нислэгийн зөвшөөрлөөр баталгаажсан байх;</p> <p>2/ энэ хэсгийн (б)-гийн 1/ 1.6-д тодорхойлсон суурилуулсан тоног төхөөрөмжийг агаарын хөлгийг хүргэх нислэг дууссаны дараа буцаан авч батлагдсан маягийн шаардлагын дагуу агаарын хөлгийн бүтцийг сэргээнэ.</p> <p>(в) Өргөдөл гаргагч нь <u>ИНЕГ</u>-аас шалгах үед экспортлох бүтээгдэхүүн болон түүний баримт бичгийг бэлэн байлгана.</p> | |
| <p>21.333. Экспортын НТЧ-ын гэрчилгээ олгох</p> <p>(a) Хэрэв <u>Дарга</u> дараах шаардлага хангагдсан гэж үзвэл, хүсэлт гаргагч нь экспортын НТЧ-ын гэрчилгээ эзэмших эрхтэй ба <u>Дарга тухайн</u> бүтээгдэхүүнд экспортын НТЧ-ын гэрчилгээ олгож болно:</p> <p>(1) хүсэлт гаргагч энэ Бүлгийн холбогдох шаардлагыг хангасан байх;</p> <p>(2) тухайн гэрчилгээг олгох нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлахгүй байх;</p> <p>(3) хангагдаагүй НТЧ-ын шаардлагыг аюулгүй байдлын хүлээн зөвшөөрөхүйц түвшнийг хангасан хүчин зүйлээр нөхсөн байх.</p> <p>(b) Энэ зүйлийн (a)(1)-ийг үл харгалзан, хэрэв хүсэлт гаргагч нь тодорхой шаардлага хангаагүй байж болохыг импортлогч улс хүлээн зөвшөөрсөн нотлох баримтыг бичгээр хүргүүлсэн бол, Дарга 21.331-ийн НТЧ-ын шаардлага бүрийг хангаагүй бүтээгдэхүүнд экспортын НТЧ-ын гэрчилгээ олгож болно.</p> <p>(c) Энэ Бүлгийн дагуу <u>Даргын</u> олгосон экспортын НТЧ-ын гэрчилгээнд:</p> <p>(1) <u>Дарга</u>, тодорхой тохиолдол бүрд шаардлагатай гэж үзсэн нөхцөлийг зааж өгч болно;</p> <p>(2) бүтээгдэхүүнийг суурилуулах, эсхүл ашиглахыг зөвшөөрөхгүй байж болно.</p> | <p>21.333. НТЧ-ын экспортын гэрчилгээ олгох/ Issue of export airworthiness certificate</p> <p>(a) <u>ИНЕГ</u>-ын дарга нь дараах шаардлагыг хангасан өргөдөл гаргагчийн бүтээгдэхүүнд НТЧ-ын экспортын гэрчилгээ олгоно:</p> <p>1/ энэ бүлгийн холбогдох шаардлагуудыг хангасан;</p> <p>2/ гэрчилгээ олгосноор нисэхийн аюулгүй байдалнд харшлахгүй байх нөхцөлийг хангасан;</p> <p>3/ НТЧ-ын аливаа шаардлагыг хангаагүй тохиолдолд тэдгээр нь зохих хүчин зүйлээр нөхөгдөж, хүлээн зөвшөөрөхүйц адилтгах хэмжээний аюулгүй ажиллагааны түвшинг хангасан.</p> <p>(б) Хэрэв өргөдөл гаргагчийн бүтээгдэхүүн нь энэ дүрмийн тодорхой шаардлагуудыг хангахгүй байгаа боловч импортлогч улсаас бүтээгдэхүүнийг хүлээн зөвшөөрсөн тухай бичгээр баталгаа гаргаж ирүүлсэн тохиолдолд <u>ИНЕГ</u>-ын дарга 21.331-д заасан НТЧ-ын шаардлагуудыг хангаагүй бүтээгдэхүүнд энэ зүйлийн (a) 1/-д заасныг үл харгалзан НТЧ-ын экспортын гэрчилгээг олгож болно.</p> <p>(в) Энэ бүлгийн дагуу <u>ИНЕГ</u>-ын дарга нь НТЧ-ын экспортын гэрчилгээг олгохдоо:</p> <p>1/ шаардлагатай гэж үзвэл тодорхой нөхцөлийг зааж өгч болох; ба</p> <p>2/ бүтээгдэхүүнийг агаарын хөлөгт суурилуулах, эсхүл ашиглахыг зөвшөөрөхгүй.</p> | <p>-Орчуулга найруулга зассан</p> |
| <p>21.335. Гэрчилгээний хүчинтэй байдал</p> <p>(a) Энэ Бүлгийн дагуу олгосон экспортын НТЧ-ын гэрчилгээ нь, тухайн бүтээгдэхүүний дараагийн загварын өөрчлөлт гараагүй бол, импортлогч улсад хүлээлгэн өгөх хүртэл</p> | <p>21.335. Гэрчилгээний хүчинтэй хугацаа/ Validity of certificate</p> <p>(a) Энэ бүлгийн дагуу олгосон НТЧ-ын экспортын гэрчилгээ нь агаарын хөлгийн бүтээгдэхүүний загварт аливаа өөрчлөлт хийлгүйгээр импортолж буй улс хүлээн авах хүртэл хүчин</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |

| | | |
|--|--|---|
| <p>хүчинтэй хэвээр байна.</p> <p>(b) Загварын өөрчлөлтийн улмаас хүчингүй болсон экспортын НТЧ-ын гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээг <u>Даргад</u> нэн даруй хураалгана.</p> | <p>төгөлдөр байна.</p> <p>(б) Загварт өөрчлөлт оруулсан тохиолдолд НТЧ-ын экспортын гэрчилгээ хүчингүй болох бөгөөд эзэмшигч нь гэрчилгээг <u>ИНЕГ</u>-т буцаан өгнө.</p> | |
| <p>21.337. Гэрчилгээг шилжүүлэх</p> <p>Экспортын НТЧ-ын гэрчилгээг тухайн бүтээгдэхүүний хамт шилжүүлнэ.</p> | <p>21.337. Гэрчилгээг шилжүүлэх/ Transfer of certificate</p> <p>(a) НТЧ-ын экспортын гэрчилгээг зөвхөн бүтээгдэхүүний хамт шилжүүлнэ.</p> | |
| <p>21.339. САА Form One - гэрчилгээг экспортод хэрэглэх</p> <p>(a) САА Form One - шилжүүлэхийг зөвшөөрсөн гэрчилгээг дараах тохиолдолд зөвхөн эд анги, эсхүл хэрэгслийг экспортод гаргахад хэрэглэх ёстой, хэрэв:</p> <p>(1) тухайн эд анги, <u>эсхүл хэрэгсэл</u> нь:</p> <p>(i) шинэ болон шинээр их засвар хийсэн, эсхүл стандарт, эсхүл хязгаарлалттай <u>категорийн</u> хүчинтэй НТЧ-ын гэрчилгээтэй агаарын хөлөгт хамгийн сүүлд суурилуулсан ба тухайн эд анги, эсхүл хэрэгсэл нь ашиглалтад шилжүүлэх шаардлагад тохирч байгаа бол;</p> <p>(ii) зөвшөөрөгдсөн загварын өгөгдөлд нийцэж байгаа бол;</p> <p>(iii) аюулгүй ажиллагааг хангах нөхцөлд байгаа бол;</p> <p>(iv) импортлогч улсын шаардсан импортын тусгай нөхцөлийг хангаж байгаа бол;</p> <p>(2) САА Form One - шилжүүлэхийг зөвшөөрсөн гэрчилгээг дараах байгууллагын журмын дагуу олгосон бол:</p> <p>(i) ИНД-145-ын дагуу гэрчилгээжсэн агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллага; эсхүл</p> <p>(ii) ИНД-148-ын дагуу гэрчилгээжсэн агаарын хөлөг үйлдвэрлэх байгууллага.</p> <p>(b) Хэрэв эд анги, эсхүл хэрэгслийг импортлогч улс хүлээн зөвшөөрөхүйц болохыг бичгээр мэдэгдсэн бол, тухайн эд анги, эсхүл хэрэгсэл нь энэ зүйлийн (a)-ийн бүх шаардлагыг хангаагүй байж болно.</p> | <p>21.339. Бүтээгдэхүүн экспортлох үйл ажиллагаанд “ИНЕГ Маягт Нэг” –Баталгаат зөвшөөрлийн гэрчилгээ”-г ашиглах/ Use of CAA Form One – authorised release certificate for export</p> <p>(a) Дараах шаардлагыг хангасан эд анги эсхүл нэмэлт тоног төхөөрөмжийг экспортлоход “ИНЕГ Маягт Нэг - Баталгаат зөвшөөрлийн гэрчилгээ”-г ашиглана:</p> <p>1/ эд анги <u>болон нэмэлт тоног төхөөрөмж</u> нь:</p> <p>1.1. шинэ, их засвар хийгдсэн, стандарт, эсхүл хязгаарлагдмал <u>ангиллын</u> НТЧ-ын хүчин төгөлдөр гэрчилгээтэй агаарын хөлөгт суурилуулж байсан ба техник үйлчилгээнээс гаргахад тавигдах шаардлагуудыг хангасан байх;</p> <p>1.2. загварын батлагдсан техникийн үзүүлэлтийг хангасан байх;</p> <p>1.3. аюулгүй ашиглах нөхцөлийг хангасан байх;</p> <p>1.4. импортлогч улсын импортын бүтээгдэхүүнд тавьдаг тусгай шаардлагуудыг хангасан байх.</p> <p>2/ “ИНЕГ Маягт Нэг -Баталгаат зөвшөөрлийн гэрчилгээ”-г дараах байгууллагууд нь зохих журмын дагуу олгоно:</p> <p>2.1. ИНД-145-ын дагуу гэрчилгээжсэн техник үйлчилгээний байгууллага;</p> <p>2.2. ИНД-148-ын дагуу гэрчилгээжсэн үйлдвэрлэгч байгууллага.</p> <p>(б) Хэрэв импортлогч улс нь тухайн эд анги эсхүл нэмэлт тоног төхөөрөмжийг хүлээн зөвшөөрсөн тухайгаа албан бичгээр мэдэгдсэн тохиолдолд эд анги, нэмэлт тоног төхөөрөмж нь энэ зүйлийн (a) 1/ дэх заалтыг бүрэн хангахгүй байж болно.</p> | <p>- Орчуулга, найруулга зассан</p> <p>-authorised release certificate- “баталгаат зөвшөөрлийн гэрчилгээ” гэснийг “шилжүүлэхийг зөвшөөрсөн гэрчилгээ” гэж өөрчилсөн</p> |
| <p>21.341. Экспортлогчийн үүрэг хариуцлага</p> <p>(a) Агаарын хөлгийн эзэмшлийг гадаадын худалдан авагчид шилжүүлэх, эсхүл шилжүүлсэн тохиолдолд, экспортын НТЧ-ын гэрчилгээ олгогдсон экспортлогч нь:</p> <p>(1) хамааралтай бол, агаарын хөлгийн Монгол Улсын бүртгэлийн болон НТЧ-ын гэрчилгээг хүчингүй болгуулах хүсэлтийг гадаадын өмчлөгчийн нэр, хаяг, эзэмшлийг шилжүүлсэн огноо зэргийн хамт гаргана;</p> <p>(2) бүртгэлийн болон НТЧ-ын гэрчилгээг Даргад буцаана;</p> | <p>21.341. Экспортлогчийн үүрэг/ Responsibilities of an exporter</p> <p>(a) НТЧ-ын экспортын гэрчилгээ авсан агаарын хөлгийн экспортлогч нь дараах үүргийг хүлээнэ:</p> <p>1/ агаарын хөлгийн улсын бүртгэлийн болон НТЧ-ын гэрчилгээг хүчингүй болгуулах өргөдлийг агаарын хөлгийг шилжүүлэн өгөх огноо, авч буй гадаадын өмчлөгчийн нэр, хаягийн хамт <u>ИНЕГ</u>-т гаргаж өгнө;</p> <p>2/ агаарын хөлгийн улсын бүртгэлийн болон НТЧ-ын гэрчилгээг</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |

| | | |
|--|--|------------------------------------|
| <p>(3) <u>Монгол Улсын үндэсний харъяалал болон бүртгэлийн дугаарыг тухайн агаарын хөлгөөс арилгасныг баталгаажуулсан мэдэгдлийг хүргүүлнэ.</u></p> <p>(b) Импортлогч улстай өөрөөр тохиролцсоноос бусад тохиолдолд, экспортын НТЧ-ын гэрчилгээ олгосон экспортлогч нь:</p> <p>(1) импортлогч улсын эрх бүхий байгууллагад дараах баримт бичгийг хүргүүлнэ:</p> <p>(i) тухайн бүтээгдэхүүний зөв ажиллагаанд шаардлагатай бүх баримт бичиг, мэдээлэл болон импортлогч улсын тусгай шаардлагад заасан бусад материал;</p> <p>(ii) угсраагүй агаарын хөлгийн хувьд, үйлдвэрлэгчийн холбогдох угсрах заавар болон шалгах нислэгийн батлагдсан шалгах хуудас;</p> <p>(2) тээвэрлэлт, эсхүл хадгалалтын үед бүтээгдэхүүнийг зэврэлт, гэмтлээс хамгаалах хадгалалтын баглаа хийнэ;</p> <p>(3) агаарын хөлгийн экспортын хүргэлт дуусахад хүргэлтийн зорилгоор суурилуулсан түр зуурын суурилуулалтыг салгах, эсхүл салгуулах ба тухайн агаарын хөлгийг зөвшөөрсөн маягийн конфигурацид буцаан оруулна.</p> | <p><u>ИНЕГ</u>-ын даргад буцааж өгнө;</p> <p>3/ <u>агаарын хөлөг дээрх Монгол Улсын үндэсний болон бүртгэлийн таних тэмдэг авсныг гэрчлэх баримтыг гаргаж өгнө.</u></p> <p>(б) Импортлогч улстай өөрөөр хэлэлцэн тохироогүй бол НТЧ-ын экспортын гэрчилгээ авсан экспортлогч нь:</p> <p>1/ импортлогч улсын иргэний нисэхийн асуудал эрхэлсэн холбогдох байгууллагад дараах баримт бичгийг илгээсэн байна:</p> <p>1.1. бүтээгдэхүүний ашиглалтын баримт бичиг, мэдээлэл болон импортлогч улсын тусгай шаардлагын дагуу урьдчилан тохирсон холбогдох бусад материал, баримтууд;</p> <p>1.2. агаарын хөлгийг угсраагүй тохиолдолд үйлдвэрлэгчийн угсралтын заавар болон шалгах нислэгийн хөтөлбөрийг.</p> <p>2/ бүтээгдэхүүнийг тээвэрлэх болон хадгалалтын үед аливаа гэмтэл, зэврэлтээс хамгаалах үүднээс баглаж боосон байх;</p> <p>3/ экспортын хүргэж өгөх ажиллагаа дууссаны дараа агаарын хөлөгт хүргэж өгөх зорилгоор суурилуулсан аливаа тоноглол, төхөөрөмжийг буцаан авч батлагдсан маягийн дагуу агаарын хөлгийн бүтцийг сэргээнэ.</p> | |
| <p>М Бүлэг-Засвар</p> | <p>И БҮЛЭГ. ЗАСВАР/ REPAIRS</p> | |
| <p>21.431. Хамрах хүрээ Энэ Бүлэг нь засварын загварт зөвшөөрөл олгох арга хэлбэрийг тогтооно.</p> | <p>21.431. Үйлчлэх хүрээ/ Scope (a) Энэ бүлгээр загварт хийгдсэн засварыг баталгаажуулах журмыг тогтооно</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |
| <p>21.433. Засварын загварын зөвшөөрөл Маягийн гэрчилгээ, эсхүл маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээний дагуу зөвшөөрөгдөөгүй засвар болон загварыг С, D, эсхүл E Бүлгийн дагуу зөвшөөрөл олгох шаардлагатай загварын өөрчлөлт гэж үзнэ.</p> | <p>21.433. Загварт хийгдсэн засварын баталгаажилт/ Approval of designs for repairs (a) Маягийн гэрчилгээ эсхүл Маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээний дагуу баталгаажуулахгүй, загварт хийгдсэн засварын ажлыг загварт өөрчлөлт хийсэн гэж үзэн баталгаажуулах ажиллагааг энэ дүрмийн В, Г, Д Бүлэгт заасны дагуу хийнэ.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |
| <p>Н Бүлэг-Техникийн өгөгдөл болон НТЧ-ын тодорхойлолт</p> | <p>К БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ, НТЧ-ЫН ТОДОРХОЙЛОЛТ/ TECHNICAL DATA AND AIRWORTHINESS SPECIFICATIONS</p> | |

| | | |
|---|--|------------------------------------|
| <p>21.501. Зорилго Энэ Бүлэг нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно:</p> <p>(1)техникийн өгөгдлийг зөвшөөрөх, эсхүл хүлээн зөвшөөрөх; (2)материал, эд анги, хэрэгсэл, эсхүл процессын тодорхойлолтыг зөвшөөрөх, эсхүл хүлээн зөвшөөрөх; (3)материал, эд анги, процесс, эсхүл хэрэгслийн тодорхойлолтоос хазайх хүсэлтийг зөвшөөрөх.</p> | <p>21.501. Үйлчлэх хүрээ/ Scope (a) Энэ бүлгээр дараах үйл ажиллагаатай холбоотой журмыг тогтооно: 1/ техникийн үзүүлэлтийг хүлээн зөвшөөрөх эсхүл баталгаажуулах; 2/ материал, эд анги, нэмэлт тоног төхөөрөмж болон технологийн арга ажиллагааны тодорхойлолтыг хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах; 3/ материал, эд анги, нэмэлт тоног төхөөрөмж болон технологийн арга ажиллагааны тодорхойлолтоос хазайсан өөрчлөлтийг баталгаажуулах</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |
| <p>21.503. Хүлээн зөвшөөрөхүйц техникийн өгөгдөл</p> <p>(a) Техникийн өгөгдлийг зөвхөн зөвшөөрсөн,эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц тохиолдолд ашиглаж болно. (b) Хүлээн зөвшөөрөхүйц техникийн өгөгдлийг энэ Дүрмийн Хавсралт D-д заасан.</p> | <p>21.503. Техникийн үзүүлэлтийг хүлээн зөвшөөрөх/ Acceptable technical data (a) ИНЕГ-ын даргын баталсан, эсхүл хүлээн зөвшөөрсөн техникийн үзүүлэлтийг ашиглана. (б) Энэ дүрмийн Хавсралт Г-д заасан техникийн үзүүлэлтүүдийг хүлээн зөвшөөрнө.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |
| <p>21.505. Form CAA 337-Техникийн өгөгдлийн зөвшөөрөл</p> <p>(a)Энэ зүйлийн (b) болон (c)-д зааснаас бусад тохиолдолд, техникийн өгөгдлийн зөвшөөрөл авах хүсэлт гаргагч нь CAA 337 маягыг бөглөж зохих төлбөрийн баримт болон дараах мэдээллийг Даргад хүргүүлэх үүрэгтэй: (1)хүсэлт гаргагчийн нэр Монгол Улсад үйлчилгээ эрхлэх хаяг; (2)өгөгдлийг тодорхойлоход хэрэгтэй бусад баримт бичиг; (3)дараах мэдээллийг багтаасан загварын өөрчлөлтийн тайлбар: (i) тухайн өөрчлөлтийг таньж тогтоох хангалттай өгөгдөл; (ii) өөрчлөлтөд өртсөн бүтээгдэхүүн, бүрдэл хэсэг, эсхүл хэрэгслийн эд анги бүрийг таньж тогтоох; (4)өгөгдлийн дагуу өөрчлөлт хийгдэх бүтээгдэхүүн, бүрдэл хэсэг, эсхүл хэрэгслийн хувьд: (i) хамааралтай НТЧ-ын шаардлага хангаж байгааг харуулахад шаардлагатай байж болох шинжлэн шалгах ажиллагаа, тест, эсхүл дүн шинжилгээний дэлгэрэнгүй мэдээлэл; (ii) тухайн бүтээгдэхүүн, бүрдэл хэсэг, эсхүл хэрэгсэлд зохих ёсоор үйлчилгээ хийж, ашиглахыг бататгах техник үйлчилгээний болон үйл ажиллагааны</p> | <p>21.505. Техникийн үзүүлэлтийг баталгаажуулах- ИНЕГ Маягт -337/ Form CAA337 – approval of technical data (a) Энэ зүйлийн (б) болон (в)-д зааснаас бусад тохиолдолд техникийн үзүүлэлтээ баталгаажуулах өргөдөл гаргагч нь дор заасан мэдээллийг шаардсан ИНЕГ-337 маягыг бөглөж, төлбөрийн баримтын хамт ИНЕГ-ын даргад ирүүлнэ: 1/ өргөдөл гаргагчийн Монгол Улсад үйл ажиллагаа явуулах нэр, хаяг; 2/ техникийн үзүүлэлтийг тодорхойлоход шаардлагатай аливаа баримт бичиг; 3/ дараах зүйлийг багтаасан загварын өөрчлөлтийн тодорхойлолт: 3.1. загварын өөрчлөлтийг тодорхойлох хангалттай техникийн үзүүлэлтийн мэдээлэл; 3.2. загварын өөрчлөлтөнд нөлөөлсөн агаарын хөлгийн бүрэлдэхүүн хэсэг, нэмэлт тоног төхөөрөмж, эсхүл бүтээгдэхүүний эд анги бүрийн тодорхойлолт. 4/ техникийн үзүүлэлтийн дагуу өөрчлөлт хийгдсэн эд анги, нэмэлт тоног төхөөрөмж болон бүтээгдэхүүний хувьд: 4.1. НТЧ-ын зохих шаардлагуудыг хангаж буйг үзүүлсэн аливаа үзлэг, шалгалтын болон шинжилгээ судалгааны ажлын дэлгэрэнгүй; болон; 4.2. зохих ёсоор техник үйлчилгээ хийгдэн, ашиглагдаж байгааг бататгах техник үйлчилгээний болон нислэгийн ашиглалтад нийцсэн үзүүлэлтүүд.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |

өгөгдөл;

(5) хэрэв тухайн маягтад үзүүлсний дагуу [Дарга](#) шаардсан бол хүсэлт гаргагч болон техникийн өгөгдөл, загварын өөрчлөлттэй холбоотой нэмэлт мэдээлэл;

(6) дараах баримт бичгийн аль нэгийг:

(i) техникийн өгөгдөл нь 21.31-д заасан НТЧ-ын шаардлага ИНД-26-д заасан холбогдох НТЧ-ын нэмэлт шаардлага болон 21.32-т заасан агаарын хөлгийн дуу чимээний болон хөдөлгүүрийн хийн ялгаруулалтын шаардлага хангасан ба холбогдох загварын өөрчлөлт нь хэрэгжүүлэлтэд тохиромжтой болохыг илэрхийлсэн, ИНД-146-гийн дагуу гэрчилгээжсэн зохион бүтээх байгууллагаас олгосон нийцлийн мэдэгдэл;

(ii) гадаадын зохих эрх бүхий байгууллагын шаардлагын дагуу гаргасан, энэ зүйлийн (a)(6)(i)-д шаардсантай дүйцэх мэдэгдэл;

(iii) техникийн өгөгдлийг зөвшөөрөл авах процессын явцад нийцлийн мэдэгдлийг хүргүүлэхээр бичгээр үйлдсэн хүсэлт.

(b) Энэ зүйлийн (a)(6)(i)-ийг үл харгалзан, нийцлийн мэдэгдэл нь тухайн техникийн өгөгдөл дараах шаардлагыг хангасныг мэдэгдэж болно:

(1) тухайн маягийн гэрчилгээнд иш татсан НТЧ-ын агаарын хөлгийн дуу чимээний болон хөдөлгүүрийн хийн ялгаруулалтын шаардлага; эсхүл

(2) хэрэв тусгай нөхцөл үйлчилж байгаа бол, энэ зүйлийн (a)(6)(i)-д шаардсантай дүйцэх аюулгүй байдлын түвшин.

(c) ИНД-146-гийн дагуу гэрчилгээжсэн агаарын хөлөг зохион бүтээх байгууллага нь энэ зүйлийн (a)-д шаардсан мэдээллийг бүртгэхдээ САА 337 маягтаас бусад баримт бичгийг ашиглаж болно.

(d) Хэрэв [Дарга](#) дараах шаардлага хангагдсан гэж үзвэл, хүсэлт гаргагч нь техникийн өгөгдлийн зөвшөөрөл авах эрхтэй [ба Дарга](#) техникийн өгөгдлийг зөвшөөрч болно:

(1) хүсэлт гаргагч энэ зүйлийн (a)-д заасан холбогдох шаардлагыг хангасан байх;

(2) тухайн өгөгдлийн зөвшөөрөл нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлахгүй байх;

5/ [ИНЕГ](#)-ын дарга нь шаардлагатай гэж үзвэл маягтанд тусгагдсан асуулгыг тодорхой болгох үүднээс загварын өөрчлөлт болон техникийн үзүүлэлттэй холбоотой нэмэлт тодруулгыг өргөдөл гаргагчаас шаардаж болно;

6/ эдгээр нь дараах зүйлүүд байж болно:

6.1. техникийн үзүүлэлт нь 21.31-д заасан НТЧ-ын шаардлага, ИНД-26-ийн НТЧ-ын нэмэлт шаардлагууд, мөн 21.32-т заасан агаарын хөлгийн дуу чимээ, хөдөлгүүрээс гарах хийн ялгаруулалтад тавигдах шаардлага болон загварын өөрчлөлттэй холбоотой бусад шаардлагуудыг хангасан тухай зохион бүтээгч байгууллагын мэдэгдэл;

6.2. энэ зүйлийн (a) 6/ 6.1-д шаардсантай адилтгах хэмжээний гадаадын Иргэний нисэхийн эрх бүхий байгууллагаас олгосон шаардлага хангасан тухай мэдэгдэл;

6.3. техникийн үзүүлэлтийг баталгаажуулах явцад шаардлага хангасан тухай мэдэгдлийг ирүүлэх тухай бичгээр гаргасан хүсэлт.

(б) Өргөдөл гаргагч нь энэ зүйлийн (a) 6/ 6.1-д заасныг бүрэн хангахгүй тохиолдолд техникийн үзүүлэлт нь дараах шаардлагыг хангаж байгаа тухай мэдэгдлийг гаргаж болно:

1/ Маягийн гэрчилгээнд заасан НТЧ-ын болон агаарын хөлгийн дуу чимээ, хөдөлгүүрээс гарах хийн ялгаруулалтад тавигдах шаардлагуудыг хангасан тухай;

2/ хэрэв тусгай нөхцөлөөр авч үзсэн тохиолдолд, энэ бүлгийн (a) 6.1 дэх заалтаар шаардсантай адилтгах хэмжээний аюулгүй ажиллагааны түвшинг хангасан тухай.

(в) Агаарын хөлгийн зохион бүтээгч байгууллагын гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (a)-аар шаардсан мэдээллийг [ИНЕГ](#)-337 маягтаас өөр баримт бичгээр гаргаж болно.

(г) Өргөдөл гаргагчийн техникийн үзүүлэлт нь дараах шаардлагуудыг хангасан тохиолдолд [ИНЕГ](#)-ын дарга баталгаажуулна:

1/ энэ зүйлийн (a)-д заасан шаардлагуудыг хангасан;

2/ батлагдсан техникийн үзүүлэлт нь аюулгүй ажиллагаанд харшлахгүй;

| | | |
|--|--|------------------------------------|
| <p>(3) хангаагүй НТЧ-ын шаардлагыг аюулгүй байдлын хүлээн зөвшөөрөхүйц түвшнийг хангасан хүчин зүйлээр нөхсөн байх;</p> <p>(4) тухайн бүтээгдэхүүн, бүрдэл хэсэг, эсхүл хэрэгсэл нь дараах тохиолдолд тэдгээрийг зориулалтын дагуу ашиглахад аюултай болгох хэв шинж, эсхүл үзүүлэлт байхгүй байх:</p> <p>(i) өгөгдлийн дагуу өөрчилсөн;</p> <p>(ii) зөв нэмж өөрчилсөн нислэгийн заавар, эсхүл бусад тогтоосон хязгаарлалтын дагуу ашигласан.</p> <p>(e) Энэ зүйлийн (d)(1)-ийг үл харгалзан, тухайн хүсэлт гаргагч энэ зүйлийн (a)-ийн бүх шаардлагыг хангаагүй байсан ч Дарга дараах тохиолдолд техникийн өгөгдлийг зөвшөөрч болно, хэрэв:</p> <p>(1) тухайн хүсэлт нь бүтээгдэхүүн, бүрдэл хэсэг, эсхүл хэрэгслээр хязгаарлагдсан бол;</p> <p>(2) тусгай категорийн НТЧ-ын гэрчилгээтэй агаарын хөлгийн техникийн өгөгдөл нь тухайн НТЧ-ын гэрчилгээ олгоход тавих стандартыг хангаж байгаа бол;</p> <p>(3) хүсэлт гаргагчийн ирүүлсэн өгөгдөл нь холбогдох загварын өөрчлөлтийг таньж тогтооход хангалттай бол.</p> | <p>3/ аливаа нэг НТЧ-ын шаардлагыг хангаагүй тохиолдолд тэдгээр нь зохих хүчин зүйлээр нөхөгдөж, хүлээн зөвшөөрөхүйц адилтгах хэмжээний аюулгүй ажиллагааны түвшинг хангасан;</p> <p>4/ агаарын хөлгийн бүрэлдэхүүн хэсэгт болон бүтээгдэхүүнд эсхүл нэмэлт тоног төхөөрөмжид дор заасан ажиллагааг хийж зориулалтын дагуу ашиглахад нислэгийн үзүүлэлтүүд болон загварын онцлогийн хувьд аюулгүй байх:</p> <p>4.1. техникийн үзүүлэлтийн дагуу өөрчлөхөд;</p> <p>4.2. нислэгийн зааварт, эсхүл бусад хязгаарлалтуудад зөв хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийн дагуу ашиглахад.</p> <p>(д) ИНЕГ-ын дарга нь дараах тохиолдолд энэ зүйлийн (a)-д заасныг шаардахгүйгээр өргөдөл гаргагчийн техникийн үзүүлэлтийг баталж болно:</p> <p>1/ хязгаарлагдмал хүрээний тухайн нэгж бүтээгдэхүүн болон нэмэлт тоног төхөөрөмж эсхүл бүрэлдэхүүн хэсэгт зориулан гаргасан техникийн үзүүлэлт бол;</p> <p>2/ техникийн үзүүлэлт нь Тусгай ангиллын агаарын хөлөгт НТЧ-ын гэрчилгээ олгоход тавигдах стандартуудыг хангаж байгаа бол;</p> <p>3/ өргөдөл гаргагч нь загварын өөрчлөлтийг тодорхойлох хангалттай техникийн үзүүлэлтийг ирүүлсэн бол.</p> | |
| <p>21.507. Тодорхойлолтыг зөвшөөрөх</p> <p>Материал, эд анги, процесс, эсхүл хэрэгслийн тодорхойлолтыг дараах хэлбэрээр зөвшөөрнө:</p> <p>(1) хэрэв тухайн тодорхойлолт нь хүлээн зөвшөөрөхүйц минимум гүйцэтгэлийн стандартыг тодорхойлдог болохыг харуулах хангалттай мэдээлэлтэй бол, Монгол Улсын TSO олгох; эсхүл</p> <p>(2) зөвшөөрөгдсөн загвар, эсхүл загварын өөрчлөлтийн тодорхойлолтыг зөвхөн тухайн загвар, эсхүл загварын өөрчлөлтөд хэрэглэх; эсхүл</p> <p>(3) Даргын хүлээн зөвшөөрөхүйц өөр аргаар.</p> | <p>21.507. Тодорхойлолтыг батлах/ Approval of specifications</p> <p>(a) Материал, эд анги, нэмэлт тоног төхөөрөмж болон технологийн арга ажиллагааны тодорхойлолтыг дараах замаар баталгаажуулна:</p> <p>1/ тодорхойлолт нь хүлээн зөвшөөрөгдөх стандартын минимум үзүүлэлтийн хангалттай мэдээллийг үзүүлсэн нөхцөлд техникийн стандарт (TSO)-ын зөвшөөрлийг олгох;</p> <p>2/ батлагдсан загвар эсхүл загварын өөрчлөлттэй холбоотой тодорхойлолтын өргөдлийг батлах;</p> <p>3/ ИНЕГ-ын даргын хүлээн зөвшөөрсөн бусад арга хэрэгслээр батлах.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |
| <p>21.509. Тодорхойлолтыг хүлээн зөвшөөрөх</p> <p>Материал, эд анги, процесс, эсхүл хэрэгслийн тодорхойлолт нь дараах тохиолдолд Даргын хүлээн зөвшөөрөхүйц байж болно, хэрэв:</p> <p>(1) Хавсралт С-д заасан НТЧ-ын загварын стандартаар гарсан, эсхүл тухайн НТЧ-ын загварын стандартад</p> | <p>21.509. Тодорхойлолтыг хүлээн зөвшөөрөх/ Acceptance of specifications</p> <p>(a) Материал, эд анги, нэмэлт тоног төхөөрөмж болон технологийн арга ажиллагааны тодорхойлолтыг дараах тохиолдолд ИНЕГ-ын дарга хүлээн зөвшөөрнө:</p> <p>1/ энэ дүрмийн Хавсралт В-д заасан загварын НТЧ-ын стандартад ашиглахыг зөвшөөрсөн болон зөвхөн тухайн загварын НТЧ-ын стандартад заасан зориулалтын дагуу</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |

| | | |
|--|--|------------------------------------|
| <p>түүнийг хэрэглэхийг хүлээн зөвшөөрсөн бөгөөд зөвхөн тухайн НТЧ-ын загварын стандартад хэрэглэсэн бол; эсхүл</p> <p>(2) гадаадын Иргэний нисэхийн эрх бүхий байгууллагаар зөвшөөрөгдсөн эсхүл хүлээн зөвшөөрөгдсөн бол; эсхүл</p> <p>(3) стандарт эд ангийн тодорхойлолт бөгөөд:</p> <p>(i) салбарын тогтсон тодорхойлолт бол; эсхүл</p> <p>(ii) Монгол Улсын үндэсний тодорхойлолт бол; эсхүл</p> <p>(iii) гадаадын үндэсний тодорхойлолт бол.</p> | <p>ашиглах бол; эсхүл,</p> <p>2/ тодорхойлолт нь гадаадын Иргэний нисэхийн удирдах байгууллагаас батлагдсан эсхүл хүлээн зөвшөөрсөн бол;</p> <p>3/ стандарт эд ангийн тодорхойлолтын хувьд:</p> <p>3.1. үйлдвэрлэлийн тодорхойлолт нь мөрддөг болж тогтсон; эсхүл</p> <p>3.2. Монгол Улсын Стандартчилал, хэмжил зүйн эрх бүхий байгууллагаас гаргасан техникийн тодорхойлолт бол; эсхүл,</p> <p>3.3. гадаад улсын техникийн стандартын тодорхойлолт бол.</p> | |
| <p>21.511. Тодорхойлолтоос хазайх хүсэлт гаргах</p> <p>(a) Монгол Улсын TSO, эсхүл хүлээн зөвшөөрсөн тодорхойлолтоос хазайх хүсэлт гаргагч нь дараах мэдээллийг агуулсан САА 24021/11 маягыг бөглөж, зохих төлбөрийн баримтын хамт Даргад хүргүүлнэ:</p> <p>(1) хүсэлт гаргагчийн нэр Монгол Улсад үйлчилгээ эрхлэх хаяг;</p> <p>(2) тухайн тодорхойлолтоос хазайсан бүтээгдэхүүн, бүрдэл хэсэг, эсхүл хэрэгслийг таньж тогтоох;</p> <p>(3) тухайн бүтээгдэхүүн, бүрдэл хэсэг, эсхүл хэрэгсэлд ашиглахад тохиромжтой болох болон тухайн тодорхойлолтоос хазайсан бүтээгдэхүүнийг дэмжихэд шаардлагатай бусад баримт бичиг;</p> <p>(4) тухайн тодорхойлолтоос хазайхыг хүссэн тухайн стандартыг дараах шаардлагыг хангасан зохих хүчин зүйл, эсхүл загварын хэв шинжээр нөхсөн болохыг нотлох баримт;</p> <p>(i) дүйцэх минимум үзүүлэлтийн стандарт;</p> <p>(ii) Даргын хүлээн зөвшөөрөхүйц аюулгүй байдлын түвшин;</p> <p>(5) тухайн маягтад үзүүлсний дагуу Даргын шаардаж болох, хүсэлт гаргагчтай холбоотой нэмэлт мэдээлэл.</p> <p>(b) Хүсэлт гаргагч нь дараах тохиолдолд тодорхойлолтоос</p> | <p>21.511. Тодорхойлолтоос хазайсан өөрчлөлтийн тухай өргөдөл гаргах/Application for deviation from specification</p> <p>(a) Бүтээгдэхүүний техникийн үзүүлэлт нь техникийн стандарт (TSO)-ын үзүүлэлтээс, эсхүл хүлээн зөвшөөрсөн техникийн тодорхойлолтоос хазайсан тохиолдолд өргөдөл гаргагч дор заасан мэдээллийг шаардсан ИНЕГ-021/11 маягыг бөглөж, холбогдох баримт бичгийн хамт ИНЕГ-ын даргад ирүүлнэ:</p> <p>1/ өргөдөл гаргагчийн Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй нэр, хаяг;</p> <p>2/ стандарт үзүүлэлт болон тодорхойлолтоос хазайсан бүтээгдэхүүн, эд анги, нэмэлт тоног төхөөрөмжийн талаарх мэдээлэл;</p> <p>3/ өргөдөлд заасан бүтээгдэхүүн, эд анги, эсхүл нэмэлт тоног төхөөрөмжийн хазайлтыг зохих хэмжээнд хадгалахад шаардлагатай баримт бичиг;</p> <p>4/ стандартаас хазайсан байдлыг зохих хүчин зүйлээр нөхөх эсхүл загварын онцлогийг дараах зүйлээр хангана гэсэн нотолгоо:</p> <p>4.1. адилтгах хэмжээний стандартын минимум техникийн үзүүлэлтээр; болон,</p> <p>4.2. ИНЕГ-ын даргын хүлээн зөвшөөрөхүйц аюулгүй ажиллагааны түвшингээр.</p> <p>5/ ИНЕГ-ын дарга шаардлагатай гэж үзвэл маягтанд тусгагдсан асуулгыг тодорхой болгох үүднээс нэмэлт тодруулгыг өргөдөл гаргагчаас шаардаж болно;</p> <p>6/ Өргөдөл гаргагч нь энэ зүйлийн (a)-д шаардсан өргөдөл болон холбогдох баримт бичгийг ирүүлэхдээ төлбөрийн баримтыг хавсаргасан байна.</p> <p>(б) ИНЕГ-ын дарга дараах шаардлагууд хангагдсан гэж үзвэл</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |

| | | |
|--|--|------------------------------------|
| <p>хазайх зөвшөөрөл авах эрхтэй, хэрэв:</p> <p>(1) хүсэлт гаргагч нь энэ Дүрмийн холбогдох шаардлагыг Даргын хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр хангаж байгаа бол;</p> <p>(2) тухайн тодорхойлолтоос хазайхыг зөвшөөрснөөр нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлахгүй бол;</p> <p>(3) хангаагүй НТЧ-ын шаардлагыг Даргын хүлээн зөвшөөрөхүйц аюулгүй байдлын түвшнийг хангасан хүчин зүйлээр нөхсөн бол.</p> | <p>тодорхойлолтоос хазайсан өөрчлөлтийг баталгаажуулна:</p> <p>1/ энэ дүрмийн холбогдох шаардлагуудыг хангасан;</p> <p>2/ хазайлтыг баталснаар аюулгүй ажиллагаанд харшлахгүй;</p> <p>3/ НТЧ-ын аливаа нэг шаардлагыг хангаагүй боловч тэдгээр нь зохих хүчин зүйлээр нөхөгдөж, ИНЕГ-ын даргын хүлээн зөвшөөрөхүйц аюулгүй ажиллагааны түвшинг хангасан.</p> | |
| <p>О Бүлэг - Монгол Улсын TSO эрх</p> | <p>Л БҮЛЭГ. ТЕХНИКИЙН СТАНДАРТ (TSO)-ЫН ЗӨВШӨӨРӨЛ/ TECHNICAL STANDARD ORDER AUTHORISATIONS</p> | |
| <p>21.601. Хамрах хүрээ Энэ Бүлэг нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно:</p> <p>(1) TSO эрх олгосноор эд зүйлийн загварыг зөвшөөрөх;</p> <p>(2) Монгол Улсын TSO эрх эзэмшигчийн үүрэг хариуцлага.</p> | <p>21.601. Үйлчлэх хүрээ/ Scope (а) Энэ бүлгээр дараах үйл ажиллагаатай холбоотой журмыг тогтооно:</p> <p>1/ техникийн стандарт (TSO)-ын зөвшөөрөл олгох эд зүйлийн загварын баталгаа;</p> <p>2/ техникийн стандарт (TSO)-ын зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг хариуцлага.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |
| <p>21.603. Тодорхойлолт Энэ Дүрэмд: Эд зүйл гэж аливаа материал, эд анги, процесс, эсхүл хэрэгслийг ойлгоно.</p> | <p>21.603. Тодорхойлолт/ Definitions (а) Энэ бүлэгт хэрэглэсэн "эд зүйл" гэж агаарын хөлөгт ашиглагдах эд анги, материал, нэмэлт тоног төхөөрөмж болон технологийн арга ажиллагааг хэлнэ.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |
| <p>21.605. Монгол Улсын TSO эрхийн шаардлага</p> <p>(а) Монгол Улсын TSO эрх нь:</p> <p>(1) эд зүйл нь Монгол Улсын TSO-д нийцсэнийг тогтоож, түүнийг үйлдвэрлэгчид олгосон загварын зөвшөөрөл;</p> <p>(2) эд зүйлд Монгол Улсын TSO үсгэн тэмдэглэгээ хийх эрх.</p> <p>(б) Эд зүйлийн хувьд этгээд Монгол Улсын TSO эрх эзэмшдэг байх ба тухайн эд зүйл нь Монгол Улсын TSO-ын гүйцэтгэлийн стандартыг хангаж байгаагаас бусад тохиолдолд, аливаа этгээд, эд зүйлд Монгол Улсын TSO тэмдэглэгээ хийхгүй.</p> | <p>21.605. Техникийн стандарт (TSO)-ын зөвшөөрөлд тавигдах шаардлага/Requirement for TSO authorisation</p> <p>(а) Техникийн стандартын зөвшөөрөл нь:</p> <p>1/ техникийн стандартын шаардлагад нийцсэн эд зүйл үйлдвэрлэгчид олгосон загварын баталгаа; ба</p> <p>2/ эд зүйлд техникийн стандартын бичилт, тэмдэглэгээг хийх.</p> <p>(б) Эд зүйл нь техникийн стандартын үзүүлэлтийг хангаж байгааг, зөвхөн техникийн стандартын зөвшөөрөл эзэмшсэн этгээд эд зүйлд техникийн стандартын бичилт, тэмдэглэгээг хийж тодорхойлно.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |
| <p>21.607. Хүсэлт гаргах нөхцөл (а) Монгол Улсын TSO эрх авах хүсэлт гаргагч нь:</p> <p>(1) ИНД-148-ын дагуу олгосон үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ эзэмшигч, эсхүл хүсэлт гаргагч байна;</p> <p>(2) тухайн эд зүйлийг үйлдвэрлэх чадамжтай, эсхүл шаардлагатай бүх бэлтгэлийг хийсэн байна.</p> <p>(б) Хэрэв Дарга, тухайн тодорхойлолт нь онцлох НТЧ-ын</p> | <p>21.607 Өргөдөл гаргах эрх/ Eligibility (а) Техникийн стандартын зөвшөөрөл авах өргөдөл гаргагч нь дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>1/ ИНД-148-ын дагуу үйлдвэрлэгч байгууллагын гэрчилгээ эзэмшигч эсхүл өргөдөл гаргагч байх;</p> <p>2/ эд зүйлийг үйлдвэрлэх боломж бололцоотой, зохих шаардлагатай бэлтгэлийг урьдчилан хангасан байх.</p> <p>(б) Үйлдвэрлэх эд зүйлд НТЧ-ын томоохон шаардлагууд багтсан</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |

шаардлагыг агуулсныг тогтоосон бол, Монгол Улсын TSO эрх авах хүсэлт гаргагч энэ зүйлийн (а)-д зааснаас гадна, дараах шаардлагыг нэмж хангана:

- (1) үйлдвэрлэх эд зүйлд тохирох зэрэглэлтэй ИНД-146-гийн дагуу олгосон зохион бүтээх байгууллагын гэрчилгээ эзэмшигч, эсхүл хүсэлт гаргагч байх; эсхүл
- (2) тухайн тодорхойлолтын нийцлийг харуулах зорилгоор үйлдвэрлэх эд зүйлд тохирох зэрэглэлтэй зохион бүтээх байгууллагын гэрчилгээ эзэмшигчтэй, зохицуулалт хийсэн байх; эсхүл
- (3) Даргын хүлээн зөвшөөрөхүйц, дүйцэх журамтай байх.

гэж ИНЕГ-ын дарга тодорхойлсон тохиолдолд, өргөдөл гаргагч энэ зүйлийн (а)-д зааснаас гадна дараах шаардлагыг хангана:

- 1/ тухайн эд зүйлийн зохион бүтээгч байгууллагын гэрчилгээ эзэмшигч эсхүл өргөдөл гаргагч байна;
- 2/ зохион бүтээгч байгууллагын гэрчилгээ эзэмшигч бол тухайн эд зүйлийг тодорхойлолтын шаардлагыг хангаж үйлдвэрлэнэ гэдгээ нотлон харуулах арга хэмжээг авна;
- 3/ ИНЕГ-ын даргын хүлээн зөвшөөрөхүйц адилтгах хэмжээний заавар журамтай байна.

21.609. Эрх авах хүсэлт гаргах

Монгол Улсын TSO эрх авах хүсэлт гаргагч нь дараах мэдээллийг шаардсан САА 24021/12 маягтыг бөглөж, зохих төлбөрийн баримтын хамт Даргад хүргүүлнэ:

- (1) хүсэлт гаргагчийн нэр Монгол Улсад үйлчилгээ эрхлэх хаяг;
- (2) хүсэлт гаргагч нь:
 - (i) Монгол Улсын TSO загвар болон гүйцэтгэлийн шаардлага хангаж чадахыг нотлох баримт;
 - (ii) эд зүйл бүрийг холбогдох тодорхойлолтын техникийн нөхцөлийн дагуу найдвартай хуулбарлан үйлдвэрлэж чадахыг нотлох баримт;
- (3) Монгол Улсын холбогдох TSO-д шаардсан техникийн өгөгдлийн нэг хувь;
- (4) хүсэлт гаргагчийн нийцлийн мэдэгдэл, эсхүл онцлох НТЧ-ын шаардлага багтсаныг Дарга тодорхойлсон эд зүйлийн хувьд, ИНД-146-гийн дагуу олгосон зохион бүтээх байгууллагын гэрчилгээ эзэмшигчийн үйлдвэрлэх эд зүйл нь холбогдох тодорхойлолтын техникийн нөхцөлтэй нийцэж байгааг мэдэгдсэн мэдэгдэл;
- (5) тухайн маягтад үзүүлсний дагуу Даргын шаардаж болох, хүсэлт гаргагчтай холбоотой нэмэлт мэдээлэл.

21.609. Зөвшөөрөл хүсэх өргөдөл / *Application for authorisation*

(а) Техникийн стандарт (TSO)-ын зөвшөөрөл авах өргөдөл гаргагч нь дор заасан мэдээллийг шаардсан ИНЕГ-021/12 маягтыг бөглөж, холбогдох баримт бичгийг төлбөрийн баримтын хамт ИНЕГ-ын даргад ирүүлнэ:

- 1/ өргөдөл гаргагчийн Монгол Улсад үйл ажиллагаа явуулах нэр, хаяг;
- 2/ дараах зүйлийг нотолсон баримт:
 - 2.1. техникийн стандартын үзүүлэлт болон загварын шаардлагуудыг хангасан тухай;
 - 2.2. тодорхойлолтод заасан техникийн нөхцөлийн дагуу эд зүйлийг найдвартай үйлдвэрлэх тухай.
- 3/ техникийн стандартаар шаардсан техникийн үзүүлэлтийн хуулбар;
- 4/ үйлдвэрлэх эд зүйлд НТЧ-ын томоохон шаардлагууд багтсан гэж ИНЕГ-ын дарга тодорхойлсон тохиолдолд, зохион бүтээгч байгууллагын гэрчилгээ эзэмшигч эсхүл өргөдөл гаргагч нь тухайн эд зүйлийг тодорхойлолтод заасан техникийн нөхцөлийн дагуу үйлдвэрлэнэ гэсэн тодорхойлолтыг ирүүлнэ;
- 5/ ИНЕГ-ын дарга шаардлагатай гэж үзвэл маягтанд тусгагдсан асуулгыг тодорхой болгох үүднээс нэмэлт тодруулгыг өргөдөл гаргагчаас шаардаж болно.

-Орчуулга,
найруулга зассан

21.611. Эрх олгох

Хүсэлт гаргагч нь дараах тохиолдолд TSO эрх авах эрхтэй, хэрэв:

- (1) хүсэлт гаргагч энэ Бүлгийн холбогдох шаардлагыг Даргын хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр хангасан бол;
- (2) тухайн гэрчилгээг олгох нь нисэхийн аюулгүй байдлын

21.611. Зөвшөөрөл олгох / *Issue of authorisation*

(а) ИНЕГ-ын дарга нь дараах шаардлагууд хангагдсан гэж үзсэн нөхцөлд Техникийн стандартын зөвшөөрөл олгоно:

- 1/ ИНЕГ-ын даргын хүлээн зөвшөөрсөн аргачлалаар энэ бүлгийн холбогдох шаардлагуудыг хангасан;
- 2/ зөвшөөрөл олгосноор аюулгүй ажиллагаанд харшлахгүй;

Орчуулга, найруулга
зассан

| | | |
|--|---|------------------------------------|
| <p>ашиг сонирхолд харшлахгүй бол; (3) тухайн хүсэлт гаргагч нь ИНД-148-ын дагуу олгодог үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ авсан бол.</p> | <p>3/ ИНД-148-ын дагуу үйлдвэрлэгч байгууллагын гэрчилгээ авсан.</p> | |
| <p>21.613. Зөвшөөрлийн эрх (а) Эд зүйлийн хувьд Монгол Улсын TSO эрх эзэмшигч нь: (1) эд зүйлийг 21.621 болон 21.623 (а), (б)-д нийцүүлэн үйлдвэрлэж болно; (2) эд зүйлд Монгол Улсын TSO тэмдэглэгээ хийж болно</p> | <p>21.613. <i>Зөвшөөрөл эзэмшигчийн эрх/ Privileges of authorisation</i> (а) Техникийн стандарт (TSO)-ын зөвшөөрөл эзэмшигч нь: 1/ энэ дүрмийн 21.621 болон 21.623 (а); (б)-д заасан нөхцөлийг хангаж эд зүйлийг үйлдвэрлэх; ба 2/ эд зүйлд техникийн стандартын бичилт тэмдэглэгээг хийж тодорхойлно.</p> | <p>Орчуулга, найруулга зассан</p> |
| <p>21.615. Эрхийн хүчинтэй байдал Хэрэв <u>Дарга</u> дараах нөхцөлийг тогтоосон бол, Монгол Улсын TSO эрхийг түдгэлзүүлж эсхүл хүчингүй болгож болно: (1) энэ Бүлгийн дагуу эрх олгоход шаардлагатай нөхцөлийг мөрдөхгүй байгаа болохыг; эсхүл (2) тухайн тодорхойлолт нь: (i) цуцлагдсан болохыг; эсхүл (ii) эзэмшиж байгаа тухайн эрхийг цаашид тохирохгүй болтол өөрчилсөн болохыг; эсхүл (3) ИНД-148-ын дагуу олгосон үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээг түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосон болохыг; эсхүл (4) 21.621-д заасан эзэмшигчийн үүрэг хариуцлагыг цаашид хэрэгжүүлэхгүй болохыг; эсхүл (5) ашиглалтын явцад тухайн эд зүйл нь хүлээн зөвшөөрч болохгүй аюул учруулж байгааг харуулсан.</p> | <p>21.615. <i>Зөвшөөрлийг хүчингүй болгох нөхцөл/ Suspend of authorisation</i> (а) <u>ИНЕГ</u>-ын дарга дараах тохиолдолд Техникийн стандартын зөвшөөрлийг түр зогсоох буюу хүчингүй болгож болно: 1/ зөвшөөрөл олгоход шаардсан нөхцөлийг цаашид хангах боломжгүй нь тогтоогдсон; 2/ тодорхойлолтын хувьд: 2.1. хүчингүй болсон; эсхүл, 2.2. зөвшөөрөл нь цаашид шаардлага хангахгүй болсон. 3/ ИНД-148-ын дагуу олгосон, үйлдвэрлэгч байгууллагын гэрчилгээгээ хураалгаж хүчингүй болгосон эсхүл үйлчлэлийг түр зогсоосон; 4/ энэ дүрмийн 21.621-д тодорхойлсон зөвшөөрөл эзэмшигчийн үүргээсчөлөөлөгдсөн; 5/ эд зүйл нь ашиглалтын хугацаанд аюултай болох нь тогтоогдсон.</p> | <p>Орчуулга, найруулга зассан</p> |
| <p>21.617. Эрхийн хугацаа (а) Энэ Бүлгийн дагуу олгосон Монгол Улсын TSO эрх нь түүнийг түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосноос бусад тохиолдолд хүчинтэй хэвээр байна. (б) Монгол Улсын TSO эрхийг хүчингүй болгосон нөхцөлд эзэмшигч нь тухайн гэрчилгээг <u>Даргад</u> нэн даруй хураалгана. (в) Монгол Улсын TSO эрхийг түдгэлзүүлсэн бол, гэрчилгээ эзэмшигч нь зохих баталгаажуулсан тэмдэглэл хийлгэхээр гэрчилгээг <u>Даргад</u> нэн даруй хүргүүлнэ.</p> | <p>21.617. <i>Зөвшөөрлийн хугацаа/ Duration of authorisation</i> (а) Энэ бүлгийн дагуу олгосон техникийн стандартын зөвшөөрөл нь түр зогсоох буюу хүчингүй болгох хүртэл тохиолдолд хүчин төгөлдөр байна. (б) Техникийн стандартын зөвшөөрлийг хүчингүй болгосон нөхцөлд эзэмшигч нь гэрчилгээг <u>ИНЕГ</u>-ын даргад нэн даруй хураалгана. (в) Техникийн стандартын зөвшөөрлийг түр түдгэлзүүлсэн нөхцөлд эзэмшигч холбогдох зөвшөөрөл болон цаашид авах арга хэмжээнд зориулан гэрчилгээг <u>ИНЕГ</u>-ын даргад яаралтай ирүүлнэ.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |
| <p>21.619. Эрх шилжүүлэх Энэ Бүлгийн дагуу олгосон Монгол Улсын TSO эрхийг бусдад шилжүүлж болохгүй.</p> | <p>21.619. <i>Зөвшөөрлийг бусдад шилжүүлэх/ Transfer of authorisation</i> (а) Энэ бүлгийн дагуу олгосон техникийн стандартын зөвшөөрлийг бусдад шилжүүлэхийг хориглоно.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |
| <p>21.621. Эрх эзэмшигчийн үүрэг хариуцлага</p> | <p>21.621. <i>Зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг/ Responsibilities of authorisation holder</i></p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |

| | | |
|---|---|--|
| <p>Эд зүйл үйлдвэрлэгч нь тухайн эд зүйлийн Монгол Улсын TSO эрх эзэмшигч бол:</p> <ol style="list-style-type: none"> (1)эд ангийг ИНД-148-ын дагуу олгосон үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээний дагуу үйлдвэрлэнэ; (2)бэлэн болсон эд зүйл нь түүний загварын өгөгдөлд нийцсэн, суурилуулахад аюулгүй болохыг бататгана; (3)тухайн бүтээгдэхүүний үйл ажиллагаа техник үйлчилгээнд шаардлагатай бүх зааврын эх хувийг боловсруулж, арчилж хадгалах болон шинэчилнэ; (4)эд зүйлийн үйл ажиллагаа техник үйлчилгээнд шаардлагатай техник үйлчилгээ, их засварын болон засварын зааврыг тухайн эд зүйлийг хэрэглэгчид бэлэн байлгана; (5)эд зүйлд дараах мэдээллийг гаргацтай, байнгын арилдаггүй байдлаар тэмдэглэх: <ol style="list-style-type: none"> (i) 21.813-т заасан мэдээлэл; (ii) эд зүйлийн нэр, маяг, эсхүл эд ангийн дугаар; (iii) Монгол Улсын холбогдох TSO дугаар; (6), техник үйлчилгээ, их засвар, засварын заавар болон 21.625-аар шаардсан бусад бүртгэлийг Даргын шаардсан даруйд хүргүүлнэ. | <p>(а) Эд зүйл үйлдвэрлэгч техникийн стандартын зөвшөөрөл эзэмшигч нь:</p> <ol style="list-style-type: none"> 1/ ИНД-148-ын дагуу олгосон үйлдвэрлэгч байгууллагын гэрчилгээний дагуу эд зүйлийг үйлдвэрлэнэ; 2/ бэлэн болсон эд зүйл бүр нь загварын үзүүлэлтэд нийцсэн, суурилуулахад аюулгүй гэдгийг бататгана; 3/ бүтээгдэхүүний ашиглалтын болон техник үйлчилгээний шаардлагатай бүх заавруудын үндсэн эх хувийг бэлтгэх ба шинэчлэж хадгална; 4/ эд зүйлийн ашиглалт ба техник үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай их засварын болон бусад холбогдох засвар үйлчилгээний заавруудыг хэрэглэгч нарт хүргүүлнэ; 5/ эд зүйл бүрд дараах мэдээллийн талаар тогтмол, бичилт тэмдэглэл хийж байрлуулна: <ol style="list-style-type: none"> 5.1 21.813-т тодорхойлсон мэдээлэл; 5.2 эд зүйлийн нэр, маяг, дугаар; 5.3 техникийн стандарт (TSO)-гийн дугаар. 6/ ИНЕГ-ын дарга шаардлагатай гэж үзсэн тохиолдолд, техник үйлчилгээний заавар, их засвар, засварын зааврууд болон энэ дүрмийн 21.625-аар шаардсан бусад бүртгэл тэмдэглэлийг ИНЕГ-ын даргад ирүүлнэ. | |
| <p>21.623. Загварын өөрчлөлт</p> <p>(а)Аливаа этгээд нь дараахаас бусад тохиолдолд, энэ Бүлгийн дагуу эд зүйлд загварын өөрчлөлт хийхгүй:</p> <ol style="list-style-type: none"> (1)тухайн этгээд нь Монгол Улсын зохих TSO эрх эзэмшигч байх ; эсхүл (2)тухайн этгээд Монгол Улсын TSO эрх авах хүсэлтийг тусад нь гаргасан байх. <p>(b)Монгол Улсын TSO эрх эзэмшигч нь дараах шаардлагыг хангасан тохиолдолд томоохон загварын өөрчлөлтөөс бусад загварын өөрчлөлтийг Даргын нэмэлт зөвшөөрөлгүйгээр өөрийн үйлдвэрлэж байгаа эд зүйлд хийж болно:</p> <ol style="list-style-type: none"> (1)тухайн эд зүйлийн үндсэн загварын дугаарыг хадгалж байх; (2)загварын өөрчлөлтийг загварын дугаарын дагавар, эсхүл эд ангийн дугаарын өөрчлөлтөөр нь таньж тогтоодог байх; (3)тухайн загварын өөрчлөлтийг таних болон Монгол Улсын TSO-ийн байнгын хэрэгжилтийг харуулахад шаардлагатай өөрчлөгдсөн өгөгдлийг Даргад хүргүүлсэн байх. <p>(c)Өөрийн үйлдвэрлэж байгаа эд зүйлд томоохон загварын</p> | <p>21.623. Загварын өөрчлөлт/ Design changes</p> <p>(а) Энэ бүлгийн дагуу техникийн стандартын зөвшөөрөл эзэмшигч эд зүйлийн загварт өөрчлөлт хийх эрхтэй.</p> <p>(б) Зөвшөөрөл эзэмшигч нь үйлдвэрлэлийн шаардлагаар загварт томоохон өөрчлөлт хийхээс бусад тохиолдолд дараах нөхцөлүүдийг хангаж ИНЕГ-ын даргаас нэмэлт зөвшөөрөл авахгүйгээр эд зүйлийн загварт өөрчлөлт хийж болно:</p> <ol style="list-style-type: none"> 1/ эд зүйлийн үндсэн загварыг дугаарыг хадгалах; 2/ загварын өөрчлөлтийг тухайн загварын дугаарын дагавар бичилт болон эд ангийн дугаарын өөрчлөлтөөр тогтоох; 3/ техникийн стандартын шаардлагыг цаашид хангаж буйг үзүүлсэн, загварын өөрчлөлтийг тодорхойлоход шаардлагатай аливаа үзүүлэлтийн өөрчлөлтийг ИНЕГ-ын даргад хүргүүлэх. <p>(в) Техникийн стандарт (TSO)-гийн зөвшөөрөл эзэмшигч нь эд</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Орхигдуулсан заалтыг нөхөж оруулсан</p> |

| | | |
|--|---|---|
| <p>өөрчлөлт хийхээр төлөвлөж байгаа Монгол Улсын TSO эрх эзэмшигч нь:</p> <p>(1) тухайн эд зүйлд шинэ маяг, эсхүл оноосон загвар өгнө; (2) Монгол Улсын шинэ TSO эрх авах хүсэлт гаргана.</p> | <p>зүйлийн загварт томоохон өөрчлөлт хийж үйлдвэрлэх тохиолдолд дараах шаардлагыг хангана:</p> <p>1/ эд зүйлийн шинэ маяг болон загварыг тодорхойлсон байх; 2/ шинэ техникийн стандарт (TSO)-гийн зөвшөөрөл авах хүсэлтийг гаргасан байх.</p> | |
| <p>21.625. Бүртгэл хөтлөх</p> <p>(a) Монгол Улсын TSO эрх эзэмшигч нь дараах журмыг тогтоосон байна:</p> <p>(1) дараах мэдээллийг таньж тогтоох, цуглуулах, индексжүүлэх, хадгалах, арчлах болон устгах:</p> <p>(i) Монгол Улсын TSO эрхийн хүрээнд, эзэмшигчийн үйлдвэрлэсэн эд зүйл бүрийн загварын бүртгэл;</p> <p>(ii) тухайн эд зүйл нь Монгол Улсын TSO болон энэ Дүрэмд нийцэж байгааг харуулах бүх холбогдох загварын мэдээлэл, зураг, тодорхойлолт, туршилт, дүн шинжилгээ болон тайлан;</p> <p>(2) дараах шаардлагыг хангасан болохыг бататгах:</p> <p>(i) бүх бүртгэл нь гаргацтай байнгын арилдаггүй байх;</p> <p>(ii) энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, энэ зүйлийн (1)-д шаардсан бүртгэлийг тухайн эд зүйлийн сүүлчийн загварыг ашиглалтаас бүрмөсөн хассанаас хойш 2 жилийн хугацаанд хадгалдаг байх.</p> <p>(b) Дарга бүртгэлийг энэ зүйлийн (a)(2)(ii)-т шаардсанаас бага хугацаагаар хадгалахыг зөвшөөрч болно.</p> | <p>21.625. <u>Бүртгэл тэмдэглэл</u>/ Records</p> <p>(a) Техникийн стандартын зөвшөөрөл эзэмшигч нь дараах журмыг тогтоосон байна:</p> <p>1/ дор заасан зүйлийн бүртгэл тэмдэглэлийг хөтлөх, цуглуулах, индексжүүлэх, ялгах, өөрчлөлт шинэчлэлт оруулах болон хадгалах журам:</p> <p>1.1. Техникийн стандартын зөвшөөрлийн дагуу үйлдвэрлэж буй эд зүйлийн загвар бүрийн;</p> <p>1.2. тухайн эд зүйл нь энэ дүрэм болон техникийн стандартын шаардлагыг хангаж буйг үзүүлсэн тодорхойлолт, зураг схем, үзлэг шалгалтын тайлан, дүгнэлт бусад загвартай холбоотой бүх мэдээллийн.</p> <p>2/ дараах зүйлийг бататгах:</p> <p>2.1. бүх бүртгэл нь тодорхой, гаргацтай, тогтсон загварт байгаа эсэх;</p> <p>2.2. энэ зүйлийн (a)-гаар шаардсан бүртгэл тэмдэглэлийг тухайн эд зүйл нь ашиглалтаас гарсан сүүлчийн өдрөөс хойш 2 жилийн хугацаанд хадгалж байгаа эсэх.</p> <p>(б) ИНЕГ-ын дарга энэ зүйлийн (a) 2/ 2.2-т заасан бүртгэл тэмдэглэлийн хадгалах хугацааг багаар тогтоож болно.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |
| <p>Р Бүлэг-Монгол Улсын PMA эрх</p> | <p>М БҮЛЭГ. ЭД АНГИ ҮЙЛДВЭРЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ</p> | |
| <p>21.701. Хамрах хүрээ</p> <p>Энэ Бүлэг нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно:</p> <p>(1) Монгол Улсын PMA эрх олгох замаар солилтын, эсхүл модификацийн эд ангийн загварыг зөвшөөрөх;</p> <p>(2) Монгол Улсын PMA эрх эзэмшигчийн үүрэг хариуцлага.</p> | <p>21.701. Үйлчлэх хүрээ/ Applicability</p> <p>(a) Энэ бүлгээр дараах үйл ажиллагаатай холбоотой журмыг тогтооно:</p> <p>1/ эд анги үйлдвэрлэх зөвшөөрөл олгосноор эд ангийг солих эсхүл өөрчлөх загварын баталгаа;</p> <p>2/ эд анги үйлдвэрлэх зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг хариуцлага.</p> | <p>-“эд анги үйлдвэрлэх зөвшөөрөл” гэснийг “Монгол Улсын PMA эрх” гэж өөрчилсөн</p> |
| <p>21.703. Монгол Улсын PMA эрхийн шаардлага</p> <p>(a) Монгол Улсын PMA эрх нь:</p> <p>(1) Дарга солилтын, эсхүл модификацийн эд анги нь хамааралтай НТЧ-ын шаардлагатай нийцэж байгааг тогтоож, үйлдвэрлэгчид олгосон загварын зөвшөөрөл;</p> <p>(2) эд ангид Монгол Улсын PMA үсгэн тэмдэглэгээ хийх</p> | <p>21.703. Эд анги үйлдвэрлэх зөвшөөрөлд тавигдах шаардлага/ Requirement for parts manufacturing approval authorisation</p> <p>(a) Эд анги үйлдвэрлэх зөвшөөрөл нь:</p> <p>1/ ИНЕГ-ын даргын тодорхойлсон НТЧ-ын холбогдох шаардлагуудыг хангаж байгаа солих эсхүл өөрчлөх эд ангийг үйлдвэрлэгчид олгосон загварын баталгаа;</p> <p>2/ эд ангид үйлдвэрлэлийн бичилт, тэмдэглэгээг хийх.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |

| | | |
|--|---|--|
| <p>эрх.</p> <p>(b) Эд ангийн хувьд, тухайн этгээд нь Монгол Улсын РМА эрх эзэмшдэг байх ба эд анги нь хамааралтай НТЧ-ын шаардлага хангаж байгаагаас бусад тохиолдолд аливаа этгээд эд ангид Монгол Улсын РМА-ын тэмдэглэгээ хийхгүй.</p> | <p>(б) Эд анги нь НТЧ-ын зохих шаардлагуудыг хангаж байгааг зөвхөн эд ангийг үйлдвэрлэх зөвшөөрөл эзэмшсэн этгээд эд ангид үйлдвэрлэлийн бичилт, тэмдэглэгээг хийж тодорхойлно.</p> | |
| <p>21.705. Хүсэлт гаргах нөхцөл <u>Монгол Улсын РМА эрх авах хүсэлт гаргагч нь:</u> <u>(1)ИНД-148-ын дагуу олгосон үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ эзэмшигч байх ба өөрийн байгууллагын Ерөнхий зааварт тухайн эд ангийг үйлдвэрлэхээр өөрчлөлт оруулах хүсэлт гаргасан байна; эсхүл</u> <u>(2)тухайн эд ангийг үйлдвэрлэхийн тулд ИНД-148-ын дагуу үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргасан байна.</u></p> | <p>21.705 Нөөц/ Reserved</p> | <p>-Орхигдсон зүйлийг нөхөж оруулсан</p> |
| <p>21.707. Эрх авах хүсэлт гаргах (а)Монгол Улсын РМА эрх эзэмших хүсэлт гаргагч нь дараах мэдээллийг шаардсан САА 24021/13 маягтыг бөглөж, зохих төлбөрийн баримтын хамт Даргад хүргүүлнэ:</p> <p>(1) хүсэлт гаргагчийн нэр Монгол Улсад үйлчилгээ эрхлэх хаяг;</p> <p>(2) эд ангийг суурилуулах бүтээгдэхүүнийг таньж тогтоох;</p> <p>(3) дараах баримт бичгээс бүрдсэн загварын мэдээлэл:</p> <p>(i) эд ангийн <u>загварын хэв шинж конфигурацийг</u> тодорхойлоход шаардлагатай тодорхойлолт болон зураг;</p> <p>(ii) эд ангийн загварын хэв шинж конфигураци нь хамааралтай НТЧ-ын шаардлага хангаж байгааг нотлох баримт;</p> <p>(iii) энэ зүйлийн (а)(3)(i)-д заасан зураг болон тодорхойлолтын жагсаалт;</p> <p>(iv) эд ангийн бүтцийн бөх бат байдлыг тодорхойлоход шаардлагатай хэмжээс, материал болон процессын мэдээлэл;</p> <p>(4)хүсэлт гаргагч нь энэ зүйлийн (а)(3)-т иш татсан загварын дагуу эд анги бүрийг найдвартай хуулбарлан үйлдвэрлэж чадахыг нотлох баримт;</p> <p>(5)хүсэлт гаргагчийн нийцлийн мэдэгдэл, эсхүл онцлох НТЧ-ын шаардлага багтсан гэж <u>Даргын</u> тодорхойлсон эд зүйлийн хувьд, ИНД-146-гийн дагуу олгосон зохион бүтээх байгууллагын гэрчилгээ эзэмшигчийн дараах мэдээлэл:</p> <p>(i) энэ зүйлийн (а)(3)-т иш татсан эд ангийн загвар</p> | <p>21.707 Зөвшөөрөл хүсэх өргөдөл/ Application for authorisation (а) Эд ангийг үйлдвэрлэх зөвшөөрөл авах өргөдөл гаргагч нь дор заасан мэдээллийг шаардсан ИНЕГ-021/13 маягтыг бөглөж, холбогдох баримт бичгийг төлбөрийн баримтын хамт <u>ИНЕГ</u>-ын даргад ирүүлнэ:</p> <p>1/ өргөдөл гаргагчийн Монгол Улсад үйл ажиллагаа явуулах нэр, хаяг;</p> <p>2/ эд ангийг суурилуулах бүтээгдэхүүний тодорхойлолт;</p> <p>3/ загварын талаарх дараах зүйлээс бүрдсэн баримт бичиг:</p> <p>3.1. эд ангийн <u>загварын үзүүлэлт</u> болон <u>хийцийг</u> тодорхойлоход шаардлагатай техникийн тодорхойлолт, зураг схем;</p> <p>3.2. эд ангийн загварын үзүүлэлт болон хийц нь НТЧ-ын холбогдох шаардлагуудыг хангасан тухай;</p> <p>3.3. энэ зүйлийн (а) 3/ 3.1-д заасан зураг схем болон техникийн тодорхойлолтын жагсаалт;</p> <p>3.4. эд ангийн бүтцийн бөх бат байдлыг тодорхойлоход шаардлагатай технологийн аргачлал, материал болон хэмжээсийн талаарх мэдээлэл.</p> <p>4/ энэ хэсгийн (а) 3/-т тусгагдсан загварын дагуу эд анги бүрийг найдвартай үйлдвэрлэж чадахаа илэрхийлсэн өргөдөл гаргагчийн нотолгоо;</p> <p>5/ үйлдвэрлэх эд зүйлд НТЧ-ын томоохон шаардлагууд багтсан гэж <u>ИНЕГ</u>-ын дарга тодорхойлсон тохиолдолд, зохион бүтээгч байгууллагын гэрчилгээ эзэмшигчийн, эсхүл өргөдөл гаргагчийн шаардлага хангасан тухай тодорхойлолтод дараах зүйлийг тусгасан байна:</p> <p>5.1. энэ хэсгийн (а) 3/-т тусгагдсан эд ангийн загвар нь тус</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |

| | | |
|--|---|--|
| <p>нь солих эд ангийн загвартай ижил, эсхүл энэ зүйлийн (а)(2)-т иш татсан бүтээгдэхүүнд тавих НТЧ-ын загварын стандартыг хангасан;</p> <p>(ii) эд анги нь хамааралтай НТЧ-ын стандартын техникийн нөхцөлийг хангасныг харуулахад шаардлагатай үзлэг шалгалт, туршилт тооцоог бүрэн хийж баримтжуулсан;</p> <p>(б) тухайн маягтад үзүүлсний дагуу <u>Даргын</u> шаардаж болох, хүсэлт гаргагчтай холбоотой нэмэлт мэдээлэл.</p> <p>(б) Хүсэлт гаргагч нь, эд анги болон холбогдох өгөгдлийг <u>Даргын</u> шаардаж болох үзлэг шалгалтад бэлэн байлгана.</p> | <p>хэсгийн 2/-д заасан бүтээгдэхүүнд хамаарах загварын НТЧ-ын стандартыг хангасан эсхүл түүнтэй ижил загварын эд ангиар солигдох талаар;</p> <p>5.2. тухайн эд анги нь НТЧ-ын стандартын зохих техникийн нөхцөлийг хангаж буйг харуулсан, үзлэг шалгалтын болон тооцоо, судалгааны дүгнэлтийг бүрэн хийж тэдгээрийг баримтжуулсан талаар.</p> <p>6/ <u>ИНЕГ</u>-ын дарга нь шаардлагатай гэж үзвэл маягтанд тусгагдсан асуулгыг тодорхой болгох үүднээс нэмэлт тодруулгыг өргөдөл гаргагчаас шаардаж болно.</p> <p>(б) <u>ИНЕГ</u>-ын дарга үзлэг, шалгалт хийх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өргөдөл гаргагч нь эд анги болон түүнтэй холбоотой техникийн үзүүлэлтийн мэдээллийг бэлэн байлгана.</p> | |
| <p>21.709. Эрх олгох</p> <p>Хүсэлт гаргагч нь дараах тохиолдолд Монгол Улсын РМА эрх авах эрхтэй, хэрэв:</p> <p>(1) энэ Бүлгийн холбогдох шаардлагыг <u>Даргын</u> хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр хангасан бол;</p> <p>(2) тухайн гэрчилгээг олгох нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлахгүй бол;</p> <p><u>(3) тухайн хүсэлт гаргагч нь ИНД-148-ын дагуу олгодог үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ авсан бол.</u></p> | <p>21.709. Зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага/ Issue of authorisation</p> <p>(а) <u>ИНЕГ</u>-ын дарга дараах шаардлагууд хангагдсан гэж үзсэн нөхцөлд эд анги үйлдвэрлэх зөвшөөрлийг олгоно:</p> <p>1/ <u>ИНЕГ</u>-ын даргын хүлээн зөвшөөрсөн аргачлалаар энэ бүлгийн холбогдох шаардлагуудыг хангасан;</p> <p>2/ зөвшөөрөл олгосноор нисэхийн аюулгүй байдалнд харшлахгүй байх нөхцөлийг хангасан.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-ИНД-148-ын зохицуулалтыг орхигдуулсан</p> |
| <p>21.711. Зөвшөөрлийн эрх</p> <p><u>Монгол Улсын РМА эрх эзэмшигч</u> нь:</p> <p>(1) эд ангийг 21.719-д нийцүүлэн үйлдвэрлэж болно;</p> <p>(2) эд ангид Монгол Улсын РМА тэмдэглэгээ хийж болно.</p> | <p>21.711. Зөвшөөрөл эзэмшигчийн эрх/ Privileges of authorisation</p> <p>(а) <u>Эд анги үйлдвэрлэх зөвшөөрөл</u> эзэмшигч нь дор заасны дагуу үйлдвэрлэлийн үйл ажиллагааг явуулах эрхтэй:</p> <p>1/ 21.719-д заасан нөхцөлийг хангаж эд анги үйлдвэрлэх;</p> <p>2/ эд ангид үйлдвэрлэлийн зөвшөөрлийн бичилт тэмдэглэгээг хийх.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |
| <p>21.713. Эрхийн хүчинтэй байдал</p> <p><u>Хэрэв Дарга дараах нөхцөлийг тогтоосон бол</u> Монгол Улсын РМА эрхийг түдгэлзүүлж, эсхүл хүчингүй болгож болно:</p> <p>(1) энэ Бүлгийн дагуу эрх олгоход шаардлагатай нөхцөлийг мөрдөхгүй байгаа болохыг; эсхүл</p> <p><u>(2) ИНД-148-ын дагуу олгосон үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээг түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосныг; эсхүл</u></p> <p>(3) 21.719-д заасан эзэмшигчийн үүрэг хариуцлагыг цаашид хэрэгжүүлэхгүй болохыг; эсхүл</p> <p>(4) ашиглалтын явцад тухайн эд зүйл нь хүлээн зөвшөөрч болохгүй аюул учруулж байгааг харуулсан</p> | <p>21.713. Зөвшөөрлийг хүчингүй болгох нөхцөл/ Suspend of authorisation</p> <p>(а) <u>ИНЕГ</u>-ын дарга дараах тохиолдолд эд анги үйлдвэрлэх зөвшөөрлийг түр зогсоох буюу хүчингүй болгож болно:</p> <p>1/ зөвшөөрөл олгоход шаардсан нөхцөлийг цаашид хангах боломжгүй нь тогтоосон;</p> <p>2/ 21.719-д заасан зөвшөөрөл эзэмшигчийн үүргээс чөлөөлөгдсөн;</p> <p>3/ эд зүйл нь ашиглалтын хугацаанд аюултай нөхцөл байдлыг үзүүлсэн.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-ИНД-148-ын зохицуулалтыг орхигдуулсан</p> |

| | | |
|---|---|--|
| <p>болохыг.</p> <p>21.715. Эрхийн хугацаа</p> <p>(a) Энэ Бүлгийн дагуу олгосон Монгол Улсын PMA эрх нь түүнийг түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох хүртэл хүчинтэй байна.</p> <p>(b) Монгол Улсын PMA эрхийг хүчингүй болгосон нөхцөлд эзэмшигч нь гэрчилгээг <u>Даргад</u> нэн даруй хураалгана.</p> <p>(c) Монгол Улсын PMA эрхийг түдгэлзүүлсэн бол, гэрчилгээ эзэмшигч нь зохих баталгаажуулсан тэмдэглэл хийлгэхээр тухайн гэрчилгээг Даргад нэн даруй хүргүүлнэ.</p> | <p>21.715. Зөвшөөрлийн хугацаа/ Duration of authorisation</p> <p>(a) Энэ бүлгийн дагуу олгосон эд анги үйлдвэрлэх зөвшөөрөл нь түр зогсоох буюу хүчингүй болгох хүртэл тохиолдолд хүчин төгөлдөр байна.</p> <p>(б) Эд анги үйлдвэрлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон нөхцөлд эзэмшигч нь гэрчилгээг <u>ИНЕГ</u>-ын даргад нэн даруй хураалгана.</p> <p>(в) Эд анги үйлдвэрлэх зөвшөөрлийг түр түдгэлзүүлсэн нөхцөлд эзэмшигч холбогдох зөвшөөрөл болон цаашид авах арга хэмжээнд зориулан гэрчилгээг <u>ИНЕГ</u>-ын даргад яаралтай ирүүлнэ.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |
| <p>21.717. Эрх шилжүүлэх</p> <p>Энэ Бүлгийн дагуу олгосон Монгол Улсын PMA эрхийг бусдад шилжүүлж болохгүй.</p> | <p>21.717. Зөвшөөрлийг бусдад шилжүүлэх/ Transfer of authorisation</p> <p>(a) Энэ бүлгийн дагуу олгосон эд анги үйлдвэрлэх зөвшөөрлийг бусдад шилжүүлэхийг хориглоно.</p> | |
| <p>21.719. Эрх эзэмшигчийн үүрэг хариуцлага</p> <p>Монгол Улсын PMA эрх эзэмшигч нь:</p> <p>(1) эд ангийг <u>ИНД-148-ын дагуу олгосон үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээний дагуу үйлдвэрлэнэ;</u></p> <p>(2) бэлэн болсон эд анги нь загварын өгөгдөлд нийцсэн суурилуулахад аюулгүй болохыг бататгана;</p> <p>(3) эд ангид дараах мэдээллийг гаргацтай, байнгын арилдаггүй байдлаар тэмдэглэнэ:</p> <p>(i) 21.813-т заасан мэдээлэл;</p> <p>(ii) эд зүйлийн нэр, маяг, эсхүл эд ангийн дугаар;</p> <p>(iii) Монгол Улсын PMA дугаар;</p> <p>(4) 21.721-д шаардсан бүртгэлийг Даргын шаардсан даруйд хүргүүлнэ.</p> | <p>21.719. Зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг/ Responsibilities of authorisation holder</p> <p>(a) Эд анги үйлдвэрлэх зөвшөөрөл эзэмшигч нь:</p> <p>1/ бэлэн болсон эд анги бүр нь загварын үзүүлэлтэд нийцсэн, суурилуулахад аюулгүй гэдгийг бататгана;</p> <p>2/ эд анги бүрд дараах мэдээллийн талаар тогтмол, бичилт тэмдэглэл хийж байрлуулна:</p> <p>2.1. 21.803-т тодорхойлсон мэдээлэл;</p> <p>2.2. эд ангийн нэр, маяг, дугаар,</p> <p>2.3. үйлдвэрлэлийн баталгаат зөвшөөрлийн дугаар.</p> <p>3/ <u>ИНЕГ</u>-ын дарга шаардлагатай гэж үзсэн тохиолдолд 21.721-д заасан бүртгэл тэмдэглэлийг <u>ИНЕГ</u>-ын даргад ирүүлнэ.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-ИНД-148-ын зохицуулалтыг орхигдуулсан</p> |
| <p>21.721. Бүртгэл хөтлөх</p> <p>(a) <u>Монгол Улсын PMA эрх</u> эзэмшигч нь дараах журмыг тогтоосон байна:</p> <p>(1) дараах мэдээллийг таньж тогтоох, цуглуулах, индексжүүлэх, хадгалах, арчлах болон устгах:</p> <p>(i) <u>Монгол Улсын PMA эрх</u>ийн хүрээнд эзэмшигчийн үйлдвэрлэсэн эд анги бүрийн бүртгэл;</p> <p>(ii) тухайн эд анги нь холбогдох Монгол Улсын PMA болон энэ Дүрэмд нийцэж байгааг харуулах холбогдох бүх загварын мэдээлэл, зураг, тодорхойлолт, туршилт, дүн шинжилгээ болон тайлан;</p> <p>(2) дараах шаардлагыг хангасан болохыг бататгах:</p> <p>(i) бүх бүртгэл нь гаргацтай байнгын арилдаггүй байх;</p> | <p>21.721. Бүртгэл тэмдэглэл/ Records</p> <p>(a) <u>Эд анги үйлдвэрлэх зөвшөөрөл эзэмшигч</u> нь дараах журмыг тогтоосон байна:</p> <p>1/ дор заасан зүйлийн бүртгэл тэмдэглэлийг хөтлөх, цуглуулах, индексжүүлэх, ялгах, өөрчлөлт шинэчлэлт оруулах болон хадгалах журам</p> <p>1.1. <u>эд анги үйлдвэрлэх зөвшөөрлийн</u> дагуу үйлдвэрлэж буй эд анги бүрийн;</p> <p>1.2. энэ дүрэм болон үйлдвэрлэх зөвшөөрөлд тавигдах шаардлагыг тухайн эд анги нь хангаж буйг харуулсан техникийн үзүүлэлт, зураг схем, үзлэг шалгалт хийгдсэн тайлан, дүгнэлт болон загвартай холбоотой бүх мэдээллийг; болон</p> <p>2/ дараах зүйлийг бататгах:</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |

| | | |
|--|--|------------------------------------|
| <p>(ii) энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, энэ хэсгийн (1)-д шаардсан бүртгэлийг тухайн эд зүйлийн сүүлчийн загварыг ашиглалтаас бүрмөсөн хассанаас хойш 2 жилийн хугацаанд хадгалдаг байх.</p> <p>(b) Дарга бүртгэлийг энэ зүйлийн (a)(2)(ii)-т шаардсанаас бага хугацаагаар хадгалахыг зөвшөөрч болно.</p> | <p>2.1. бүх бүртгэл нь тодорхой, гаргацтай, тогтсон загварт байгаа эсэх;</p> <p>2.2. энэ хэсгийн (a)-аар шаардсан бүртгэлийг тухайн эд анги нь ашиглалтаас гарсан өдрөөс хойш 2 жилийн хугацаатай хадгалж буйг.</p> <p>(б) ИНЕГ-ын дарга энэ зүйлийн (a) 2/ 2.2-т заасан бүртгэл тэмдэглэлийн хадгалах хугацааг багаар тогтоож болно.</p> | |
| <p>Q Бүлэг — Бүтээгдэхүүн болон эд ангийг таньж тогтоох</p> | <p>Н БҮЛЭГ. БҮТЭЭГДЭХҮҮН, ЭД АНГИЙН ТАНИХ ТЭМДЭГ/ IDENTIFICATION OF PRODUCTS AND PARTS</p> | |
| <p>21.801. Зорилго Энэ Бүлэг нь дараах агаарын хөлөг,эд ангийг таньж тогтоох зохицуулалтын шаардлагыг тогтооно:</p> <p>(1) агаарын хөлөг, агаарын хөлгийн хөдөлгүүр болон сэнс;</p> <p>(2) эрсдэлтэй эд анги;</p> <p>(3) тодорхой солилтын болон модификацийн эд анги.</p> | <p>21.801. Үйлчлэх хүрээ/ Scope (a) Энэ бүлгээр дараах зүйлүүдэд таних тэмдэг тавих үйл ажиллагааны журмыг тогтооно:</p> <p>1/ агаарын хөлөг, түүний хөдөлгүүр болон сэнсэнд;</p> <p>2/ онцгой эд ангид;</p> <p>3/ солилт, өөрчлөлт хийгдсэн эд ангид.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |
| <p>21.803. Агаарын хөлөг хөдөлгүүр болон сэнсийг таньж тогтоох (a) ИНД-148-ын дагуу агаарын хөлөг, эсхүл агаарын хөлгийн хөдөлгүүр үйлдвэрлэж байгаа этгээд нь тухайн агаарын хөлөг, эсхүл хөдөлгүүрт дараах шаардлагыг хангасан тэмдэглэгээг галд тэсвэртэй өгөгдлийн пайз хэлбэрээр хийнэ:</p> <p>(1)21.805-д заасан таньж тогтоох мэдээллийг химийн аргаар идүүлэх, тамгалах, сийлэх, эсхүл бусад галд тэсвэртэй тэмдэглэгээний аргаар тэмдэглэсэн байх;</p> <p>(2)дараах байдал үүсэхгүй байх хэлбэрээр бэхэлсэн байх:</p> <p>(i) хэвийн ашиглалтын явцад балрах, эсхүл ховхрох; эсхүл</p> <p>(ii) ослын үед алдагдах, эсхүл устах;</p> <p>(3)хүнтэй чөлөөт бөмбөлгөөс бусад агаарын хөлгийн хувьд, газарт байгаа этгээдэд уншигдахуйцаар, их биеийн дараах хэсэгт бэхэлсэн байх:</p> <p>(i) орох хаалганы ойролцоо хүрэх боломжтой байрлалд; эсхүл</p> <p>(ii) их биеийн гадна, бусад хэсэгт;</p> <p>(4)агаарын хөлгийн хөдөлгүүрийн хувьд, хөдөлгүүрт хүрэх боломжтой байрлалд бэхэлсэн байх;</p> <p>(5)хүнтэй чөлөөт бөмбөлгийн хувьд:</p> <p>(i) бөмбөлгийн бүрхүүл дээр бэхэлсэн байх;</p> | <p>21.803. Агаарын хөлөг, түүний хөдөлгүүр болон сэнсийг таних тэмдэг/Identification of aircraft, aircraft engines, and propellers (a) ИНД 148-ийн дагуу агаарын хөлөг эсхүл хөдөлгүүр үйлдвэрлэж буй аливаа этгээд нь галд тэсвэртэй материал дээр дор заасны дагуу бичилтийг хийж агаарын хөлөг болон хөдөлгүүрт таних тэмдгийн пайзыг байрлуулна:</p> <p>1/ сийлж дүрслэх, цохиж шигтгэх, хэвэнд цутгаж суулгах эсхүл бусад галд тэсвэртэй тэмдэглэлтийн аргаар энэ дүрмийн 21.805-д тодорхойлсон таних тэмдгийн мэдээллийг тэмдэглэх; ба</p> <p>2/ дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>2.1. ашиглалтын үед бичилт тэмдэглэл нь арилах эсхүл ховхорч унахааргүй байх;</p> <p>2.2. агаарын хөлөг осолдсон тохиолдолд алга болох эсхүл устаж үгүй болохооргүй байх.</p> <p>3/ агаарын бөмбөлгөөс бусад агаарын хөлгийн хувьд газарт байгаа хүмүүс уншиж болохуйц их биений гадна хэсгийн дор заасан газарт байрлуулна</p> <p>3.1. орох хаалганы ойролцоо; эсхүл,</p> <p>3.2. агаарын хөлгийн их биений бусад хэсгийн гадна талд.</p> <p>4/ агаарын хөлгийн хөдөлгүүрийн хувьд хялбар хүрч болохуйц газар байрлуулна;</p> <p>5/ агаарын бөмбөлөгт:</p> <p>5.1. тусгай зориулалтын даавуун материалаар хийгдсэн</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |

| | | |
|---|---|------------------------------------|
| <p>(ii) бөмбөлгийг хийлсэн үед үйл ажиллагаа эрхлэгчид харагдахуйц газарт байрлуулсан байх.</p> <p>(b) Хүнтэй чөлөөт бөмбөлөг үйлдвэрлэж байгаа этгээд нь энэ зүйлийн (а)-д зааснаас гадна дараах мэдээллийг бөмбөлгийн дүүжинт сагс болон халаагч иж бүрдэл дээр гаргацтай, байнгын арилдаггүй байдлаар тэмдэглэнэ:</p> <p>(1) үйлдвэрлэгчийн нэр;</p> <p>(2) эд ангийн дугаар, эсхүл дүйцэх мэдээлэл;</p> <p>(3) серийн дугаар, эсхүл дүйцэх мэдээлэл.</p> <p>(c) ИНД-148-ын дагуу сэнс, сэнсний алга, эсхүл сэнсний бул үйлдвэрлэж байгаа этгээд нь дараах шаардлагыг хангасан мэдээллийг галд тэсвэртэй өгөгдлийн пайз, эсхүл химийн аргаар идүүлэх, тамгалах, сийлэх, эсхүл бусад галд тэсвэртэй тэмдэглэгээний хэлбэрээр тэмдэглэнэ:</p> <p>(1) 21.805-д заасан таньж тогтоох мэдээллийг агуулсан байх;</p> <p>(2) эрсдэлгүй гадаргуу дээр байрлуулсан байх;</p> <p>(3) дараах байдал үүсэхээргүй байх:</p> <p>(i) хэвийн ашиглалтын явцад балрах, эсхүл ховхрох; эсхүл</p> <p>(ii) ослын үед гээгдэх, эсхүл устах.</p> | <p>бөмбөрцөг дээр байрлуулах; ба</p> <p>5.2. агаарын бөмбөлөгийг хийлэх үед ашиглагч этгээдэд харагдахуйц газарт байрлуулна.</p> <p>(б) Агаарын бөмбөлөг үйлдвэрлэгч этгээд нь энэ зүйлийн (а)-д зааснаас гадна бөмбөлөгийн дүүжинт сагс болон хийн шаталтын төхөөрөмжид дор заасан мэдээллийг тод гаргацтай бичиж байрлуулна:</p> <p>1/ үйлдвэрлэгчийн нэр;</p> <p>2/ эд ангийн дугаар;</p> <p>3/ үйлдвэрлэлийн серийн дугаар.</p> <p>(в) ИНД-148-ын дагуу сэнс, сэнсний алга, эсхүл сэнсний голыг үйлдвэрлэж буй этгээд нь дор заасан мэдээллийг сийлж дүрслэх, цохиж шигтгэх, хэвэнд цутгаж суулгах эсхүл галд тэсвэртэй таних пайз дээр бичиж тэмдэглэх аргаар байрлуулна:</p> <p>1/ 21.805-д заасан, таних тэмдгийн мэдээллийг тусгасан байх;</p> <p>2/ аюултай бус гадаргуун дээр байрлуулах; ба</p> <p>3/ дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>3.1. ашиглалтын үед бичилт тэмдэглэл нь арилах, эсхүл ховхорч унахааргүй байх;</p> <p>3.2. агаарын хөлөг осолдсон тохиолдолд алга болох, эсхүл устаж үгүй болохооргүй байх.</p> | <p>Орчуулга, найруулга зассан</p> |
| <p>21.805. Таньж тогтоох мэдээлэл</p> <p>Энэ дүрмийн 21.803 (а)(1)-ийн дагуу өгөгдлийн пайзанд тэмдэглэхийг шаардсан таньж тогтоох мэдээлэл болон 21.803 (с)(1)-ийн дагуу сэнс, сэнсний алга, эсхүл сэнсний булыг таньж тогтоох мэдээлэл нь дараах өгөгдлийг багтаасан байх ёстой:</p> <p>(1) үйлдвэрлэгчийн нэр;</p> <p>(2) оноосон загвар;</p> <p>(3) үйлдвэрлэгчийн серийн дугаар;</p> <p>(4) хэрэв хамааралтай бол маягийн гэрчилгээ, эсхүл маягийг хүлээн зөвшөөрсөн гэрчилгээний дугаар;</p> <p>(5) хэрэв хамааралтай бол үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээний дугаар, эсхүл гадаадын дүйцэх дугаар;</p> <p>(6) агаарын хөлгийн хөдөлгүүрийн хувьд, тогтоогдсон хүчин чадал;</p> <p>(7) <u>Даргын</u> шаардаж болох бусад мэдээлэл.</p> | <p>21.805. Таних тэмдгийн мэдээлэл/ Identification information</p> <p>(а) Энэ дүрмийн 21.803 (а) 1/-д шаардсан таних пайзанд болон тус хэсгийн (в) 1/-д заасан сэнс, сэнсний алга эсхүл сэнс голны таних тэмдгийн мэдээлэлд дараах зүйлийг багтаасан байна:</p> <p>1/ үйлдвэрлэгчийн нэр;</p> <p>2/ загварын тодорхойлолт;</p> <p>3/ үйлдвэрийн серийн дугаар;</p> <p>4/ хэрэв шаардлагатай бол Маягийн гэрчилгээ болон Маягийг хүлээн зөвшөөрсөн гэрчилгээний дугаар;</p> <p>5/ хэрэв шаардлагатай бол үйлдвэрлэгч байгууллагын гэрчилгээний дугаар, эсхүл түүнтэй адилтгах хэмжээний гадаадын үйлдвэрлэгчийн дугаар;</p> <p>6/ агаарын хөлгийн хөдөлгүүрийн хувьд тогтоосон ангилал; болон</p> <p>7/ <u>ИНЕГ</u>-ын даргын шаардаж болох бусад мэдээлэл.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |
| <p>21.807. Таньж тогтоох мэдээллийг салгах, өөрчлөх болон солих</p> <p>(а) Энэ зүйлийн (б)-д зааснаас бусад тохиолдолд, аливаа этгээд нь <u>Даргын</u> зөвшөөрөлгүй дараах аль нэг мэдээллийг</p> | <p>21.807 Таних тэмдгийн мэдээллийг салгаж авах, өөрчлөх, солух/ Removal, alteration and replacement of identification information</p> <p>(а) Энэ зүйлийн (б)-д зааснаас бусад тохиолдолд <u>ИНЕГ</u>-ын даргын зөвшөөрөлгүй дараах зүйлийн таних тэмдгийн мэдээллийг</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |

| | | |
|--|--|--|
| <p>салгахгүй өөрчлөхгүй, эсхүл солихгүй:</p> <p>(1)21.803 (a)(1)-ийн дагуу, өгөгдлийн пайз дээр тэмдэглэсэн байхыг шаардсан таньж тогтоох мэдээлэл;</p> <p>(2)21.803 (c)(1)-ийн дагуу сэнс, сэнсний алга, эсхүл сэнсний булыг тодорхойлоход шаардлагатай таньж тогтоох мэдээлэл;</p> <p>(3)21.811-ийн дагуу, эрсдэлтэй эд ангийг таньж тогтооход шаардлагатай эд ангийн дугаар болон серийн дугаар.</p> <p>(b)Хэрэв салгалт, өөрчлөлт, эсхүл солилтыг Даргын хүлээн зөвшөөрөхүйц арга, техник, эсхүл практик аргачлалын дагуу гүйцэтгэдэг бол, ИНД-43-ын дагуу техник үйлчилгээ гүйцэтгэж байгаа этгээд нь энэ зүйлийн (a)(1) (a)(2)-т заасан таньж тогтоох мэдээлэл болон энэ зүйлийн (a)(3)-т заасан эд ангийн дугаар, серийн дугаарыг салгаж, өөрчилж, эсхүл сольж болно.</p> | <p>салгах, өөрчлөх, солихыг хориглоно:</p> <p>1/ 21.803 (a) 1/-д заасны дагуу бичилт хийгдсэн таних тэмдгийн мэдээлэл бүхий пайзыг;</p> <p>2/ 21.803 (b) 1/-д заасны дагуу бичилт хийгдсэн сэнс, сэнсний алга эсхүл сэнс голыг тодорхойлсон таних тэмдгийн мэдээлэл;</p> <p>3/ 21.811-д заасан онцгой эд ангийн таних тэмдэг болох үйлдвэрийн серийн дугаар болон эд ангийн дугаар.</p> <p>(б) ИНД-43-ын дагуу техник үйлчилгээг гүйцэтгэж буй этгээд нь ИНЕГ-ын даргын хүлээн зөвшөөрсөн техник, технологийн аргачлалаар салгах, өөрчлөх, солих ажиллагааг гүйцэтгэх тохиолдолд энэ хэсгийн (a) 1/, 2/-т заасан таних тэмдэг болон тус хэсгийн 3/-т заасан эд ангийн дугаар, серийн дугаарыг салгах, солих, өөрчлөхийг зөвшөөрнө.</p> | |
| <p>21.809. Өгөгдлийн пайзыг салгах болон дахин суурилуулах</p> <p>(a)Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд аливаа этгээд нь 21.805-д заасан таньж тогтоох мэдээллийг агуулсан өгөгдлийн пайзыг Даргын зөвшөөрөлгүй салгах, эсхүл дахин суурилуулахгүй.</p> <p>(b)ИНД-43-ын дагуу техник үйлчилгээ гүйцэтгэж байгаа этгээд нь дараах тохиолдолд 21.805-д заасан таньж тогтоох мэдээллийг агуулсан өгөгдлийн пайзыг салгаж эсхүл дахин суурилуулж болно, хэрэв:</p> <p>(1)техник үйлчилгээний үед өгөгдлийн пайзыг салгах шаардлагатай бол;</p> <p>(2)өгөгдлийн пайзыг Даргын хүлээн зөвшөөрөхүйц арга, техник практик аргачлалын дагуу салгадаг ба дахин суурилуулдаг бол;</p> <p>(3)салгасан өгөгдлийн пайзыг тухайн салгаж авсан бүтээгдэхүүн, эсхүл эд анги дээр буцаан суурилуулдаг бол.</p> | <p>21.809. Таних пайзыг салгах болон дахин суурилуулах/ Removal and reinstallation of data plate</p> <p>(a) Энэ зүйлийн (б)-д зааснаас бусад тохиолдолд ИНЕГ-ын Даргын зөвшөөрөлгүй 21.801-д заасан таних тэмдгийн мэдээлэл агуулсан таних пайзыг салгах болон дахин суурилуулахыг хориглоно.</p> <p>(б) ИНД-43-ийн дагуу техник үйлчилгээг гүйцэтгэж буй этгээд нь 21.805-д заасан таних тэмдгийн мэдээлэл агуулсан таних пайзыг дараах тохиолдолд салгах эсхүл дахин суурилуулж болно:</p> <p>1/ техник үйлчилгээний үед таних пайзыг салгах шаардлага гарсан;</p> <p>2/ таних пайзыг ИНЕГ-ын даргын хүлээн зөвшөөрсөн техник, технологийн аргачлалаар салгах эсхүл дахин суурилуулах;</p> <p>3/ салгаж авсан таних пайзыг өмнө нь байсан бүтээгдэхүүн, эд анги дээр дахин суурилуулах.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> |
| <p>21.811. Эрсдэлтэй эд ангийг таньж тогтоох</p> <p>Эрсдэлтэй эд ангийг үйлдвэрлэж байгаа этгээд нь тухайн эд ангид дараах мэдээллийг гаргацтай байнгын арилдаггүй байдлаар тэмдэглэнэ:</p> <p>(1)эд ангийн дугаар, эсхүл дүйцэх дугаар;</p> <p>(2)серийн дугаар, эсхүл дүйцэх дугаар.</p> | <p>21.811. Онцгой эд ангийн таних тэмдэг/ Identification of critical parts</p> <p>(a) Онцгой эд анги үйлдвэрлэгч аливаа этгээд нь дараах тэмдэг тэмдэглэгээг эд ангид тогтмол, уншиж болохуйц тодорхой байрлуулна:</p> <p>1/ эд ангийн дугаар, эсхүл түүнтэй адилтгах дугаар;</p> <p>2/ эд ангийн үйлдвэрийн серийн дугаар эсхүл адилтгах дугаар.</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-critical-“онцгой” гэснийг “эрсдэлтэй” гэж өөрчилсөн</p> |

21.813. Солилтын болон модификацийн материал, эд анги хэрэгслийг таньж тогтоох

(а)Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд К Бүлэгт шаардсан эрхийн хүрээнд солилтын, эсхүл модификацийн эд анги, эсхүл хэрэгсэл үйлдвэрлэж байгаа этгээд нь 21.805-д заасан таньж тогтоох мэдээллээс гадна, дараах мэдээллийг тухайн эд анги, эсхүл хэрэгсэлд гаргацтай, байнгын арилдаггүй байдлаар тэмдэглэнэ:

- (1)“Mongolian TSO”, эсхүл “Mongolian PMA” бичилтийн аль тохирохыг;
- (2)эрх эзэмшигчийн нэр, барааны тэмдэг, эсхүл бэлгэдэл;
- (3)эд ангийн дугаар;
- (4)эд ангид суурилуулахад тохиромжтой, маягийн гэрчилгээ, эсхүл маягийг хүлээн зөвшөөрсөн гэрчилгээ олгосон бүтээгдэхүүний нэр, оноосон загвар.

(b)Энэ дүрмийн 21.303(2)-ын дагуу солилтын, эсхүл модификацийн материал, эд анги, эсхүл хэрэгсэл үйлдвэрлэж байгаа этгээд нь тухайн материал, эд анги, эсхүл хэрэгслийг гаргацтай, байнгын арилдаггүй байдлаар, дараах шаардлагыг бататгах хэлбэрээр тэмдэглэнэ:

- (1)өөрөөр хүлээн зөвшөөрөхүйц материал, эд анги болон хэрэгслээс тусдаа танигддаг байх;
- (2)үйлдвэрлэлийн өгөгдөлтэйгээ шууд хамааралтай байх.

(c)Хэрэв материал, эд анги, эсхүл хэрэгсэл нь энэ зүйлийн (а), эсхүл (b)-д шаардсан мэдээллийг тэмдэглэхэд хэтэрхий жижиг, эсхүл өөр хэлбэрээр тэмдэглэх боломжгүй бол, тухайн мэдээллийг материал, эд анги, хэрэгслийн хавсаргасан шошгонд, эсхүл түүний контейнер дээр бичнэ.

(d)Энэ зүйлийн (а)(4)-т шаардсан тэмдэглэгээг шошгон дээр бичих боломжгүй урт бол, тухайн материал, эд анги, эсхүл хэрэгслийг суурилуулахад зориулсан, маягийн гэрчилгээ, эсхүл маягийг хүлээн зөвшөөрсөн гэрчилгээ олгосон бүтээгдэхүүний нэр болон оноосон загварын ашиглахад бэлэн заавар, эсхүл каталогт тухайн материал, эд анги, хэрэгсэл, эсхүл контейнерт хавсаргасан шошгыг иш татаж болно.

Хавсралт А-Хамааралгүй

Хавсралт В-Нөөц

Хавсралт С-НТЧ-ын загварын стандарт

21.813. Солих, өөрчлөх эд анги, материал, нэмэлт тоног төхөөрөмжийн танух тэмдэг/ Identification of replacement and modification materials, parts, and appliances

(а) Энэ зүйлийн (б)-д зааснаас бусад тохиолдолд бүлэг Ж-ийн дагуу солих эсхүл өөрчлөх эд анги, нэмэлт тоног төхөөрөмжийг үйлдвэрлэгч этгээд нь 21.805-д тодорхойлсон таних тэмдгийн мэдээллээс гадна дараах бичилтийг эд анги, нэмэлт тоног төхөөрөмжид тодорхой бөгөөд тогтмол хийж байрлуулна:

- 1/ техникийн стандарт “TSO”, эсхүл үйлдвэрлэлийн баталгаат зөвшөөрөл “PMA” гэсэн товчилсон бичилт;
- 2/ зөвшөөрөл эзэмшигчийн нэр, үйлдвэрийн тэмдэг, бэлэгдэл;
- 3/ эд ангийн дугаар;
- 4/ Маягийн гэрчилгээ, эсхүл Маягийг хүлээн зөвшөөрсөн гэрчилгээ олгогдсон бүтээгдэхүүн нэг бүрийн нэр, загварын тодорхойлолт.

(б) Энэ дүрмийн 21.304 2/-ын дагуу солих, өөрчлөх материал, эд анги, нэмэлт тоног төхөөрөмжийг үйлдвэрлэгч этгээд нь материал, эд анги, нэмэлт тоног төхөөрөмжид уншиж болохуйц, тогтмол тэмдэглэгээ хийх аргаар дараах зүйлийг бататгана:

- 1/ бусад зөвшөөрөгдсөн материал, эд анги, нэмэлт тоног төхөөрөмжөөс ангид ялгагдаж буйг;
- 2/ үйлдвэрлэлтэй холбоотой үзүүлэлт нь тодорхой байгаа эсэхийг.

(в) Хэрэв материал, эд анги, нэмэлт тоног төхөөрөмж нь энэ зүйлийн (а) болон (б)-д шаардсан мэдээллийг тэмдэглэх боломжгүй хэтэрхий жижиг хэмжээтэй бол мэдээллийг шошгон дээр бичиж материал, эд анги, нэмэлт тоног төхөөрөмжид болон тэдгээрийг савлах хайрцагт зүүж өгнө.

(г) Энэ зүйлийн (а) 4/-т заасан тэмдэг тэмдэглэгээ нь материал, эд анги, нэмэлт тоног төхөөрөмжид зүүх шошгонд багтахгүй бол Маягийн гэрчилгээ, эсхүл Маягийг хүлээн зөвшөөрсөн гэрчилгээ олгогдсон бүтээгдэхүүн нэг бүрийн нэр, загварыг тодорхойлох заавар болон каталог гаргана.

-Орчуулга,
найруулга зассан

ХАВСРАЛТ А. НӨӨЦ/ RESERVED

ХАВСРАЛТ Б. НӨӨЦ/ RESERVED

**ХАВСРАЛТ В. ЗАГВАРЫН НТЧ-ЫН СТАНДАРТ/
AIRWORTHINESS DESIGN STANDARDS**

(а) Монгол Улсад ашиглагдаж буй агаарын хөлгийн НТЧ-ын

- (a) Энэ зүйлийн (c)-г харгалзан, стандарт категорийн НТЧ-ын загварын стандарт нь дараах баримт бичгээс бүрдэнэ:
- (1) АНУ-ын FAA-аас гаргасан Холбооны нисэхийн дараах дүрэм:
- (i) Part 23 НТЧ-ын Стандарт: Ердийн, Өргөн хэрэглээний, Аэробатик болон Компьютер категорийн нисэх онгоц, 23.785(a) болон 23.807(b)(5)-аас бусад;
 - (ii) Part 25 НТЧ-ын Стандарт: Тээврийн категорийн нисэх онгоц;
 - (iii) Part 27 НТЧ-ын Стандарт: Ердийн категорийн роторт-хөлөг;
 - (iv) Part 29 НТЧ-ын Стандарт: Тээврийн категорийн роторт-хөлөг;
 - (v) Part 31 НТЧ-ын Стандарт: Хүнтэй чөлөөт бөмбөлөг;
 - (vi) Part 33 НТЧ-ын Стандарт: Агаарын хөлгийн хөдөлгүүр;
 - (vii) Part 35 НТЧ-ын Стандарт: Сэнс; эсхүл
- (2) Даргын тодорхойлсон, дараах НТЧ-ын загварын стандартын багц:
- (i) ICAO-гийн Хавсралт 8-ын шаардлагыг хангасан;
 - (ii) энэ зүйлийн (a)(1)-д заасан НТЧ-ын загварын стандарттай дүйцэх аюулгүй байдлын түвшнийг хангасан.
- (b) Энэ зүйлийн (c)-г харгалзан, хязгаарлалттай категорийн НТЧ-ын загварын стандарт нь:
- (1) тухайн агаарын хөлгийг ашиглах зорилгод тохирохгүй гэж Даргын тодорхойлсон шаардлагаас бусад, энэ зүйлийн (a)-д заасан загварын стандарт болон энэ зүйлийн (d), (e)-д заасан холбогдох стандарт; эсхүл
- (2) тухайн агаарын хөлгийг ашиглах зорилгод тохирно гэж Даргын тодорхойлсон НТЧ-ын загварын стандартын багц байна.
- (c) Стандарт категори , эсхүл хязгаарлалттай категорийн агаарын хөлгийн НТЧ-ын загварын стандарт нь дараах мэдээллийг агуулсан нислэгийн заавартай байх ёстой:
- (1) заавар, тэмдэглэгээ, эсхүл зурагт хуудас хэлбэртэй хамааралтай НТЧ-ын загварын стандартаар хангахыг

- маягийн стандартын хувьд тухайн агаарын хөлгийг зохион бүтээх, үйлдвэрлэх үед үйлдвэрлэгч орны Иргэний нисэхийн удирдах газрын мөрдөж байсан НТЧ-ын маягийн стандарт болон түүнтэй адилтгах хэм хэмжээ, тэдгээрт орсон нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч мөрдөнө.
- (б) Стандарт ангиллын загварын НТЧ-ын стандартуудын хувьд:
- 1/ АНУ-ын Холбооны нисэхийн алба /FAA/-наас гаргасан дараах дүрмийг хүлээн зөвшөөрнө.
- 1.1. агаарын хөлөгт:
- Part 23 Airworthiness Standards: Normal, Utility and Acrobatic Category Airplanes (тус дүрмийн 23.785(a) болон 23.807(b)(5)-аас бусад);
 - Part 25 Airworthiness Standards: Transport Category Airplanes;
 - Part 27 Airworthiness Standards: Normal Category Rotorcraft;
 - Part 29 Airworthiness Standards: Transport Category Rotorcraft.
- 1.2. агаарын хөлгийн хөдөлгүүр сэнсэнд:
- Part 33 Airworthiness Standards: Aircraft Engines;
 - Part 35 Airworthiness Standards: Propellers.
- 1.3. эд анги, тоног төхөөрөмжийн хувьд:
- АНУ-ын Холбооны нисэхийн алба (FAA)-наас гаргасан техникийн стандарт (TSO)-ыг мөрдөнө. эсхүл;
- 2/ ИНЕГ-ын даргын тодорхойлсон загварын НТЧ-ын дараах стандартуудыг хүлээн зөвшөөрнө:
- 2.1. Чикагогийн конвенцийн Хавсралт 8-ыг хангасан; болон
- 2.2. энэ зүйлийн (б) 1/-д тодорхойлсон загварын НТЧ-ын стандарттай ижил хэмжээний аюулгүй ажиллагааны түвшинг хангасан.
- (в) Хязгаарлагдмал ангиллын загварын НТЧ-ын стандартын хувьд дараах шаардлагуудыг дагаж мөрдөнө:
- 1/ энэ зүйлийн (б), (д) болон (е)-д тодорхойлсон загварын стандартуудаас гадна агаарын хөлгийн ашиглалтын зорилгод нийцэхгүй гэж үзсэн ИНЕГ-ын даргын тогтоосон шаардлагууд; эсхүл,
- 2/ агаарын хөлгийн ашиглалтын зорилгод нийцүүлэн ИНЕГ-ын дарга тогтоосон загварын НТЧ-ын стандартууд.
- (г) Стандарт эсхүл хязгаарлагдмал ангиллын агаарын хөлгийн нислэгийн зааварт дараах зүйлийг багтаасан байна:
- 1/ загварын НТЧ-ын стандарт шаардлагын дагуу заавар, тэмдэглэл, зурагт хуудас хэлбэрээр хийгдсэн мэдээлэл, ашиглалтын хязгаарлалт болон агаарын хөлгийн аюулгүй ажиллагааг хангахад зориулагдсан бусад нэмэлт

-Орчуулга,
найруулга зассан

-Орчуулга,
найруулга зассан

| | | |
|--|--|---|
| <p>шаардсан үйл ажиллагааны хязгаарлалт болон мэдээлэл;</p> <p>(2) нисэх онгоц, <u>роторт-хөлгийн</u> хувьд, тухайн нислэгийн зааврын техникийн үзүүлэлтийн мэдээллийн хэсэгт заасан хөдөлгүүрийн хөргөлтийг туршсан гадна орчны агаарын максимум хэм;</p> <p>(3) <u>21.32-ын дагуу шаардсан гэрчилгээ, эсхүл тухайн нислэгийн зааврын хуудас хэлбэртэй мэдээлэл.</u></p> <p>(d) Стандарт <u>категорийн</u> агаарын хөлгийн дуу чимээний стандарт нь:</p> <p>(1) дараахаас бусад тохиолдолд, ICAO-гийн Хавсралт 16, Vol.I-ийн холбогдох бүлэгт заасан стандарт байна:</p> <p>(i) 2003 оны 6 сарын 30-наас хойш, дууны хурдны өмнөх (subsonic) хурдтай турбо-жет, турбо-фэн хөдөлгүүртэй нисэх онгоц нь Хавсралт 16, Vol.I, Chapter.3-т заасан стандартыг хангасан байх ёстой;</p> <p>(ii) хэрэв тухайн агаарын хөлгийн маягийн гэрчилгээ, дуу чимээний гэрчилгээ, эсхүл дүйцэх баримт бичигт илүү өндөр стандартыг заасан бол, түүнийг мөрдөх; эсхүл</p> <p>(2) <u>Даргын</u> хүлээн зөвшөөрөхүйц дүйцэх НТЧ-ын загварын стандартын багц.</p> <p>(e) Стандарт <u>категорийн</u> агаарын хөлгийн хөдөлгүүрийн хийн ялгаруулалтын стандарт нь:</p> <p>(1) ICAO-гийн Хавсралт 16, Vol.II-ийн холбогдох Бүлэгт заасан стандарт; эсхүл</p> <p>(2) <u>Даргын</u> хүлээн зөвшөөрөхүйц дүйцэх НТЧ-ын загварын стандартын багц.</p> | <p>зааварчилгааг,</p> <p>2/ онгоц, <u>нисдэг тэрэгний</u> хувьд, нислэгийн зааврын үзүүлэлт /performance/- ийн мэдээллийн хэсэгт хүрээлэн буй орчны агаарын хамгийн их температурын үед хөдөлгүүрийн хөргөлтийн чадавхийг харуулсан график.</p> <p>(д) Стандарт ангиллын агаарын хөлгийн дуу чимээний стандартын хувьд:</p> <p>1/ 2010 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс хойш Чикагогийн конвенцийн Хавсралт 16-д тодорхойлсон дараах шаардлагуудыг дагаж мөрдөнө:</p> <p>1.1. Тийрэлтэт хөдөлгүүрээр тоноглогдсон онгоцнууд нь Нэгдүгээр дэвтрийн II-р хэсгийн бүлэг 3 болон 4-ийн холбогдох стандартуудыг;</p> <p>1.2. сэнст хөдөлгүүрээр тоноглогдсон онгоцнууд нь Нэгдүгээр дэвтрийн II хэсгийн бүлэг 3, 4, 5, 6 болон 10-ын холбогдох стандартуудыг;</p> <p>1.3. <u>нисдэг тэрэгний</u> хувьд Нэгдүгээр дэвтрийн II хэсгийн бүлэг 8 болон 11-ийн холбогдох стандартуудыг;</p> <p>1.4. хэрэв агаарын хөлгийн маягийн гэрчилгээ болон дуу чимээний гэрчилгээнд эсхүл түүнтэй адилтгах баримт бичигт илүү өндөр стандарт тогтоосон бол тэдгээрийг дагаж мөрдөх; эсхүл</p> <p>2/ <u>ИНЕГ</u>-ын даргын хүлээн зөвшөөрсөн адилтгах хэмжээний загварын НТЧ-ын стандартыг мөрдөнө.</p> <p>(e) Стандарт ангиллын агаарын хөлгийн хөдөлгүүрээс гарах хийн ялгаруулалтад тавигдах стандартын хувьд:</p> <p>1/ Чикагогийн конвенцийн Хавсралт 16-ийн Хоёрдугаар дэвтэрт тодорхойлсон шаардлагуудыг дагаж мөрдөнө; эсхүл</p> <p>2/ <u>ИНЕГ</u>-ын даргын хүлээн зөвшөөрсөн адилтгах хэмжээний загварын НТЧ-ын стандартыг мөрдөнө.</p> | |
| <p>Хавсралт D - Хүлээн зөвшөөрөхүйц техникийн өгөгдөл</p> <p>(a) Энэ зүйлийн (b)-г харгалзан, дараах өгөгдөл нь хүлээн зөвшөөрөхүйц техникийн өгөгдөл болно.</p> <p>(1) маягийн гэрчилгээний өгөгдлийн хуудас (TCDS);</p> <p>(2) маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээ олгоход ашиглагдах гадаадын маягийн гэрчилгээний өгөгдлийн хуудас;</p> <p>(3) маягаар гэрчилгээжсэн бүтээгдэхүүний маягийн загварын</p> | <p>ХАВСРАЛТ Г. <u>ИНЕГ</u>-ААС ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ/ ACCEPTABLE TECHNICAL DATA</p> <p>(a) Энэ зүйлийн (б)-ийн нөхцөлд дараах техникийн үзүүлэлтийг <u>ИНЕГ</u>-аас хүлээн зөвшөөрнө:</p> <p>1/ Маягийн гэрчилгээний техникийн үзүүлэлтийн хуудасны (TCDS);</p> <p>2/ Маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээ олгоход үндэслэсэн гадаадын Маягийн гэрчилгээний техникийн үзүүлэлтийн хуудас;</p> <p>3/ Маягийн гэрчилгээтэй бүтээгдэхүүний маягийн загварын</p> | <p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-2009 онд Amend 8-аар нэмэгдсэн</p> |

өгөгдөл;

(4) 21.73-т заасан аргаар зөвшөөрөгдсөн загварын өөрчлөлтөд тулгуурласан загварын өөрчлөлтийн өгөгдөл;

(5) 21.505-ын дагуу [Даргын](#) зөвшөөрсөн өгөгдөл;

(6) [Даргын](#), Зөвлөмжийн Цувралаар (AC) гаргасан өгөгдөл;

(7) засвар, эсхүл [модификацийн](#) тусгай зааварчилгаа өгдөг НТЧ-ын удирдамж;

(8) дараах байгууллагаас олгосон нэмэлт маягийн гэрчилгээ:

(i) АНУ-ын FAA;

(ii) Оросын холбооны улсын ФАС;

(iii) Европын холбооны EASA;

(9) хамааралгүй;

(10) бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн хангасан, маягийн гэрчилгээнд заасан, эсхүл маягийг хүлээн зөвшөөрсөн гэрчилгээнд тухайн бүтээгдэхүүнд ашиглахаар иш татсан дүйцэх эсхүл, техник үйлчилгээний заавар, засварын болон их засварын заавар, НТЧ-ын хадгалалтын зааварчилгаа, сервис бюллетень (SB)-д модификаци, эсхүл засвар хийх тусгай зааварчилгаа заасан өгөгдөл;

(11) АНУ-ын FAA-аас гаргасан зөвлөмжийн цуврал AC43.13-1B;

(12) тухайн НТЧ-ын гэрчилгээний категорид тусгайлан хамаарсан болон түүнд багтсан өгөгдөл.

(b) Энэ зүйлийн (a)-д заасан техникийн өгөгдөл нь дараах тохиолдолд хүлээн зөвшөөрөгдөхүйц байна, хэрэв:

(1) өгөгдөл нь тухайн бүтээгдэхүүн, бүрдэл хэсэг, эсхүл хэрэгсэлд тохирсон ба хийгдэж байгаа ажилд шууд холбоотой бол;

(2) гадаадын нэмэлт маягийн гэрчилгээ, эсхүл нэмэлт маягийн зөвшөөрлийн хувьд:

(i) шинэ нислэгийн зааврын иж бүрдэл ашиглаагүй бол;

(ii) тухайн агаарын хөлгийн маягийг дахин тогтоогоогүй бол;

(iii) өгөгдөл нь [Даргын](#) хүлээн зөвшөөрсөн тодорхой маягийн гэрчилгээний нэмэлт ба тухайн маягийн гэрчилгээг нэмэлт маягийн гэрчилгээ, эсхүл нэмэлт

техникийн үзүүлэлт;

4/ энэ дүрмийн 21.73-т тодорхойлсон аргачлалаар загварын өөрчлөлтийг баталгаажуулсан загварын өөрчлөлтийн техникийн үзүүлэлт;

5/ энэ дүрмийн 21.505-ийн дагуу [ИНЕГ](#)-ын даргын баталсан техникийн үзүүлэлт;

6/ [ИНЕГ](#)-ын даргын гаргасан Зөвлөмжийн цуврал (AC)-д тусгагдсан техникийн үзүүлэлт;

7/ засвар, [өөрчлөлт](#) хийх тусгай зааварчилгааг агуулсан НТЧ-ын удирдамж (AD);

8/ дараах улсаас олгосон нэмэлт маягийн гэрчилгээг:

8.1. АНУ-ын Холбооны нисэхийн алба /FAA/-наас олгосон;

8.2. Европын Иргэний нисэхийн аюулгүй байдлын агентлаг /EASA/-аас олгосон;

8.3. [Канад улсын тээврийн яам \(Transport Canada\) -аас олгосон;](#)

[8.4. Улс хоорондын нисэхийн зөвлөл \(МАК\)-өөс олгосон;](#)

9/ ОХУ-ын Холбооны иргэний нисэхийн удирдах газраас баталсан бүтээгдэхүүний маягийн техникийн үзүүлэлт;

10/ Маягийн гэрчилгээ, Маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээнд тусгагдсан эсхүл тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэгчийн их засварын заавар, НТЧ-ын хадгалалтын баримт бичиг, бюллетень, техник үйлчилгээний засварын заавар ба өөрчлөлт хийх зааварчилгаа зэрэгт тодорхойлогдсон болон бусад адилтгах хэмжээний техникийн үзүүлэлт;

11/ АНУ-ын Холбооны нисэхийн алба (FAA)-наас гаргасан AC-43.13-1A тоот зөвлөмж баримт бичиг;

12/ НТЧ-ын гэрчилгээний ангиллыг тодорхойлсон болон багтаасан техникийн үзүүлэлт.

(б) Энэ зүйлийн (a)-д заасан техникийн үзүүлэлт нь дараах тохиолдолд хүлээн зөвшөөрөгдөнө:

1/ үзүүлэлт нь тухайн эд анги, тоног төхөөрөмж болон бүтээгдэхүүнд тохирсон бөгөөд холбогдох ажлыг гүйцэтгэхэд шууд хамааралтай бол;

2/ гадаадын нэмэлт маягийн гэрчилгээ, эсхүл нэмэлт маягийн баталгаажуулалтын хувьд:

2.1 шинээр гарсан ашиглалтад ороогүй байгаа нислэгийн заавар;

2.2 агаарын хөлгийн маягийг дахин тодорхойлоогүй үеийн

маягийн зөвшөөрөлд иш татсан бол;

- (3) тухайн суурилуулагч нь, нэмэлт маягийн гэрчилгээ, эсхүл нэмэлт маягийн зөвшөөрөл эзэмшигчээс STC суурилуулах бичгээр үйлдсэн зөвшөөрөлтэй бол;
- (4) бүрдэл хэсэг үйлдвэрлэгчийн гаргасан өгөгдөл нь тухайн эд ангийг бүрдүүлдэг бүрдэл хэсгийн бүтээгдэхүүн, эсхүл иж бүрдэл үйлдвэрлэгчийн гаргасан өгөгдөлтэй зөрчилдөөгүй бол.

Хавсралт Е - Туршин нисгэгч (шилжилт)

Дараахаас бусад тохиолдолд, аливаа этгээд нь агаарын хөлгийн маягийн анхны загварыг шалгах, эсхүл агаарын хөлгийг туршин нисэх зорилгоор туршин нисгэгчийн үүрэг гүйцэтгэхгүй:

- (1) тухайн этгээд нь ИНД-61-ийн дагуу олгосон хүчинтэй нисгэгчийн үнэмлэх, эсхүл баталгаажуулсан зөвшөөрөл эзэмшдэг ба төлөвлөж байгаа маягийн анхны загварыг шалгах, эсхүл туршин нисэх зорилгоор туршин нисгэгчийн үүрэг гүйцэтгэхийг Дарга зөвшөөрсөн бол; эсхүл
- (2) агаарын хөлөг нь хэт хөнгөн агаарын хөлөг бөгөөд тухайн этгээд нь үйл ажиллагаа гүйцэтгэх зорилгоор хэт хөнгөн агаарын хөлгийн байгууллагаас зөвшөөрөгдсөн байх, хэрэв ИНД-149-ийн гэрчилгээ нь түүнийг эзэмшигчид маягийн анхны загварыг шалгах, эсхүл туршин нисэхийг тухайн туршин нисгэгчид зөвшөөрөх эрх олгодог бол; эсхүл
- (3) агаарын хөлөг нь глайдер бөгөөд тухайн этгээд нь үйл ажиллагаа гүйцэтгэх зорилгоор глайдерын байгууллагаас зөвшөөрөгдсөн байх, хэрэв ИНД-149-ийн гэрчилгээ нь түүнийг эзэмшигчид маягийн анхны загварыг шалгах, эсхүл туршин нисэхийг тухайн туршин нисгэгчид зөвшөөрөх эрх олгодог бол.

тодорхойлолт;

- 2.3 нэмэлт маягийн гэрчилгээ эсхүл нэмэлт маягийн баталгаажуулалтад тусгагдсан **ИНЕГ**-ын даргын хүлээн зөвшөөрсөн маягийн гэрчилгээний нэмэлт үзүүлэлтүүд; болон
- 3/ нэмэлт маягийн гэрчилгээ эзэмшигчээс зохих зөвшөөрөл олгогдсон эрх бүхий суурилуулагч этгээд бол;
- 4/ агаарын хөлгийн бүрэлдэхүүн хэсгийн үйлдвэрлэгчээс гаргасан техникийн үзүүлэлт нь тухайн бүрэлдэхүүн хэсгийн эд анги, бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн техникийн үзүүлэлттэй зөрчилдөхгүй бол.

- Part 19-өөс
шилжүүлсэн

Дүрмийн боловсруулалтын хэлтэс